

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 11
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	12 – 97
1.	<i>Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх эсэх тухай асуудал</i>	13 – 16
2.	<i>Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	16 – 50
3.	<i>Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	50 – 68
4.	<i>Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	69 – 82
5.	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	83 – 95
6.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i>	95 – 97

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 05 дугаар сарын 20-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 00 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Туваан;

Чөлөөтэй: Л.Мөнхбаатар, Н.Учрал, О.Цогтгэрэл, Ө.Шижир;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Одбаяр;

Тасалсан: Д.Амарбаясгалан, Б.Батбаатар, А.Ганбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д "Энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ." гэж заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл тус бүрээр санал хураалт явуулав.

Б.Баярбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 10

Бүгд: 18

44.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нарагийн 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 11

Бүгд: 18

38.9 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 6

Бүгд: 18

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 5

Бүгд: 18

72.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын Хурлын гишүүн Д.Батбаяр нарын 6 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 9
Бүгд: 18
50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүнээс 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 7
Бүгд: 18
61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатарын 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 8
Бүгд: 18
55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 14 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Б.Энхбаяр, Б.Хэрлэн, Л.Гантөмөр, О.Алтангэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Б.Энхбаяр, С.Зулпхар, Ж.Батжаргал, О.Алтангэрэл, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Б.Баярбаатар: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 7
Бүгд: 21
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан 15 цаг 30 минутаас хуралдааныг даргалав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Л.Гантөмөр, Д.Энхтуяа нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ч.Лодойсамбуу нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн үг хэлэв.

Б.Жавхлан: 1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Л.Гантөмөр нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ж.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Б.Жавхлан: 1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13

Татгалзсан: 8

Бүгд: 21

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14

Татгалзсан: 7

Бүгд: 21

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүн 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийн газрын дарга С.Чинбат, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газрын дарга Н.Наранцэцэг, Гадаад харилцааны яамны Консулын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Биндэръяа, Консулын газрын зөвлөх О.Эрдэнэсамбуу нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газрын дарга Н.Наранцэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр уг асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулъя гэсэн горимын санал гаргав.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 11
Бүгд: 21
47.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Л.Гантөмөр, Д.Бум-Очир нар үг хэлэв.

Б.Жавхлан: 1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 11
Бүгд: 21
47.6 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

2.Хамт өргөн мэдүүлсэн Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганаар оруулж хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл /Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Жавхлан Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Б.Жавхлан: “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 9
Бүгд: 21
57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 17 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 30 минут үргэлжилж, 32 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 65.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 00 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа гишүүн ирсэн байна,
Ж.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна.
Ж.Батжаргал гишүүн ирсэн байна.
Б.Баярбаатар гишүүн ирсэн байна,
Ж.Баярмаа гишүүн ирсэн байна.
Э.Болормаа гишүүн ирсэн байна.
С.Бямбацогт гишүүн ирсэн байна.
Л.Гантөмөр гишүүн ирсэн байна.
Ц.Даваасүрэн гишүүн ирсэн байна.
Т.Доржханд гишүүн ирсэн байна.
Б.Жавхлан гишүүн ирсэн байна.
С.Зулпхар гишүүн ирсэн байна.
Ч.Лодойсамбуу гишүүн ирсэн байна.
Ч.Ундром гишүүн ирсэн байна.
Б.Хэрлэн гишүүн ирсэн байна.
Б.Чойжилсүрэн гишүүн ирсэн байна.

Б.Энхбаяр гишүүн ирснээр 53.1 хувьтай ирц хүрсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Та бүхэнд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулъя.

- Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх эсэх тухай асуудал.
- Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын

Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг.

- Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- Дөрөв.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- Тав.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх.
- Бусад асуудал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар
хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг
чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх эсэх
тухай асуудал**

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх эсэх тухай асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт "энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ" гэж заасан.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл тус бүрээр санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Санал хураалтад 9 гишүүн бэлдсэн байна. Л.Гантөмөр гишүүн санал хураалтдаа бэлтгэе. С.Зулпхар гишүүн, Н.Номтойбаяр гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалт.

1.Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар 2026 оны 5 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 8 гишүүн оролцож, 44.4 хувийн саналаар уг санал дэмжигдсэнгүй. /алх цохив/

2.Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара 2026 оны 5 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 7 гишүүн дэмжиж, 38.9 хувиар санал дэмжигдсэнгүй. /алх цохив/

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

4.Улсын Их Хурлын Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 12 гишүүн оролцож, 66.7 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

5.Улсын Их Хурлын Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 13 гишүүн дэмжиж, 72.2 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

6.Монгол Улсын Хурлын гишүүн Д.Батбаяр нарын 6 гишүүн 2026 оны 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

9 гишүүн дэмжсэн санал өгч, уг санал дэмжигдсэнгүй уналаа. /алх цохив/

7.Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүн 2026 оны 5 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

8.Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 7 гишүүн 2026 оны 5 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн дэмжиж, 61.1 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

9.Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар 2026 оны 5 сарын 15-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 10 гишүүн дэмжиж, 55.6 хувиар санал дэмжигдлээ. /алх цохив/

Дараагийн асуудалдаа орно.

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн
2026 оны 05 дугаар 13-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Хоёр.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэхийн хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгална" гэж, 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно" гэж, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурал үйл ажиллагааны зохих салбар чиглэлээр Байнгын хороотой байна" гэж, мөн хуулийн 2 дугаар хэсэгт "Байнгын хороо болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно" гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу сонгуулийн холимог тогтолцоогоор сонгож байгуулагдсан 126 гишүүний бүрэлдэхүүнтэй Улсын Их Хурлын бүрэн эрх 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Анхдугаар чуулганаа хийж тангараг өргөснөөр хэрэгжиж эхэлсэн.

Энэ удаагийн парламентын бүрэн эрх хэрэгжиж эхэлснээс хойш 4 дэх ээлжит чуулган хуралдаж байгаа бөгөөд ээлжит бус нэг чуулганыг хуралдуулсан байна.

Ес дэх парламентын бүрэн эрх хэрэгжиж эхэлснээс хойш 2 жилийн хугацаанд төсөл өргөн мэдүүлсэн өдөр хүртэл нийт 131 хууль, Улсын Их Хурлын 169 дүгээр тогтоол баталсан нь өмнөх бүрэн эрхийн хугацаанд баталсан хуулийн 8, 9 хувьтай дүйцэхээр байна.

Түүнчлэн 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс Улсын Их Хурлын үйл ажиллагааг 8 байнгын хороо, 15 дэд хороотой байхаар зохион байгуулсан.

Ийнхүү зохион байгуулснаас хойш 2025 оны намрын ээлжит чуулганы хуралдаанд 5 дэд хороо 1-ээс 2 удаа, 2026 оны хаврын ээлжит чуулганы чуулган эхэлснээс хойш 5 дэд хороо 1-ээс 4 удаа тус тус хуралдсан бол 10 дэд хороо хуралдаагүй байна.

Түүнчлэн 2024 оноос өнөөдрийг хүртэл ирц бүрдээгүйн улмаас Байнгын хорооны хуралдаан 38 удаа, ирц бүрдсэн ч бусад шалтгаанаар 19 удаа, нийт 57 удаагийн хурлаар хойшилсон.

Нөгөө талаас Улсын Их Хурлын ёс зүйн асуудалтай холбогдуулан 2026 оны намрын ээлжит чуулганы хуралдааны Ёс зүйн дэд хороонд 7 гомдол, 2026 оны 1 дүгээр улиралд Ёс зүйн дэд хороонд 52 гомдол ирсэн тоон мэдээ гарсан байна.

Иймд хууль санаачлагч бидний 12 гишүүн Улсын Их Хурлын гишүүдийн чуулганы хуралдааны ирц, санал хураалтад оролцуулж буй байдал, парламентын хэлэлцэж буй асуудлаарх улс төрийн зөвшилцлийг хангах, гишүүний ёс зүйн асуудал, Улсын Их Хурлын үйл ажиллагааны үр нөлөөтэй байдалд онцгой анхаарч, Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээлгэсэн онцгой бүрэн эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэх бодит хэрэгцээ шаардлага үүссэн бөгөөд энэ нь иргэдийн төрд итгэх итгэл, парламентын нэр хүндэд шууд нөлөөлж байна гэж дүгнэлээ.

Үүний хүрээнд Улсын Их Хурлын зохион байгуулалтыг оновчлох, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гишүүдийн ирц, оролцоо, хариуцлагыг сайжруулах, Улсын Их Хурлын үйл ажиллагааны бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээмжтэй ажиллаж буй гишүүдийг дэмжих, хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийг чанаржуулах, мэргэшсэн Байнгын хороодод түшиглэсэн парламентыг бэхжүүлэх зорилгоор миний бие Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл, Ж.Батжаргал, Б.Бейсен, Ч.Лодойсамбуу, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, Ц.Сандаг-Очир, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн нарын 12 гишүүний хамтаар Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хамт өргөн мэдүүлсэн төслийг боловсруулж, 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Хуулийн төсөл хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн нийт заалтын 40.1 хувь буюу 263 заалтыг хөндсөн бөгөөд төслийн гол зохицуулалтыг багцлан танилцуулъя. Үүнд:

Нэг. Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтыг оновчлох хүрээнд.

Улсын Их Хурлын зохион байгуулалтыг Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Өргөдлийн, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүй, хүний эрхийн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, Цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын, Эдийн засаг, Эрүүл мэнд, нийгмийн бодлогын гэсэн 11 Байнгын хороотой байхаар боловсруулж, эрхлэх асуудлыг хуваариллаа.

Байнгын хороонд харьяанд ажиллах дэд хороодын эрхлэх асуудлын ялгаа заагийг тогтоож, Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар Тусгай хяналтын, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын, Ёс зүйн, Төсвийн зардлын хяналтын, Хууль сахиулах ажиллагааны тухай, Хяналтын, Тусгай хяналтын, Хүний эрхийн, Тогтвортой хөгжлийн зорилтын нийт 7 дэд хороотой байхаар төсөл боловсруулж, дэд хороодын тоог 8-аар цөөлөв.

Байнгын хороог 11 болгосонтой холбогдуулан Байнгын хорооны бүрэлдэхүүнийг хуульд нийцүүлэн нэг Байнгын хороо 21 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар тогтоож, асуудал хариуцсан сайд нь холбогдох Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох асуудлыг нээлттэй үлдээлээ.

Байнгын хорооны дарга нар хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд нэгдсэн хуралдаанд заавал оролцож, Байнгын хорооны эрхлэх асуудалтай холбоотой гишүүдийн асуултад хариулах үүрэгжүүлсэн зохицуулалт тусгалаа.

Хоёр. Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг сайжруулах, саналаа биечлэн өгөх үүрэг бий болгох, бүтээмж нэмэгдүүлэх, гишүүдийн бодит оролцоонд үндэслэн хариуцлага ба итгэлийн механизм бүрдүүлэх хүрээнд.

Ээлжит чуулганы хугацаанд гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал, чуулганы хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн тоо, дотоод, гадаад албан томилолт, хууль тогтоомжийн төсөл санаачилсан, хамтран санаачилсан, ажлын хэсэг ахалсан, бүрэлдэхүүнд нь ажилласан, хянан шалгах үйл ажиллагаанд оролцсон байдал болон хууль тогтоомжийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй санал, энэ хуульд заасан хариуцлага хүлээх эсэх талаарх мэдээллийг бодит цагийн горимоор олон нийтэд ил тод тогтмол мэдээлэх зохицуулалт тусгаж, уг бодит оролцоог үндэслэн гишүүнийг хүссэн Байнгын хорооны бүрэлдэхүүнд оруулах, Байнгын, дэд хорооны даргаар сонгох зэрэг үр нөлөөтэй ажиллаж байгаа гишүүнд итгэл үзүүлэн дэмжих.

Нөгөө талаас ирц, санал хураалтад биечлэн оролцсон талаарх бодит мэдээллийг үндэслэн хариуцлага хүлээлгэх, сонгогчдод хууль зүйн механизм бүрдүүллээ.

Гишүүн саналаа заавал биечлэн өгөх зохицуулалт нэмж, Улсын Их Хурлын хэлэлцэж буй аливаа асуудлаар гишүүн идэвхтэй үйлдлээр саналаа илэрхийлэх, асуудлыг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхээр тусгалаа.

Хууль тогтоолын төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны хуралдааны явцад гишүүний горимын саналаар төслийн хэлэлцүүлгийг мэтгэлцээний горимд шилжүүлэхээр тусгасан нь төслийн хэлэлцүүлгийн чанарыг дээшлүүлнэ гэж үзлээ.

Гишүүний ёс зүйн дүрмийг хууль тогтоох, хуулийн биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ шударгаар хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд Ёс зүйн дэд хорооны ажиллах журамтай байхаар нэмж тусгав.

Мөн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлэхээр Улсын Их Хурлын аль нэг дэд дарга хуулиар тогтоосон чиг үүргийнхээ хүрээнд Ёс зүйн дэд хороог удирддаг байхаар тус тус нэмлээ. Аль нэг дэд дарга.

Гурав. Улсын Их Хурлын эргэх холбоо, хүртээмж, ил тод байдлыг сайжруулах, сонгогчдод мэдээллийг тогтмол хүргэх тогтолцоо бүрдүүлэх хүрээнд.

- Улсын Их Хурлын даргыг сонгох хуралдааныг хэлэлцүүлэгтэй явуулахаар, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, хуульд заасан тохиолдолд оролцох боломжийг хангахуйц хүртээмжтэй байх, Улсын Их Хурлын мэдээ, мэдээллийг нийтэд дамжуулахдаа дохионы хэл, товч, бичвэр, тайлбар зэргийг оруулж, тусгай хэрэгцээт иргэдийн мэдээлэл авах, оролцох хүртээмжийг хангахаар, иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судлан шийдвэрлэсэн байдал, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэрийнхээ талаарх мэдээллийг нэгтгэн сар бүр тогтмол мэдээлдэг байх тогтолцоог бүрдүүлэхээр;
- Шаардлагатай гэж үзвэл хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын цахим хуудас, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, харилцаа холбооны хэрэгслээр иргэдээс санал авах боломжийг нэмэгдүүлэхээр;
- Баталсан хууль, тогтоомжийн ач холбогдол, үр нөлөөг иргэдэд энгийн ойлгомжтой богино хэмжээний дүрс бичлэг болон зураг зэрэг хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэн иргэдийг тогтмол мэдээллээр хангадаг байхаар;

Өргөн мэдүүлсэн рууль тогтоомжийн төсөл, хэлэлцүүлгийн үйл явц болон баталсан хууль тогтоомжийн зохицуулалт, ач холбогдлыг хууль санаачлагч

гишүүн, ажлын хэсэг, Байнгын хорооны дарга тайлбарлан таниулж, тогтмол мэдээлдэг байх нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтууд нэмж тусгалаа.

Дөрөв. Улсын Их Хурлын хэлэлцэж буй асуудлаар улс төрийн зөвшилцлийг хангах, парламентыг үл хүндэтгэх үйлдэлд хариуцлага тооцох бодит механизмыг бүрдүүлэх хүрээнд.

- ✧ Хэлэлцэж байгаа аливаа асуудлаар Улсын Их Хурал дахь улс төрийн зөвшилцлийг хангах арга хэмжээ авахыг Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн дарга нарт үүрэг болгохоор;

Хуралдаан даргалагч чуулганы хуралдааны явцад парламентыг үл хүндэтгэсэн үйлдэл гаргасан этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэхээр томилох эрх бүхий этгээдэд албан бичиг илгээх, томилох эрх бүхий этгээд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх хариуг хуралдаан даргалагчид албан бичгээр ирүүлнэ.

Ийнхүү ирүүлсэн албан бичгийг хуралдаан даргалагч холбогдох хуралдаанд уншиж танилцуулах зохицуулалтыг тус тус орууллаа.

Баярлалаа.

Б.Жавхлан: Ж.Бат-Эрдэнэ даргад баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу?

Б.Хэрлэн гишүүнээр тасаллаа. Ч.Ундрам гишүүнд микрофон өгье.

Ч.Ундрам: Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ хэд хэдэн асуулт байна.

- ▷ **Нэгдүгээрт**, 8.6-д олон нийтэд гишүүн хэдэн удаа асуулт асуусан, үг хэлсэн тоо, мөн гаргасан зарчмын зөрүүтэй саналын тоог нийтэлнэ гэж байна.

Тэгэхээр хэрвээ гишүүнд асуух асуулт нэг их гарахгүй, эсвэл хэлэх боломж олдохгүй. Бид чинь аппликэйшнээр дамжуулж хүсэлтээ өгөөд цөөхөн гишүүд л үг хэлэх, асуулт асуух боломж олдож байгаа шүү дээ. Ийм байх юм бол ажлаа муу хийсэн юм шиг харагдаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр хууль санаачлагч юу гэж бодож ингэж оруулсан юм бэ?

- ▷ **Хоёрдугаарт**, 8.7.2-т гишүүн ёс зүйн хэм хэмжээ алдах юм бол 8.7.2-ын “а”-д 30 хүртэл хоногоор асуулт асуух, үг хэлэх эрхийг нь хасах гэж байгаа юм л даа.

Гэтэл тухайн гишүүн чинь өөрөө ард түмний мандат аваад аливаа асуудал дээр тэр ард түмнийхээ төлөө үг хэлэх, асуух эрхтэй байх ёстой шүү дээ. Тэрийг нь Ёс зүйн дэд хороо гээд хэдэн хүмүүс тэр эрхийг нь хасаж болж байгаа юм уу? Ямар үндэслэлээр үүнийг оруулж байгаа юм бэ?

▷ **Гуравдугаарт**, 8.10-д гишүүн ажлын хэсэг юм уу Хянан шалгах түр хорооны хуралдаан тасалсан бол гээд оруулсан байгаа. Нэг удаа л ямар нэгэн шалтгааны улмаас таслах юм бол шууд дураараа нөгөө ажлын хэсэг нь хаслаа гээд хасах юм уу гэдэг ийм асуулт.

▷ **Дөрөвдүгээрт**, 22.6 дээр Байнгын хороодыг нэмсэн байна. Зарим дээр нь санал нэг байна.

Гэхдээ Өргөдлийн байнгын хороо гэж ерөөсөө маш олон чиглэлийн асуудлууд ярьдаг. Тэгсэн мөртлөө асуудлууд тийм олигтой шийдэгдэх боломжгүй ийм нэг Байнгын хороо байгаад байна.

Иргэдээс ирсэн санал хүсэлт, өргөдлийг нь яг мэргэжлийн Байнгын хороодод нь тарааж өгөөд, тэр нь хүлээж аваад, тэр мэргэжлийн Байнгын хорооныхоо хүрээнд шийдээд, тэндээс нь тогтоол, шийдвэр нь гараад явж болдоггүй юм уу?

Тэгэхгүй бол нэг боловсрол ярьж байснаа л нэг орон сууц яриад л, нэг нийгмийн асуудал яриад л үсрээд л. Ерөөсөө мэргэшсэн байдал тэнд огт харагдахгүй. Юм, юм руу л үсчиж ордог. Тэгсэн мөртлөө огт асуудал шийдэхгүй. Ард түмэнд өчнөөн итгэл найдвар төрүүлээд, энэ Их Хурал дээр авчраад үгийг нь сонсоод, тэгсэн мөртлөө асуудал нь шийдэгдэхгүй нэг ийм Байнгын хороог яагаад хэвээр нь энд үлдэж оруулсан юм бол?

Энэ Өргөдлийн байнгын хорооны үйл ажиллагаа нь тийм сайн явлаа гэсэн дүгнэлт энд тэндээс гарсан юм уу?

Б.Жавхлан: Хэн хариулах вэ? Улсын Их Хурлын дарга С.Бямбацогтын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Ч.Ундрам гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг сайжруулах, саналаа биечлэн өгөх хөшүүрэг бий болгох, бүтээмжийг нэмэгдүүлэх, гишүүний бодитой оролцоонд үндэслэн хариуцлага тооцох, Улсын Их Хурлын үйл ажиллагааг сайжруулж, улмаар парламентад итгэх, төрд итгэх ард түмний итгэлийг нэмэгдүүлэх зорилго бүхий заалтууд Улсын Их Хурлын тухай хуульд орж байгаа.

Түүний нэг хэсэг нь таны хэлж байгаа ээлжит чуулганы хугацаанд гишүүний ирц, саналаа биечлэн өгсөн байдал, хурал чуулганы хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн тоо.

Дээрээс нь дотоод, гадаад албан томилолт, хууль санаачилсан яг өөрийн биеэр, мөн хууль санаачлахад оролцсон, ажлын хэсэг ахалсан, ажлын хэсэгт орж ажилласан энэ байдлуудыг бүгдийг нь статистик мэдээллүүдийг нэг бүрчлэн бүртгэж, нэгтгэж үүнийгээ олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлдэг байя гэж орж байгаа.

Үүний зорилго нь юу юм бэ гэхээр Улсын Их Хурлын гишүүдийг илүү ард түмний өргөсөн тангарагтаа хариуцлагатай ажлаа хийх, үүгээрээ Улсын Их Хурлын үйл ажиллагаа тасалдахгүй, хурдан шуурхай явах, ингэснээр төрд итгэх ард түмний итгэл нэмэгдэх энэ бололцоог бий болгоно гэж үзэж байгаа.

Одоо ингээд ирцэд ороод саналаа өгдөггүй алга болдог. Тэгээд үндсэндээ тэр санал унаад унаад байдаг. Эсвэл Байнгын хорооны хуралдаанд оролцохгүй гишүүдэд хэдэн цаг дуудуулаад хуралдаан тасалдах явдал олон удаа гарч байгаа.

Тийм болохоор илүү мэдээлэл өгөөд ард түмний өмнө хүлээсэн, сонгогчдод төлөөлөх эрхээ, үүргээ хэрхэн биелүүлж байгааг нь ил тод мэдээлдэг байя. Тухайн гишүүний идэвх оролцоог үздэг байя.

Ажлын хэсэгт орно орно гэж ороод ажлын хэсэг хуралдахгүй, ирц нь бүрдэхгүй, удаа дараа тасалдах тохиолдол маш их гарч байгаа.

Тийм болохоор ажлын хэсэгт ороод ажлын хэсгийн хуралдаандаа 2 удаа ирэхгүй бол ажлын хэсгээс нь хасъя. Өөр ажлын хэсэгт орох боломжтой хүмүүс нь оруулъя. Иймрхүү зохицуулалтууд орж байгаа.

Ёс зүйн зөрчил гаргавал гэдэг дээр. Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө ёс зүйтэй байх ёстой, илүү үлгэр жишээ манлайлалтай байх ёстой.

Гэтэл өөрсдөө Их Хурлын чуулганы хуралдааны танхимд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээхгүй гэдэг утгаараа ард түмэндээ буруу үлгэр дуурайлал үзүүлдэг, өөрсдөө ёс зүйгүй авирладаг, бүдүүлэг үг хэрэглэдэг, бие биеэ гэмт хэрэгт гүтгэдэг, гутаадаг, худлаа мэдээлэл тараадаг. Энэ нь эргээд ард түмний төрд итгэх итгэл, эргээд парламентад итгэх итгэлийг сулруулж байгаа.

Тийм болохоор удаа дараа ийм зөрчил гаргаад байвал тэр Байнгын хорооны хуралдаан, чуулганы хуралдаанд үг хэлэх, санал өгөх эрхийг нь хязгаарлах, энэ эрхийг нь гэхдээ Ёс зүйн дэд хороо тодорхой үндэслэл, шалтгааныг нь судалж тогтоож байж хязгаарлах ийм зохицуулалтууд орж байгаа.

Ажлын хэсгээс хасахыг хариулсан. Өргөдлийн байнгын хорооны тухайд нэлээн ярьсан.

Тэгээд нэлээн ярьж ярьж байгаад яах аргагүй парламентын үйл ажиллагааг илүү нээлттэй явуулахад, **d.parliament** тийм үү, **e.petition** гээд шинэ олон нийтийн харилцааг бий болгох, иргэд олон нийттэйгээ илүү санал бодлоо тулгуурлаж харилцах нь Өргөдлийн байнгын хорооны тодорхой чиг үүрэг байх ёстой юм байна.

Урьд нь Өргөдлийн байнгын хороонд байгуулагдахдаа яадаг байсан бэ гэхээр ерөөсөө бүх асуудлаар, эрүүл мэндийн асуудал, боловсролын асуудал, байгаль орчны асуудал, уул уурхайн асуудал гээд бүх Байнгын хорооны асуудал талаар өргөдлүүдийг хүлээж аваад хэлэлцдэг байсан бол үүнийг хязгаарлаж байгаа.

Тодорхой асуудлаар нийтийн хэм хэмжээний шинжтэй, нийтийн, олон нийтийн ашиг сонирхолтой холбоотой, d.parliament.mn-тэй холбоотой асуудлууд дээр Өргөдлийн байнгын хороо тодорхой чиг үүрэгтэйгээр ажиллах нь зөв юм болов уу гэдэг үүднээс оруулж ирсэн гэдгийг танд хариулья.

Б.Жавхлан: Ч.Ундрам гишүүн тодруулья.

Ч.Ундрам: С.Бямбацогт дарга та ерөнхийд нь ингээд хариулаад байна.

Одоо жишээлбэл, гишүүд хариуцлагатай байх, саналаа өөрөө байж өгөх гэдгийг би хүлээн зөвшөөрч байгаа. Гэхдээ асуулт асуусан, үг хэлсний тоо гэхээр чинь үг хэлэхийн төлөө хэлэх, нөгөө асуудлаа ойлгохын төлөө хэлэх биш, хэлэхийн төлөө хэлэх гээд уралдаад, асуухын тулд л асуух гээд уралдаад байх вий гэдэг нэг ийм асуудал.

Хоёрдугаарт, Ёс зүйн дэд хороо чинь гишүүний мандат. Би бусад арга хэмжээ авах заалтуудыг нь хүлээн зөвшөөрөөд байгаа юм.

Гэтэл үг хэлэх, асуух асуулт, тэр мандатыг нь Ёс зүйн дэд хороо гээд хэдхэн хүн хасаж болохгүй шүү дээ. Тэр чинь ард түмний өчнөөн мянган хүний, сонгогчийн тэр мандат явж байгаа учраас гэдэг ийм юугаар асуугаад байгаа юм.

Тэгээд энэ 8.10-д “удаа дараа тасалсан” гэж бараг оруулах нь зөв байх гэж бодож байна.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын дарга С.Бямбацогтын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Түрүүн хэлэхээ мартаж. Энэ дэг дээр нэг орж байгаа асуудал. Байнгын хороо, чуулган дээр үг хэлэхдээ бүлгээр дамжуулж асуулт асуух, үг хэлэх нэрээ өгч урьд нь тэгж авдаг байсан. Тэгээд асуулт асууна гээд, үг хэлнэ гээд нэрээ өгөөд бусдынхаа боломжийг хязгаарлаж, хаагаад асуултаа асуудаггүй, үгээ хэлдэггүй, тийм аягүй хатуу дэгтэй болсон байгаа. Үүнийг уян хатан болгож байгаа.

Ерөөсөө асуулт асууж, үг хэлэх гишүүд өглөө чуулганы хуралдаан дээр ирээд шууд үгээ авдаг болно.

Зүгээр Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар тодорхой асуудлыг хэлэлцэх хугацааг нь тогтоож өгнө.

Хугацааг нь тогтоож өгөөд л тэр дотор Улсын Их Хурлын гишүүд асуултаа чөлөөтэй асуух, үгээ чөлөөтэй хэлэх эрх нь нээлттэй болж байгаа. Заавал бүлэг дээр хязгаарладаг байдлыг чөлөөтэй зохицуулж байгаа.

Ео нь зайлшгүй байх ёстой. Нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагдах ёстой. Бид өөрсдөө үлгэр дуурайлал. Дээрээс нь... /минут дуусав/

Б.Жавхлан: Нэмэлт хариулт, дэд дарга Ж.Бат-Эрдэнийн микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь яах вэ, нэлээн хуулиудыг үзэж байгаад энэ хуулийн ажлын хэсэг энэ саналуудыг оруулж ирсэн.

Тэгэхээр үнэхээр тодорхой хэмжээний зөрчил гаргаад байгаа ийм тохиодол байх юм бол энд 30 хоног гэсэн байдлаар үг хэлэх эрхийг нь хасъя гэсэн ийм санал орж ирж байгаа юм.

Тэгэхдээ хууль дээр ажлын хэсэг гарна. Ажлын хэсэг бүх 5 нам, эвслийн саналаа өгсөн гишүүдээс, өөрөөр хэлбэл ажлын хэсэг бүрдээд явна. Энэ дээр дахиад ярих боломж бололцоо гарна.

Энэ хоёр талтай л асуудал байгаа юм. Нөгөө талаар мэдээж ард түмний квот, эрх авсан хүмүүсийн дуу хоолойг хэдхэн хүн хорих нь зөв, буруу гэсэн саналууд гарч ирээд байгаа юм. Таны тавьж байгаа санал.

Тэгэхээр үүнийг авч хэлэлцэх нь зүйтэй байх. Ер нь ажлын хэсэг дээр гараад ирнэ. Ер нь нийгмээс хүсээд байгаа зүйл Улсын Их Хурлын гишүүдийг аль болох ёс зүйтэй, аль болох дэгтэй, журам... /минут дуусав/

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг өгье. Нэмж хариулт.

С.Бямбацогт: Дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйл дээр сая Ч.Ундром гишүүний асууж байгаа асуултыг нарийвчлан зохицуулсан байгаа.

Нэг сарын хугацаанд нийт санал хураалтын 50 хувьд оролцоогүй бол. 50 хувьд.

Мөн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 5 удаа чуулганы хуралдаан тасалсан бол саяын зохицуулалтыг хэрэглэнэ гэж маш тодорхой.

Ерөнхийлөгчийн хуульд чинь “30 хувьдаа хуралдаанд оролцоогүй бол бүрэн эрхийн асуудал ярина” гэж байсан бол энэ дээр бид илүү 50 хувьд нь санал хураалтад оролцоогүй, 5 удаа чуулганы нэгдсэн хуралдаанд оролцоогүй бол энэ эрхийг хязгаарлах ийм зохицуулалт орж байгаа юм. Илүү хариуцлагатай болгох үүднээс.

Б.Жавхлан: Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Асуулт.

Б.Энхбаяр: Эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын гишүүдийн хууль тогтоох үйл ажиллагааны процесст тавигдах сахилга хариуцлагыг дээшлүүлэх, парламентын ажил хэрэгч чадварыг дээшлүүлэх хүрээнд боловсруулсан хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа.

Эндээс хэлэлцүүлгийн шатанд бас нэг бодолцож үзэх ийм гарц шийдэл байна уу гэдгийг хүрээнд хэд хэдэн санал байна.

Тэр дотор жишээлбэл өргөн барьсан төслийн 8.6 байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүдийн чуулган болон Байнгын хорооны хуралдаанд асуулт асуусан, үг хэлсэн тоо, томилолт, хуулийн төсөл санаачилсан, ажлын хэсгийг ахалж ажилласан байдал, зарчмын зөрүүтэй санал гаргасан байдлыг Байнгын хорооны дарга болоход харгалзах шалгуур болгох нь би зүгээр хэр зохимжтой юм бол л гэсэн бодолтой байгаа юм.

Яагаад гэхээр Байнгын хорооны дарга гэдэг парламентад олонхын суудал авсан улс төрийн шалгуур байгаад байгаа юм.

Улс төрийн шалгуур гэдэг бол их онцлог л доо. Бид чинь ТМС төгссөн Монгол Улсын Ерөнхийлөгчтэй байсан байхгүй юу. Дээд боловсролгүй ийм хүн байсан.

Зүгээр би Үндсэн Хуулийн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байхад Улсын Бага Хурал болон Ардын Их Хурлын хуралдаануудын протокол тэмдэглэлийг шүүж үзэж байсан юм.

Тэгэхэд надад нэг зүйл их сонин анзаарагдаж байсан нь Монгол Улсын төрийн тэргүүнээр ажиллаж байсан гэдэг юм уу, ер нь нэр нөлөө бүхий улс төрийн лидерүүд яг хуралдаа сууж байсан юм нь их бага байдаг юм билээ. Их сонин.

Тэгэхээр улс төрийн ажлаа тэр зөвхөн энэ танхимд биш өөр ажлууд хийдэг л байсан юм шиг байгаа юм. Тийм. Жишээлбэл 8 жил Ерөнхийлөгчөөр, 2 удаа Ерөнхий сайдаар ажиллаж байсан Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч гэхэд яг Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байх дээр санаачилж байсан хууль байдаггүй юм

билээ шүү дээ. Хуралд бараг суудаггүй байсан хүн байна лээ. Тэгэхдээ том лидер байсан ч гэдэг юм уу. Тийм ээ.

Тэгэхээр үүнийг яг ингэж харьцуулаад хууль бүр ингээд бичиж бас болж байна уу, үгүй юу. Яг ирц асуусан байдлаар нь ярих юм бол А.Ариунзаяа гишүүнтэй өрсөлдөх хүн байхгүй л байх л даа. Тийм. Шууд бараг Улсын Их Хурлын шууд удирдлагын түвшинд ажиллахаар байна.

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Ер нь Улсын Их Хурлын гишүүн чинь анх нэр дэвшээд явахдаа ерөөсөө л улс орноо хөгжүүлнэ, ард түмнийхээ амьдралыг сайхан болгоно, уулыг нураагаад усыг эргүүлээд ёстой танай нутгийг орвонгоор нь эргүүлнэ гэж байгаад сонгогддог шүү дээ.

Над шиг л мундаг хүн байхгүй, над шиг л ажил хэрэгч хүн байхгүй, над шиг л хариуцлагатай хүн байхгүй гээд. Тэгээд сонгогдоод дараад нь хуралдаа суудаггүй. Би олон сонгогдсон, би туршлагатай хүн. Тийм болохоор би жоохон архаг баавартай байх ёстой. Хуралд суудаг чинь шинэ гишүүдийн, идэвхтэй гишүүдийн ажил. Би тэгдэг гэж ийм хандлага байх нь зохимжгүй байх.

Тийм болохоор яг энэ хандлагаар ярих нь би нэг их зөв биш байх гэж бодож байна.

Хуучин бол одоо байгаа хүчин төгөлдөр Улсын Их Хурлын тухай хуулийн 25.7 дээр Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулж болно гэсэн ийм заалт байгаа.

Энэ бол бүр олон жил улираад ингээд хадгалагдаад явсан заалт. Үүнийг ер нь харгалздаг. Үүн дээр нь нэмээд тэр Байнгын хорооны дарга гэдэг чинь зөвхөн эрх биш –

- хуралдаан даргалахдаа үүрэгтэй,
- өөрөө хариуцлагатай байх ёстой,
- өөрөө хурлаа тасалдаггүй байх ёстой,
- өөрөө илүү ажил хэрэгч байх ёстой.

Одоо Байнгын хороодын дарга нарыг харахад ерөөсөө л Байнгын хорооны дарга гэдэг нь эрхтэй, үүрэггүй юм шиг тийм ойлголтууд яваад байгаа.

Тийм болохоор Байнгын хорооны дарга олон сонгогдсон гэдэг туршлага харгалзаж болно. Гэхдээ дээрээс нь тэр идэвх оролцоо.

- Хэн хариуцлагатай байна,

- хэн ажил хэрэгч чуулган болон Байнгын хорооны хуралдаан цагтаа ирж байна,
- асуудалд санал хураалтад хариуцлагатай оролцож байна,
- иргэдийг төлөөлөх эрхээ хэр зэрэг хэрэгжүүлж байна,
- хууль тогтоох эрхээ хэр зэрэг санаачилгатай хийж хэрэгжүүлж байна.

Одоо ингээд ажлын хэсэгтэй орно орно гэж орчхоод ажлын хэсгийн хуралдаа ирдэггүй.

Хуулийн төсөл санаачлах, гарын үсэг зурчхаад санаачлагчаар эргээд өөрөө өөрийнхөө санаачилсан хууль дээр эсрэг асуулт асуугаад, өөрийнхөө санал асуулгыг дэмжихгүй байр суурь илэрхийлээд явж байдаг.

Энэ байдлуудыг л хариуцлагатай болгоё. Ингэх юм бол гишүүн болгоны үг, үйлдэл болгон хариуцлагатай байж Улсын Их Хурлын үйл ажиллагаа сайжирна. Ингэхдээ үнэхээр идэвхтэй, хариуцлагатай, санаачилгатай ажиллаж байгаа гишүүдийг Байнгын хорооны дарга болоход нь тэр туршлага дээр нэмээд харгалзах үзүүлэлтүүд байж болно гэдэг агуулгаар нэмж энэ заалтуудыг оруулсан гэдгийг хэлмээр байна.

Б.Жавхлан: Б.Энхбаяр гишүүнд микрофон өгье. Тодруулга.

Б.Энхбаяр: 8.6-д заасан оролцоог харгалзаж сонгоно гээд байгаа юм.

Энэ дээр нэг ийм зүйлийг ажлын хэсгийн түвшинд ярих бололцоо байх болов уу. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд бол ер нь бараг асуулт асуухгүй. Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдаан дээр Засгийн газраас парламентад өргөн барьж байгаа хууль тогтоомжийн чинь 70-аас 90 хувь нь Засгийн газар өөрөө өргөн барьсан хуулийн төслүүд байгаад байдаг. Өөрөө өөрөөсөө асууж болохгүй.

Тэгэхээр ерөөсөө бараг асуулт асуудаггүй. Энэ онцлогоосоо хамаараад.

Тэгэхээр асууж засуулсан цаг, минут гэдэг юм нь аягүй бага гарна. Бараг асуулт асуухгүй. Тэгээд хүн харахад дуугүй байгаад байгаа юм шиг харагддаг талтай, тийм нигууртай.

Тэгэхээр асуулт асуусан, үг хэлсэн тоо гэдэг юман дээр нь Засгийн газрын гишүүдийг арай жаахан бодолцож.../минут дуусав/

Б.Жавхлан: Б.Энхбаяр гишүүн үг хэллээ. Б.Хэрлэн гишүүний микрофоныг нээе. Асуулт.

Б.Хэрлэн: Өдрийн мэнд хүргэе. Улсын Их Хурлын тухай хуульд оруулж байгаа өөрчлөлтийг зарчмын хувьд дэмжиж байна.

Ялангуяа Улсын Их Хурлын гишүүдийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх санааг агуулсан гэдэг утгаар нь үүнийг дэмжиж байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад надад гурван асуулт байна.

Нэгдүгээрт нь, 8.5, 8.1.21. Өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурлын гишүүн ёс зүйн дүрмийг сахиж биелүүлэх тухай энэ хоёр заалт утга давхцаад байна уу гэдгийг тодруулмаар байна. Хууль санаачлагчаас 8.5, 8.1.21 хоёр чинь давхцаад байна уу, үгүй юу?

Хоёрдугаарт нь, 25.7, 25.8 хоёр чинь ерөнхийдөө хоорондоо утгын хувьд авцалдаж байна уу, үгүй юу гэдгийг асуух гэсэн юм.

Яагаад вэ гэхээр 25.7-д Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдон ажилласан хугацаа туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгоно гэж байгаа юм. Тэгснээ тэгээд дараа нь 25.8-д нь болоод ирэхээр 8.6 дахь “идэвх, оролцоог нь харгалзацна” гэсэн. Уг нь хараад байхад гишүүдийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлээд, тэгээд нөгөө тойргийн жагсаалтын гэсэн ялгааг багасгаад явж байгаа юм шиг хэрнээ яг энэ 25.7, 25.8 хоёр дээр чинь эргээд ялгаа заагийн асуудлыг үүсгээд байгаа юм биш биз дээ.

Ажлын үр дүн бүтээмжийг нь харах гээд байгаа юм уу, эсвэл зүгээр олон удаа сонгогдсон байдлыг нь харах гээд байгаа юм уу? Аль нь өнөөдөр яг чухал юм бэ гэдгийг. Энэ хоёр чинь хоорондоо авцалдаж байна уу гэдгийг эргэж хараач ээ гэж.

Тэгээд тэр 25.7 дээр өгүүлбэрийнх нь найруулгыг нь харах юм бол үйлийн эзэн нь алга л даа. Нэг өгүүлбэрт “сонгох” гэдэг үг гурван удаа оронгуутаа тэгээд хэн сонгох гээд байгаа гэдэг нь тодорхойгүй. Ядаж өгүүлбэрээ бүтцийнх нь хувьд зөв найруулах хэрэгтэй байна.

Дараа нь 26.1.1 дээр Байнгын хорооны даргын чиг үүрэг дотор Байнгын хорооны хуралдааны ирцийг бүрдүүлж, бэлтгэлийг хангаж, зохион байгуулна гэсэн байгаа юм.

“Бэлтгэлийг хангана” гэдэг маань арай дэндүү ерөнхий байгаад байна уу, үгүй юу гэж. Өөрөөр хэлэх юм бол Байнгын хорооны хурал дээр орж ирэхэд хурал дээр хэлэлцэх асуудлынх нь материалыг тараах тухай асуудал байдаг. Зүгээр улс орны эрх ашгийн тухай асуудал, төр засгийн бүрэн бүтэн байдлын тухай асуудал, маш чухал асуудал хэлэлцэх гэж байхад материалыг нь өгдөггүй. Хурал дээр нь тараадаг ийм асуудлууд байгаад байдаг шүү дээ. Үүнийг тэгээд бид бэлтгэл хангаж байна гэж үзэх үү?

Тэгэхээр энэ “бэлтгэл хангах” гэдгийг өшөө илүү жаахан тодруулж оруулж ирэх бас ямар боломж байх вэ гэж хуулийн төслийг санаачлагчаас асуумаар байна.

Б.Баярбаатар: Хууль санаачлагч Ж.Бат-Эрдэнэ дарга хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ даргын микрофоныг өгөөрэй.

Ж.Бат-Эрдэнэ: 25.7 дээр Байнгын хорооны даргыг сонгохдоо гээд Улсын Их Хуралд сонгогдсон, ажилласан хугацаа, туршлагыг харгалзан Байнгын хорооны гишүүдээс сонгоно гэж байгаа юм.

Энэ үндсэндээ бидний өнөөдрийг хүртэл барьж байгаа зарчим шүү дээ. Ер нь бол.

Гэхдээ бид сая оруулж ирсэн 25.8 дээр Байнгын хорооны даргыг дахин улираан буюу улираан сонгох бол энэ хуулийн 8.6-д заасан оролцоог харгалзаж үзнэ гэж байгаа. Харгалзаж сонгоно гэж байгаа юм. Харгалзах л гэж байгаа юм л даа.

Тэгэхээр яг үүнийг баримталж энэ хуулийн тэдийн тэдийн заалтыг, өөрөөр хэлбэл 8.6-г баримталж сонгоно гэхээс арай ондоо харгалзаж үзье гэж байгаа юм.

Түрүүн бас Б.Энхбаяр гишүүний сайдын хэлсэн үгэн дотор ч бас гарлаа шүү дээ. Ер нь харгалзах асуудал болчхоод байгаа байхгүй юу даа.

Түүнээс биш яг баримтлах бас биш. Ер нь Улсын Их Хурал нь тэр тусмаа давхар сайд хийж байгаа хүмүүсийн хувьд өөр өөрсдөөсөө асуух ч байдаг юм уу, асуудлыг зүгээр хараад сууж байх нөхцөл байдлууд бас байгаад байдаг л даа.

Тийм болохоор үүнийг “харгалзаж” гэдэг үгийг оруулсан юм. Нөгөөтэйгүүр бид ажлын хэсэг байгуулна. Энд нийт 30 гаруй, 40-өөд гишүүдээс ирсэн 200 гаруй санал орж ирсэн байгаа.

Тэгэхээр нийт гишүүдийн орж ирсэн саналыг ерөнхийд нь ярилцаад бас нэг тусгачихъя гэдэг ийм бодлого барьсан юм. Яагаад вэ гэхээр энэ хууль дотор аль болох олон гишүүдийн, аль болох үзэл баримтлалууд, санаа оноонууд шингэг гэсэн утгаар оруулаад ирсэн. Гагцхүү ажлын хэсэг дээрээ хэдүүлээ үүнийгээ дахиад үзээд нарийвчлаад яг энэ байх уу, үгүй юу? Жишээ нь, зөвхөн үүнийг харгалзаад Байнгын хорооны даргыг сонгоод байх юм уу. Энэ харгалзах нэг поинт нь бас мөн үү, биш үү ч гэдэг юм уу ингээд цаашаа ярих нь зүйтэй байх л гэж байгаа юм.

Б.Баярбаатар: Тодруулах уу? Б.Хэрлэн гишүүн тодруулга 1 минут.

Б.Хэрлэн: Тэгэхээр энэ дээр өөрөөр хэлэх юм бол 25.7, 25.8 хоёр дээр ерөнхийдөө туршлагыг нэгдүгээрт харгалзана, үндэслэнэ.

Хоёрдугаарт, дараагийн харгалзах гол шалгуур нь тэр хүний идэвх оролцоог хоёр дахь шалгуураа болгоно гэсэн ийм санаагаар оруулж ирсэн юм байна гэж ерөнхийдөө ойлгож болох юм шиг байна.

Гэхдээ 25.7 дээр түрүүний миний асуугаад байгаа тэр үйлийн эзнийг тодорхой болгох тухай асуудал. Үүнийг бас эргэж харах хэрэгтэй юм байна. Тийм.

Б.Баярбаатар: 1 минут тодруулж хариулъя. Ж.Бат-Эрдэнэ дарга.

Ж.Бат-Эрдэнэ: 25.7 дээр Байнгын хорооны даргыг анх сонгож байгаа асуудал байгаа. 25.8 дээр Байнгын хорооны даргыг дахин болон улируулан сонгох гээд бас нэг ялгаа байгаа шүү. Тийм. Үүнийг гишүүд маань анхаараарай л гэж.

Б.Баярбаатар: Лувсаннямын Гантөмөр гишүүн асуулт асууна.

Л.Гантөмөр: Тэгэхээр тэмээ гэхээр ямаа гээд л явлаа л даа.

Ер нь ард түмэн Монгол Улсын парламентын ёс зүйтэй, хариуцлага сахилга баттай, бусадтайгаа хариуцлага тооцож чаддаг, идэж уухаас хол байгаасай л гэж ярьж байгаа шүү дээ.

- ✦ Худлаа ярьдаггүй,
- ✦ цуурхал тараадаггүй,
- ✦ хэлсэн зүйлээ нотолж чаддаг,
- ✦ популизм хийдэггүй,
- ✦ ард түмэн дээр тулгамдаж байгаа асуудлыг шийдэх чадавхтай.

Гэтэл бид ёс зүйн асуудлыг цэвэр ирцтэй холбоод гараад явчхаж байгаа юм.

Хамгийн гол юм бол ер нь энэ Монголын парламент ийм байгаагүй л дээ. Асуудал үүсэх юм бол тэр асуудлыг нэлээн нухацтай ярьж байгаад тэгээд бодитой шийдлийг нь олоод явдаг байсан юм. Хэдэн хууль баталснаараа уралддаггүй байсан юм л даа.

Хэн их үг хэлдэг популист вэ гэдгээрээ гайхуулдаггүй байсан юм.

- Гол бодлогоо яаж гаргах вэ,
- Засгийн газраа хэрхэн хязгаарлах вэ,
- хэрхэн ард түмний талд шийдвэр гаргах вэ гээд.

Тэгээд наад зах нь түрүүн хаврын чуулганаар хэлэлцэх асуултын жагсаалтыг айхтар эвдэж байна л даа. Наад зах нь ийм зүйл баймгүй байхгүй юу. Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлаа шийдсэн бол тэр асуудлаа л ярьдаг байх хэрэгтэй шүү дээ.

Тэгээд л нэг нөхөр салбаганаад л юм өргөн бариад л, нэг хэсэг нь орилж хашхираад л цаг хугацаа яриад л ямар ч замбараагүй учир шалтгаангүйгээр хууль өргөн барьдаг, шахалтад ордог, дарамтад ордог ийм байдлууд болохгүй байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга дахиад шинэ хууль хүлээж авч болохгүй. Энэ хаврын чуулганаар. Байгаа хуулиудаа ярьж дуусга. Шийдлээ гарга.

Ордын чинь хоёр талд хоёр жагсаал явж байна. Үүнийгээ шийд л дээ. Хэн ч шийдэхгүй. 70 хонолоо.

- Хэн ч гарч уулзахгүй.
- Төрийн байгуулалтын байнгын хороо хүлээж авахгүй.
- Асуудал ярихгүй.

Бид ийм байдалтай байгаад байхаар Монголын ардчилалд итгэх итгэл алдраад, үүнийг зарим нэг хүмүүс нь ашиглаад Монголын ардчиллыг дуусгах гэж байгааг бүгдээрээ харж байгаа шүү дээ.

Тэгэхээр миний асуулт юу вэ гэхээр Их Хурлын даргаас асуумаар байна.

- Хэрхэн хариуцлага тооцдог болох юм бэ? Бид.
- Энэ их тодорхой болох хэрэгтэй.
- Яавал хоёр нүүргүй болох вэ?
- Бидний ирцийг бүртгэж байгаа бол сайд нарынхаа ирцийг давхар бүртгэ.
- Өглөө ажилдаа очиж байна уу?
- Орой яг ажлынхаа цагаар тарж байна уу?
- Ерөнхий сайд чинь чуулгандаа бүрэн суудаг байх хэрэгтэй.
- Ерөнхий сайд Байнгын хорооныхоо хуралд ордог байх хэрэгтэй.

Б.Жавхлан: Лувсаннямын Гантөмөр гишүүнд 1 минут.

Л.Гантөмөр: Монголчуудын хэлээд байгаа хамгийн том асуудал юу вэ гэхээр төр хоёр нүүртэй байна. Хууль болгон хоёр үзүүртэй гараад байна гэдэг ийм л шүүмжлэл байгаа юм. Заримд нь үйлчилдэг, зарим эрх мэдэлтэй хүмүүст хууль үйлчилдэггүй, толгойг нь илээд байна гэдэг.

Тэгэхээр бид яах ёстой вэ гэхээр яг бодит байдал дээр үнэхээр ёс зүйн дээд код ашиг сонирхлын зөрчил.

Төрөөс тендер авдаг өндөр албан тушаалтнуудыг холдуулж чадах юм бол ёс зүйтэй төр болно.

- Яг энэ асуудлыг хэзээ шийдэх юм бэ?
- Төрийн тендертэй холбогдсон сайд нар маргааш нь ажлаа өгдөг байх асуудлыг хэзээ шийдэх юм бэ:

Ийм шийдэл гаргаж байж Монголын парламентыг хамгаална гэж би хувьдаа бодож байна.

Тэгээд мөн чанар луугаа хэзээ орох юм бэ л гэдэг ийм асуултыг тавимаар байгаа юм.

- Гол мөн чанар луугаа хэзээ орох юм бэ?
- Бид хараагүй сонсоогүй юм шиг яваад байх юм уу?

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг нээе.

С.Бямбацогт: Тийм. Л.Гантөмөр гишүүнтэй яг санал нэг байна.

Мөн чанар луугаа орох ёстой. Бид аливаа асуудлын хэлбэрт нь биш, агуулгад нь анхаарах ёстой. Төр нь төр шиг, төрийн түшээ нь төрийн түшээ шиг байж ард түмний төрд итгэх итгэлийг сэргээх ёстой. Ард түмэн “төрийн минь сүлд өршөө” гэж залбирдаг. “Төр төвшин, түмэн олон амгалан байгаасай” гэж ерөөдөг.

Гэтэл төр түшиж байгаа төрийн түшээдийн төрийнх нь, парламентынх нь үйл ажиллагаа ийм хариуцлагагүй, ёс зүйгүй болохоор чинь л үндсэндээ төрд итгэх ард түмний итгэл дагаад таны ярьж байгаа парламентын засаглал маань эрсдэлд орох гээд байгаа юм.

Тийм учраас парламентынхаа үйл ажиллагааг сайжруулъя. Парламентынхаа үйл ажиллагааг сайжруулахын тулд дотоод дэг хуралдаан зохион байгуулалтаа илүү улам боловсронгуй болгоё. Төрийн түшээ болсон гишүүддээ илүү хариуцлагатай, ёс зүйтэй, сахилга баттай, илүү түшээгийнхээ үүрэг, гишүүнийхээ тангаргийг ёсчлон биелүүлэхэд нь хуулиа сайжруулъя гэдэг агуулгаар Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд Улсын Их Хурлын тухай хуулийг санаачилсан.

2024 оны 7 сард энэ парламент анхдугаар чуулганаа хийж тангаргаа өргөсөн. Үүнээс хойш –

- 4 ээлжит чуулган,
- 1 ээлжит бус чуулган хийсэн байна.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд бид –

- 131 хууль,
- 169 тогтоол баталсан байна.

Үүнийг 2020-2024 оны парламенттай харьцуулаад үзэхэд 10 хувьд нь хүрэхгүй байгаа юм. 10 хувьд нь.

Тэгээд 2020-2024 оны парламент ямархуу ажил хийж байж бидний өнөөдөр хийж байгаа ажил маань юу байна гэхээр ерөөсөө энэ хууль тогтоох үйл ажиллагаа маань ийм сул байна.

Дээрээс нь 2025 оны 7 сарын 09-нд Их Хурлын 8 Байнгын хороо, 15 дэд хороотой байхаар байгуулагдсан.

- ➔ 2025 оны намрын одоо ээлжит чуулганы хугацаанд 5 дэд хороо 1-ээс 2 удаа хуралдсан байна.
- ➔ 2026 оны хаврын ээлжит чуулган эхэлснээс 5 дэд хороо 1-ээс 4 удаа хуралдсан байна.

Гэтэл 10 дэд хороо огт хуралдаагүй байна. Хуралдаагүй шалтгаан нь ерөөсөө ихэнх нь ирц хүрээгүй.

- 2024 оноос хойш өнөөдрийг хүртэл ирц хүрээгүйн улмаас Байнгын хороодын хуралдаан 38 удаа тасарсан байна. Хуралдаагүй. Ирц бүрдсэн ч бусад шалтгаан нь 19 удаа, нийтдээ 57 удаа Байнгын хороод хуралдаж чадахгүй байна. Ажлаа хийж чадахгүй байна гэсэн үг шүү дээ.

Үүний дийлэнх шалтгаан нь ирц хүрэхгүй байгаа юм.

Улсын Их Хурлын гишүүдтэй холбоотой 2025 оны намрын ээлжит чуулганд Ёс зүйн дэд хороонд 7 гомдол ирж байсан бол 2026 оны 1 дүгээр улиралд Ёс зүйн дэд хороонд 52 гомдол ирсэн байна. Улсын Их Хурлын гишүүдтэй холбоотой.

Ингээд үндсэндээ гишүүдийн ёс зүй чинь ийм байна шүү дээ. Хуралдаа оролцохгүй байна шүү дээ гэдэг юмнууд чинь өнгөрсөн цаг хугацаанд статистикийг харьцуулаад үзэхээр ийм байгаа учраас

- Улсын Их Хурлынхаа үйл ажиллагааг илүү сайжруулъя,
- Улсын Их Хурлынхаа гишүүдийг илүү хариуцлагатай болгоё,
- Үндсэн хуульд өргөсөн тийм ард түмний элч төлөөлөгч байх, нийт иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэх тангарагтаа илүү ухамсартайгаар ханддаг байгаасай гэдэг үүднээс энэ зохион байгуулалтын тодорхой заалтуудыг оруулж байгаа.
- Ингэж байж илүү Улсын Их Хурлын үйл ажиллагаа сайжирна.
- Бидний баталж байгаа хууль тогтоомж илүү чанартай болно.

Баталж байгаа хууль тогтоомжуудыг олон нийтэд сурталчлах, түгээх, таниулах тал дээр бас томоохон өөрчлөлтүүд орж байгаа.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийн үе шат бүрт нь хуулийг энгийн, ойлгомжтой, товч тодорхой байдлаар ард иргэдэд хүргэдэг байх. Эцэслэн баталсных нь дараа маш ойлгомжтой сурталчлах энэ бүх заалтуудыг илүү тодорхой оруулж байгаа.

Улсын Их Хурлын үйл ажиллагаа ард иргэдээсээ тасарсан. Өнөөдөр бидний баталсан хууль амьдрал дээр хэрэгждэггүй. Ямар хууль батлах гээд байгааг иргэд сонсохоосоо илүү ямар гишүүд хоорондоо юу ярьж хэрэлдэж байна гэдэг нь олон нийтэд цацагддаг болсон. Энэ юмнуудыг л нэг жоохон цэгцэлье.

Б.Жавхлан: Л.Гантөмөр гишүүнд тодруулъя. 1 минут.

Л.Гантөмөр: Тийм.

Тэгэхээр би Их Хурлын даргаас юу асуух гээд байна вэ гэхээр хууль хоёр нөмөргүй үйлчилдэг байх тэр зохицуулалтыг яаж оруулах юм бэ? Одоо жишээлбэл энэ Байнгын хорооны хурлыг Н.Учрал тасалсан байгаа. Ерөнхий сайд нь суудаггүй.

Бусад нь ямар үлгэр авах юм. Ерөнхий сайд нь хуралдаа суухгүй таслаад байхаар бусад гишүүд яаж суух юм. Тийм. Одоо Засгийн газрын гишүүд дараа нь буугаад Байнгын хорооны дарга болохын тулд тэр хуралд суудаг ирц бид нарыг чөлөөлж өгөөч гэдэг зүйл яригдана шүү дээ.

Хоёр юм байна. Ерөнхий сайд яавал Их Хурлын чуулганд суудаг болох юм бэ? Бид ард түмнээс тасраад Ерөнхий сайд нь Их Хурлаасаа тасарсан. Ийм амьдрал дунд бид байна шүү дээ. Нэг.

Хоёр дахь нь, өвчин, гадаад томилолт хоёроос бусад бүх нөхцөл дээр чөлөө өгдөггүй баймаар байна.

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг нээе. Хариулт.

С.Бямбацогт: Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдэд хүндэтгэн үзэх шалтгаан байгаа юм. Давхар ажил байдаг.

Тийм болохоор хоёр Байнгын хороонд биш нэг Байнгын хороонд л харьяалуулж байгаа.

Бусад гишүүд хоёр Байнгын хороонд харьяалагдаж байгаа. Ийм байдлаар Засгийн газрын гишүүд, Ерөнхий сайдыг Улсын Их Хурлын даргыг нэг л Байнгын хороонд харьяалуулахаар. Бусад гишүүд нь хоёр Байнгын хороонд харьяалагдахаар оруулж ирж байгаа.

Дээрээс нь хуралдаандаа суухгүй. Бүгд суух үүрэгтэй. Ерөнхий сайд байна уу, сайд байна уу бүгд хуралдаанд суух үүрэгтэй. Ямар нэгэн байдлаар Ерөнхий сайд учраас суухгүй байх. Сайд учраа суухгүй байх тийм хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй. Тасалсан бол тасалсан. Чөлөөтэй бол чөлөөтэй гэдгээр нь.

Бид яагаад чөлөө, томилолт гэж оруулаад байгаа юм. Чөлөөтэй байдаг, томилолттой байдаг. Энэ статистик нь арай өөрөөр гардаг.

Хамгийн гол нь хуралдаанд –

- нэг ч хоцроогүй,
- нэг ч таслаагүй,
- гадаад томилолтоор ажиллаагүй,
- чөлөө аваагүй –

-гэдэг чинь илүү сайн үзүүлэлт болох юм гэдгийг... /минут дуусав/

Б.Жавхлан: Оюунсайханы Алтангэрэл гишүүний микрофоныг өгье. Асуулт.

О.Алтангэрэл: Идэвх, хариуцлага нэмэгдүүлье гэж байгаа бол зөв л дөө.

Тэгэхдээ энэ чинь хий идэвх нэмэх вий дээ. Нэг ийм хийрхсэн идэвх.

Тухайлах юм бол сая тайлбар гарч байна. Сайд нар гээд нэг Байнгын хороонд. Би одоо ам бардам хэлнэ. Туул зөвлөхөө. Би сайд байхдаа нэг ч Байнгын хорооны уралдаанд би тасалж байгаагүй. Байнга суудаг. Би нэг ч чуулган тасалж байгаагүй. Сонгогдсон цагаасаа хойш одоо жишээлбэл хоёр жил болоход би чуулган тасалж үзээгүй.

Би яагаад үүнийг хэлж байна вэ гэхээр тасалдаг зарим нэг хүмүүс сонирхлын зөрчил гараад хэлж чадахгүй байж магад. Хий идэвх нэмэх вий дээ. Жишээлбэл, чуулган дээр үг хэлэхийг чинь нам, эвслийн бүлгээс нэр авч байгаа шүү дээ.

Тэгээд бид жишээлбэл нам дотроо энэ дээр үг авъя, тэр дээр үг авъя гэж өрсөлдөж байж үг авч байгаа. Багтаагүй нь яах юм? Үг хэлээгүй гэдэг ангилал руу орох уу? Тэр листэд ороогүй нь. Тэгээд нөгөө нэг мундаг олон үг хэлдгийнхээ дараа нь орох уу? эсвэл ямар ч ач холбогдолгүй юм болгоны талаар яриад суудаг нь мундаг үг хэлдэг. Хийж бүтээдэггүй ирцтэй ингээд явах уу? Тэгэхээр энэ дээрээ Та бүхэн маань анхаараарай.

Ер нь хэлэлцэхийг нь, үүнийг бид хэлэлцэх ёстой. Тэгээд энэ хий идэвхжүүлдэг, худлаа цаасан малгай өмсгөдөг, тоо нэмдэг юмнуудаа бас анхаараарай. Яваандаа зарчмын зөрүүтэй саналууд гарах байх.

Дараа нь энэ санал. Цахим хөгжил, хиймэл оюуны бодлогын хороотой болох юм байна. Энэ дээрээ инновацаа заавал тусгаж өгөөч. Инновац. Инновацын чиг үүрэг Эдийн засгийн байнгын хорооны чиглэлд орсон байсан.

Гэтэл энэ чинь цахим хөгжил, өндөр технологи, инновац гэдэг юмнууд чинь бүгдээр уялдаа холбоотой явдаг. Хуучин ингээд явж байсан. Тэгэхээр цаашдаа үүнийг тусгах дээр анхаараарай. Инновац маань яг энэ Байнгын хорооны нэртэй уялдахаас биш хиймэл оюуны тухай бүгд ярьж байгаа юм. Энэ хороогоо ингээд нэрлэхээр бас гоё болох юм байна гэдэг биш, энэ үндэсний хөгжил, бүтээмжид яаж нөлөөлөх юм, ямар ач холбогдолтой байх юм гэдгээсээ нэмээсэй гэж ийм бодол.

Дараагийн дугаарт нь, маш тодорхой асуулт. Хуучин хуулийн төсөл дээр тойргийн гишүүн “бие төлөөлөгчтэй” байна гэж байсан. Тухайлах юм бол Оюунсайханы Алтангэрэл миний бие хангайн бүсээс сонгогдсон 58 сум байдаг. 3 аймаг бий. Дунд нь нэг бие төлөөлөгчтэй. Тэгээд төлөөлөгчийн маань ажил үүрэг гүйцдэггүй учраас чуулганы хуралдаан, Байнгын хорооны хуралд хуралдаанаа таслахгүйн тулд байнга хагас сайн, бүтэн сайн болгоноор явж байгаа.

Тэгээд ийм онцлогтой. Зарим хүн намын бодлого хэрэгжүүлэх жагсаалтад орж ирсэн байдаг. Зарим нь олон аймагтай байдаг. Зарим нь дүүрэгтээ байгаа. Хүн болгоны онцлог өөр. Тэгээд ингэж оруулж ирсэн юм байна. Үүнийг шүүмжилсэнгүй.

Тэгэхдээ энд хэдэн “бие төлөөлөгч” нэмэгдэж хэдэн төгрөг төсвөөс гарах вэ? Бие төлөөлөгчдийн цалин. Би тодорхой тоо асууж байгаа юм шүү. Хэдэн төгрөг шинээр нэмэгдэж байгаа вэ? Бие төлөөлөгч нарын цалин жилд гарах вэ?

Б.Баярбаатар: Ж.Бат-Эрдэнэ дарга хариулъя. Ж.Бат-Эрдэнэ даргын микрофоныг.

Ж.Бат-Эрдэнэ: Мэдээж та сахилга, хариуцлага нэмэгдүүлье гэдэг дээр санал нэгтэй байгаа.

Тэгэхээр үг хэлэх, асуулт асуух, ирц гэдэг юм чинь. Ер нь Улсын Их Хурал гэдэг бол бидний ажил шүү дээ.

Тэгэхээр зайлшгүй ирцтэй байх ёстой. Эндээ ирж байх ёстой. Дээрээс нь бид сонгогчдыгоо энд төлөөлж байгаа шүү дээ. Тийм үү. Тэгэхээр тэднийхээ санаа бодлыг. Түрүүн Л.Гантөмөр гишүүн асуугаад байна лээ. Хоосон үг хэлэх гээд.

- Тэднийхээ санаа бодлыг илэрхийлж бид үг хэлж байгаа.
- Тэднийхээ асууя гэсэн зүйлүүдийг бид асууж байгаа шүү дээ.

Тэгэхээр яг үндсэндээ “асуулт асуух”, “ирцэд байх”, “үг хэлэх” гэдэг яг үндсэн Улсын Их Хурлын гишүүний ажил гэдэг утгаар нь энэ дээр оруулж ирээд байгаа юм.

Урьд өмнө 76 гишүүнтэй байж байхад ер нь хуралд ордог гишүүд бас л. Яах вэ, тэр тусмаа олон сонгогдсон гишүүд ордоггүй шүү дээ. Та бүхэн мэдэж л байгаа. Ордоггүй л байсан.

126 гишүүнтэй болоод энэ маань шал ондоо болсон. Одоо энд чинь яг ажил гэдэг хардаг утгаараа ингэж хандъя гэдэг ийм хандлага орж ирээд энэ саналууд чинь өөрөө энэ шинэчлэл рүү орж ирж байгаа болохоор энэ саналууд орж ирж байгаа юм.

Мэдээж ажлын хэсгийн хүрээнд үүнийгээ хэдүүлээ ярья. Аливаа тэр попрол, илүү дутуу юмнаасаа бас гарах гарц. Үүнийг бас арай ондоо өнцгөөс нь харж томьёолох ч байдаг юм уу, ийм зүйлүүд бас байж болно.

Нөгөөтээгүүр цахим хөгжил дээр инновацыг нэмье гэдэг таны санал байна. Үүнийг ажлын хэсэг дээр бас ярилцаад явад болох байх. Мэдээж 5 нам, эвслийнхэн ажлын хэсэгт ижил тоогоор боломж бололцоотойгоор оруулсан байгаа.

Бие төлөөлөгчтэй байна гэдэг дээр одоо 48 тойргоос сонгогдсон гишүүд дээрээ л нэмж байгаа юм.

Уучлаарай. Жагсаалт. Тийм. 48 жагсаалтаар орж байгаа гишүүд дээрээ “бие төлөөлөгч” нэмж байгаа. Тийм. Үүнийгээ ижил болгоё гэж байна.

Тэгэхээр тооцоог нь дараа нь надаа хэлээд өгвөл би бас гаргаад хэлье. Тийм.

Б.Баярбаатар: О.Алтангэрэл гишүүн тодруулна. Тийм. 1 минут.

О.Алтангэрэл: Тэр тоогоо та тодруулаад хэлчхээрэй. Нэлээн хэдэн тэрбум төгрөг бас яригдах байх.

Энэ цөөнхийн гишүүдэд илтэд хохиролтой зүйлүүд бас орсон байна шүү. Та хэд маань анхаараарай. Би яваандаа зарчмын зөрүүтэй санал гаргана.

Энэ 46.5.6-д нь үнэлгээ хийх талаар. Өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэр хянах шатад буюу төсөл боловсруулаад явж байхад зардлын тооцоонд хийсэн тайланд үнэн бодит байдлын үнэлгээ хийнэ гэсэн байгаа.

Тэгээд ямар төсөл өргөн барих вэ, яах вэ гэдгээ Байнгын хорооны тэр үнэлгээнд Улсын Их Хурлын гишүүний эрх хязгаарлагдах нь л дээ. Ийм юм байхгүй шүү дээ.

Хэлэлцэх эсэхийг нь энд шийдээд, чуулган дээр хэлэлцэх эсэхийг нь шийдээд хэлэлцвэл хэлэлцээд явдаг болохоос өмнө нь нэг ийм хиймэл шат үүсгэж болохгүй. Энэ бол хууль санаачлагчийн эрхэд ноцтой халдаж байна гэж үзэж байгаа.

Доор нь дахиад тэр хэлэлцүүлгийн шатад нь дахиад “нөлөөллийн дүн шинжилгээ хийнэ” гээд. Тэр шинжилгээ нь сөрөг гарвал яах юм гэдэг нэг ийм асуудал байгаа. Энэ дээр санал гарна.

Б.Баярбаатар: О.Алтангэрэл гишүүний 1 минутыг нэмээд өгчих.

О.Алтангэрэл: Манай С.Бямбацогт дарга сая яг зөв юмнууд хэлж байна. Бидний баталж байгаа хууль тогтоомжийн талаар.

Тэгэхээр С.Бямбацогт дарга аа, би танд нэг хүсэлт тавьсан байгаа.

2025 оны 5 дугаар сарын 21-ний өдөр буюу 365 хоногийн өмнө өргөн мэдүүлсэн Нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах хуулийн төслийг хоёр удаагийн хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулаад одоо болтол хэлэлцэхгүй байхаар бидний ажил яаж явах юм бэ?

Тэгээд одоо яг жилийнх нь ой маргааш болох гэж байна. 5 дугаар сарын 21-ний өдөр.

Тэгээд би танд хандаж хүсэж байна. Дарга аа, энэ хуулийн төслийг хэлэлцүүлээд өгөөч. Эрх баригч намын дарга, Ерөнхий сайд маань бас дэмжиж байна гэдгээ илэрхийлсэн.

Нэгэнт хэлэлцэх асуудлын дараалал, захирамжид орсон юмыг хэлэлцүүлж өгөөч гэж энэ завшааныг ашиглаж С.Бямбацогт даргад хүсэлт тавьж байна. Баярлалаа.

Б.Баярбаатар: С.Бямбацогт дарга хариулъя.

С.Бямбацогт: Тэгэхээр жагсаалтын гишүүд тойргийн гишүүдээс нэг нэг “ажлын албаны орон тоо” нэг нэгээр цөөн байгаа.

- Тойргийн гишүүд 3.
- Жагсаалтын 2.

Энэ дээр олон гишүүд адилхан гишүүн, тойрог, жагсаалт ялгаа байхгүй гэж санал тавьсан учраас адилхан 3 болгож байгаа.

Үүнийг хэлэлцүүлгийн явцад гишүүд ярих хэрэгтэй.

Урьд нь гишүүд нэг аймаг төлөөлөөд явдаг байсан бол 4, 5 аймаг төлөөлдөг. Тойрог илүү томорсон үндэслэл байгаа. Үүнийг тэгээд хэлэлцүүлгийн явцад гишүүд ярих байх гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, яах аргагүй “нийт иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэнэ” гэж тангараг өргөдөг.

- Улс орныхоо эрх ашгийн эсрэг хууль санаачилдаг, попордог,
- Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолд эрсдэл учрахаар хууль санаачилдаг асуудлууд байна.

Тийм болохоор хэлэлцүүлгийн явцад шаардлагатай бол тухайн мэргэжлийн Байнгын хороо хууль зүйн дүгнэлт гаргуулах мөн одоо... /минут дуусав/

Б.Баярбаатар: Гүйцээгээд хариулъя. С.Бямбацогт дарга.

С.Бямбацогт: Тэгэхээр үүнийг нэлээн ярих ёстой.

Сая тэгээд Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийг өргөн бариад хэлэлцүүлэхэд л Үндсэн хууль зөрчсөн хууль гээд л яригдаж байсан. Үүнийг бид эхнээсээ нь харж, анхаарч ярьж байхгүй бол үнэхээр нийт иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэж хуулиа барьж уу, үгүй юу. Улсын төсөв, санхүүд ноцтой хор хохирол учруулахаар төсөв өргөн барьчхаад ард түмэн тэр нь таалагддаг. Тэгээд тэр нь хэлэлцэх хэцүү, хэлэлцэхгүй байх нь хэцүү байдалд ордог тохиолдлууд зөндөө л байгаад байна.

Тэгэхээр энэ дээр мэргэжлийн Байнгын хороод нь бас нэг санал, дүгнэлт гаргадаг байя, шинжилгээ хийдэг байя гэж байгаа.

Таны тэр санаачилсан хуулийг Хууль зүйн байнгын хорооноос хэлэлцэгдээд ингээд даргын зөвлөл рүү орох ёстой. Даргын зөвлөл дээрээс орж ирээгүй байна. Хэрвээ холбогдох Байнгын хороо нь даргын дэргэдэх зөвлөл рүү саналаа оруулж ирвэл хэлэлцүүлэхэд бэлэн байна.

Тэгэхээр холбогдох Байнгын хороотойгоо асуудлаа яриарай гэдгийг танд хэлье.

Б.Баярбаатар: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлж үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Чинбатын Ундрэм гишүүнээр, Оюунсайханы Алтангэрэл гишүүн нэмэгдлээ. Ч.Ундрэм гишүүн үг хэлнэ.

Ч.Ундрам: Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Ард түмэнд байж болох бүхий л сайхан үгийг хэлж, амлалт өгч сонгогдсон Их Хурлын гишүүд хариуцлагатай байх ёстой. Хуралдаа ирц сайтай. Тэгээд өөрөө байж байж зөвшөөрсөн, татгалзсан гээд хууль, тогтоол дээр саналаа өгөх ёстой.

Мөн чуулганы танхимд ч гэсэн хэлсэн үгүүд нь хариуцлагатай байх ёстой. Яагаад вэ гэвэл Их Хурлын гишүүн ямар үг хэлснээс шалтгаалж маш олон хүн түүнд нь шууд итгэдэг. Худлаа хэлсэн ч итгэдэг. Заримдаа тэр нь нийгмийг хуваагдуулах, ард түмэнд буруу ойлголт өгөх, янз бүрийн эдийн засгийн ч гэсэн нөлөөллийг үүсгэдэг.

Тийм учраас Их Хурлын гишүүдийг илүү хариуцлагатай байлгах хууль санаачлах асуудлыг би дэмжээд Улсын Их Хурлын даргад ч гэсэн өөрийн саналаа өгсөн.

Гэхдээ бас хэтэрхий бид нэг тал руугаа туйлширч болохгүй. Юмыг наанатай цаанатай авч үзэх ёстой. Хэрвээ Их Хурлын гишүүн хууль санаачилж байгаа бол тэр нь чанартай хууль байх ёстой байхгүй юу. Тэгэхгүй нэг лоозонгийн чанартай, ерөөсөө хэрэгждэггүй тийм хуулиуд бас байгаа шүү дээ.

Хуулийн нэрийг нь сонсохоор ард түмэнд таалагддаг. Тэгсэн мөртөө тэндээс яг хэрэгжүүлээд, араас нь барих юм байдаггүй. Тийм хууль зөндөө байгаа.

Тэгэхээр чанаргүй зүгээр хий дэмий цаг үрсэн, Их Хурлын гишүүдийн ч цагийг үрсэн тийм хууль аль болохоор санаачлуулахгүй, чанар тал тал дээрээ бид анхаарах ёстой. Зөвхөн тоо хараад байхгүй. Тийм.

- Хууль батлах, хэлэлцэх эсэхийг нь шийдэх босго өндөр байх ёстой.
- Хэлж байгаа үг, асууж байгаа асуулт нь чанартай байх ёстой.

Яагаад вэ гэвэл бас л өчнөөн төрийн албан хаагч нар ирээд л Байнгын хороо, Их Хурлын чуулганы хуралд цагаа үрээд л суудаг. Тэгээд л 20, 30-аараа 40 тавиараа хэрэгтэй хэрэггүй юм асуугаад л, тоогоо нэмэх гээд л. Дараа нь статистик тоон дээр нэг их өндөр тоотой. Түүн дотор чанартай тийм асуусан асуулт, өндөр утга агуулгатай юм байхгүй. Тийм зүйлүүд ч гэсэн ажиглагддаг шүү дээ.

Тэгэхээр үүнийг бид маш сайн наанатай, цаанатай бодож, Их Хурлын бүтээмжийг чанар талаас нь нэмэгдүүлэх байдлаар ажлын хэсэг байгуулагдаад ажиллах ёстой гэж бодож байна.

Тэгээд миний хувьд ажлын хэсгийг ахлах саналтай байна. Баярлалаа.

Б.Баярбаатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн санал хэлнэ.

Б.Энхбаяр: Би төслийг дэмжиж байгаа.

Тэр дотроо өмнө нь Засгийн газрын гишүүнээр ажиллаж байх үед их анзаарагддаг байсан. Тухайн сайд нь эрхэлсэн Байнгын хороондоо орохыг хориглосон.

Тэгэнгүүт жишээлбэл Гадаад хэргийн сайд гэхэд гадаад бодлогынхоо Байнгын хороонд орж чаддаггүй, Хууль зүйн сайд гэхэд Хууль зүйн байнгын хороондоо орж чаддаггүй гээд.

Ингээд парламент, Засгийн газрын тасалдал, зай холдолт, мэдээллийн солилцоо алсраад байсан. Үүнийг залруулж байгааг би талархан дэмжиж байгаа.

Үүнтэй хамт бас нэг боломж гаргаж өгвөл болохгүй юу. Засгийн газрын гишүүдийг нэг Байнгын хороонд л оруулаад байгаа. Магадгүй Улсын Их Хурлын удирдлага, ялангуяа бүлгийн дарга нарын түвшинд эрхийг нь өгөөд Засгийн газрын гишүүн өөрөө хүсвэл бүлгийн удирдлага бас яриад хоёр хүртэл Байнгын хороонд орох тэр эрхийг нь нээж болохгүй юу? Одоо би жишээлбэл хашиж байгаа ажлынхаа чиг үүргийн дагуу Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалагдаад байгаа юм л даа.

Тэгээд миний зүрх сэтгэл Хууль зүйн байнгын хороон дээр яваад байдаг. Тэндээ орж чаддаггүй. Энэ хуулиас болоод. Тэнд өмнө нь ярьж хэрэгжүүлж байсан бодлого, үйл ажиллагаан дээр дуу хоолой юмаа бас гаргамаар байдаг. Зүрх сэтгэлгүй гээд байдаг.

Тэгээд хуулиар хашилтад орчхоод орж чаддаггүй. Би ажлынхаа цагаа зохицуулаад орно. О.Алтангэрэл сайд бид хоёр сайд байхдаа хэдийгээр хуулиар хориотой ч гэсэн Хууль зүйн байнгын хорооныхоо хуралдаанд ерөөсөө таслахгүй суугаад байдаг байсан юм. Үгээ хэлээд, саналаа хэлээд яваад байдаг байсан юм л даа.

Тэгэхээр энэ бол Улсын Их Хурал, Засгийн газрыг ойртуулна уу л гэхээс биш холдуулахгүй. Бодлогын нэгдмэл байдлыг ойртуулна уу л гэхээс биш холдуулахгүй байгаа юм л даа.

Тэгээд ирц хүрэхгүйгээсээ болоод энэ чинь манай Хууль зүйн байнгын хорооны тал нь бараг хуульч биш гишүүд байгаа байхгүй юу. Одоо.

Тэгэхээр энэ чинь мэргэжлийн бас нэг шинжлэх ухаан байгаад байдаг. Тэнд оролцох хүсэл эрмэлзэл байгаад байдаг. Ийм нэг боломж олох тал дээр ажлын хэсэг маань анхаарч өгөөч гэсэн хүсэлт, гуйлт байна.

Б.Баярбаатар: Б.Энхбаяр гишүүнд баярлалаа. С.Зулпхар гишүүн.

С.Зулпхар: Их Хурлын гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг –

- ▷ **Нэгдүгээрт**, үзэл баримтлалынх нь хувьд.
- ▷ **Хоёрдугаарт**, шинээр нэмж оруулж байгаа зарчмынх нь хувьд бүрэн дэмжиж байгаа.

Энэ хууль угаасаа нийгмийн өөрийнх нь хүлээлт гэж ойлгох ёстой. Өнгөрсөн жил тойрон хугацаанд Улсын Их Хурлын талаар олон нийт, сонгогчид, өөрөөр хэлбэл төрийн бүрэн эрх мэдэл нь байдаг ард түмэн бидэнтэй холбоотой тодорхой шүүмжлэлтэй байгаа. Тодорхой асуудал дээр биднийг яаж ажиллах талаар санал, бодлоо байнга илэрхийлж байгаа.

Энэ үүднээс нь Улсын Их Хурал өөрөө –

- ✦ хариуцлагатай байх,
- ✦ мэргэшсэн түвшинд ажиллах,
- ✦ мэргэшсэн институцийн түвшинд ажиллах –

-талаас нь энэ хууль хүссэн ч хүсээгүй ч цаг хугацаа нь яг болсон хууль гэж байгаа юм.

Тэгэхээр үүнийг ямар нэгэн байдлаар бид өнөөдөр оруулж ирж хэлэлцэж байгаа нь хаврын чуулганых уу, намрын чуулганых уу гэж эргэлзэх зүйлгүйгээр шууд хэлэлцэх ёстой асуудал гэж байгаа юм.

Гэхдээ гишүүдийн хэлж байгаатай санал нэг байна. Зарим нэг зүйлийг бид харгалзах ёстой байх гэж бодож байгаа юм.

Мэдээж хэрэг бид сая харсан. Тодорхой зүйлүүд дээр идэвхтэй байхын тулд зарим шалгууруудыг оруулаад ирж байгаа юм.

- ➔ Хэчнээн асуулт асуух юм.
- ➔ Хэчнээн санал хэлэх юм гэх мэтчилэн.

Энэ зүйл нэлээн маргаан дагуулах юм шиг байна. Ер нь тэгэх ч байх гэж бодож байгаа юм.

Дандаа их олон асуулт асуух уу, эсвэл тодорхой чиглэлээр өөрөө би асуулт асуух уу гэдгийг тухайн гишүүн өөрөө шийддэг л асуудал л даа.

Тэгэхээр энэ талаас нь хэдүүлээ ажлын хэсэг дээр үүнийг ярих байх гэсэн би ийм бодолтой байна.

Нөгөөтээгүүр Байнгын хороодын даргыг саяын юм уу, зарим нэг шалгуураар бид нэр дэвшүүлнэ гэдэг ч юм уу, эсвэл нэр дэвших боломжийг нь олгоно гэдэг ч юм уу ийм шалгуур тавих юм бол парламентад тогтсон өөрийн нэг тогтсон улс төрийн соёл байгаа. Тэрийгээ бид орхигдуулах вий гэж байгаа юм.

Сая гишүүдийн зарим нь хэлж байна. Улс төрд улс төрийн өөрийн нэг капитал гэж байдаг. Одоо хоёроос дээш сонгогдохоор зэрэг төдий хэмжээгээр улс төрийн туршлагатай болдог учраас тэрийг нь харгалзаж байж Байнгын хороодыг даргалуулдаг. Энэ бол улс төрийнх нь өөрийнх нь байр суурь нь тодорхой тогтсон улсууд, ноён нуруутай болсон гэдэг юм уу энэ талаас нь харгалздаг.

Тэгэхээр Байнгын хороодын дарга нарын шалгуур дээр өөр зүйлүүд байгаа. Ийм нийтлэг байдлаар урьд нь ч гэсэн хэрэглэдэг байсан юм.

- Парламентын ажлын туршлага гэж нэг зүйл бий.
- Тухайн салбар юм уу, чиглэлийн мэдлэг, туршлага гэж нэг зүйл бий.

Хууль тогтоох процесстой холбоотой туршлага их чухал.

Хэлэлцүүлэг удирдаад, талуудыг зохицуулах, маргаан өрнөх юм бол тэрийг намжаах ур чадвар гэж гэж бас байна. Нөгөө түр хүлээн зөвшөөрөгдөх гэдэг ч юм уу.

Тэгэхээр үүнийгээ бид бас орхигдуулахгүйгээр эдгээр зүйлийг энэ асуудал дээр бас тусгах ёстой байх гэсэн бодолтой байна. Гэхдээ үүнийг хэлэлцэх явцдаа бид ярих ёстой байх.

Хоёр дахь нэг санал байна. Би О.Алтангэрэл саналд гишүүнтэй санал нэг байна. Энэ инновацын асуудал бол уг нь салбар дундын шинжтэй, бүх салбарт байдаг зүйл юм. Бүх салбарт инновац явагдаж байгаа шүү дээ.

Бид Байнгын хороодыг, дэд хороодыг ярьж байх явцад би сайн санаж байна. Тэр үед цахим хөгжил болон инновац бүх салбарт хэрэгжиж байгаа учраас энэ хоёроо салбар дундын шинжтэй, бүх салбарын асуудал учраас нэг Байнгын хороо, нэг дэд хороо байлгая гэж байгуулсан байхгүй юу.

Тэгэхээр бид өөр Байнгын хороо руу аваачиж. Би эндээс уншихдаа боловсрол, шинжлэх ухаан, соёл, спортын Байнгын хороо руу аваачиж шинжлэх ухаантай уялдуулсан юм шиг байна. Байж болох хэлбэр. Гэхдээ яг одоо шинээр хиймэл оюун ухааныг бид цахим хөгжлөөр аваад ирлээ шүү дээ.

Тэгэхээр энэ гурав нэг шүү гэдэг талаас нь харгалзах нь зөв байх гэж бодож байна.

Би мөн адил ажлын хэсэг байгуулагдвал ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах саналтай байгаагаа. Хүсэлтэй байгаагаа илэрхийлье. Баярлалаа.

Б.Баярбаатар: Бүлгийн дарга Ж.Батжаргал.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Хамтын удирдлагатай байгууллагын үйл ажиллагааных нь үндсэн зарчим хуралдаан л даа.

Тийм учраас бид энэ рүүгээ л анхаарах ёстой. Тийм.

Тийм учраас үндсэн гурван л юм ярьдаг.

- ▷ **Нэгдүгээрт**, хуралдааны бэлтгэл, хангалтын тухай асуудал байдаг.
- ▷ **Хоёрдугаарт**, хуралдаан өөрөө байдаг.
- ▷ **Гуравдугаарт**, шийдвэрийн хэрэгжилт байдаг.

Ерөөсөө энэ байгууллагуудын чинь өмнөө тавьдаг гол юм нь энэ.

Тийм учраас би энэ асуудлуудаа нэлээн сайн зохицуулах талаас нь анхаарч, тодорхой судалгаа, ер нь энэ Их Хурлын сүүлийн он жилүүдийн явц, энэ бүх юманд нэлээн анзаарч байгаа.

Зарим кэйсүүд дээр хүртэл тодорхой асуудлууд ярьж байж үүнийг нэлээн гайгүй болгосон гэж би бодоод байгаа юм. Мэдээж бүх юм төгс болохгүй нь ойлгомжтой. Засах залруулах юмнууд байгаа байх. Тэрийг би ажлын хэсгийн түвшинд нь шийдэх ёстой.

Дээр нь манай гишүүд олж харсан зүйлээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нь бэлдээд ажлын хэсэг рүүгээ өгөөд шийдэх ёстой. Бид аль болохоор л үүнийг их сайжруулж гаргах ёстой юм гэдэг талаас нь би хэлмээр байна.

Тийм учраас хэлэлцэхийг нь дэмжээд шуурхай явъя гэдэг тал руу нь байр сууриа илэрхийлж байна.

Нэг зүйл орхигдсон юм билээ. Би сүүлийн үеийн Төсвийн Байнгын хороо дээр орж ирээд байгаа асуудлуудыг харсан чинь.

- Анхдагч хууль, шинэчилсэн найруулгыг хэн өргөн барих вэ гэдэг юмыг заагласан хэр нь нэмэлтийг чөлөөтэй хаясан. Өөрчлөлтийг. Гэтэл –

- юун “анхдагч хууль”,
- юун “шинэчилсэн найруулга”-аас
- давсан “**нэмэлт, өөрчлөлт**” байгаа байхгүй юу.

- Ганцхан заалттай хууль ороод ирж байгаа юм.

Тэгээд тэр Монгол Улсын төсвийн орлогын 20 хувийг бүрдүүлж байгаа орлогын талыг байхгүй болгож байгаа ийм заалт орж ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь нэлээн том зүйл юм билээ.

Тийм учраас би –

- ◆ төсөвтэй,
- ◆ татвартай,
- ◆ нийгмийн даатгал,
- ◆ тэтгэвэр,
- ◆ тэтгэмжтэй,
- ◆ эрүү,
- ◆ иргэнтэй –

-асуудлыг ер нь Засгийн газарт нь өгөх ёстой. Энд бүхэл бүтэн мэргэшсэн салбарууд нь ажиллаж байгаа газар. Эндээ судалгаа, тооцоолол бүх юмаа хийж нэгдсэн бодлоготойгоор өргөн баригдаж орж ирдэг байх ёстой.

Тийм учраас хэлэлцүүлгийн түвшинд нь манай зарим гишүүд хамтарч хэдүүлээ энэ асуудлыг өргөн барих ёстой юм билээ. Энэ хөндөгдөөгүй заалт учраас нөгөө нэмэлт, өөрчлөлтөөр ярьж болохгүй болчихоод байгаа юм.

Ингэж үүнийг нэг зөв болгож авахгүй бол сүүлдээ ер нь хүнд таалагдахын тулд улс орны эдийн засаг, төсөв, татварын үндсэн тогтолцоогоо устгахад хүрэх хэмжээнд очих гэж байгаа байхгүй юу.

Тийм учраас үүнийг бодох ёстой. Энэ бол энэ улс орны өөрийнх нь язгуур эрх ашиг, аюулгүй байдалтай нь холбоотой зүйл.

Тэгээд одоо бид хэд чинь юм өөрчлөхөөрөө орон нутгуудынхаа эдийн засгийн чадамж, эрх мэдлийг өргөжүүлэх тухай ярьцгаана.

Гэтэл буцаагаад энд юм хийхээрээ дандаа тэр түвшинд ордог орлогуудыг нь хумьж аваад байгаа.

Тийм учраас тэр 2020 оны Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, түүнийг дагуулж хийсэн төсвийн хийгээд татварын хуулийн өөрчлөлтөөр сумдыг чинь эдийн засаг, төсвийн чадамж нэлээн гайгүй болсон юм. Одоо эргээд энэ рүү нь халдаад, олон сум санхүүгийн дэмжлэгтэй болох юм билээ. Асуудлаа тэндээ шийдэж чадахааргүй болох юм билээ.

Тэгэхээр үүний үр дагавар гэж нэг аюултай юм байна. Энэ боловсруулж байгаа хуулиудын.

Тийм учраас тэр үр дагаврын үнэлгээнүүдийг хийх тухай асуудал ер нь их зөв юм билээ. Бид хэд чинь зүгээр юм хараад үүнийг янзлах ёстой юм байна гээд байгаа болохоос биш ямар үр дүн, ямар үр дагавар дагуулах вэ гэдэг юмыг... /минут дуусав/

Б.Жавхлан: Баярлалаа. Үг хэлэх дотор Баярмагнайн Баярбаатар гишүүний нэрийг нэмж оруулаарай.

Одоо Оюунсайханы Алтангэрэл гишүүн үг хэлнэ. Микрофоныг нээе.

О.Алтангэрэл: Хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ нэг асуудал.

Гэтэл одоогийн төсөл дээр жишээлбэл зардлын тооцоо хийсэн тайланд үнэн бодит байдлын үнэлгээ хийнэ гээд байгаа байхгүй юу. Үнэн бодит байдлын.

Энэ шалгуураар жишээлбэл Ж.Баярмаа гишүүн нарын, одоо бидний гишүүдийн санаачилсан Хувь хүний орлогын албан татварын тухай хууль. Энэ чинь болохгүй гээд тэнд нэг дүгнэлт гаргаад л өргөн мэдүүлэгдэхгүй нь л дээ.

Энэ Их Хурлын гишүүд чинь бүгдээрээ тийм мэдлэггүй, боловсролгүй, эх орныхоо эсрэг хүмүүс бас биш шүү дээ. Нэг асуудал шийдэж нэг газраас юм дутвал цаана нь алтернативаар алийг нь өгөх вэ. Аль бодлогыг нь дэмжих вэ. Энэ асуудлуудаа харна л даа.

Тэгээд өргөн мэдүүлэх төслийн бүрдүүлбэр хянах шатад нь үнэлнэ гээд нэг босго тавиад. Хэлэлцэх шатад нь дахиад зардлын тооцоо, төсөвт үзнэ гээд, дахиад шинжилгээ тавина гээд байх тусам хууль санаачлагч, нэн ялангуяа цөөнхийн бүлгийн гишүүдийн эрхэд халдах гээд байна гээд би яагаад хэлээд байна вэ гэвэл засаг чинь өөрөө яамтай, бүтэцтэй, асуудлыг боловсруулаад ороод ирэх бүтэцтэй. Ингээд массаараа хийж байгаа ажил. Эрх баригчид, Засгийн газрын бүтэц дээрээ тулгуурлаж бодлогоо явуулна.

Нөгөө тал заавал ч үгүй чи ийм сайхан байх ёстой, гоё хувцастай бай гэж хүн шахаж байгаа юм шиг. Үүнийг чинь үзнэ, бид болно, болохгүйг чинь үзнэ, бид шийднэ гээд дарангуйлаад байвал энэ өөрөө дарангуйллын хэрэгсэл бол вий гэж сайн харъя гэж байгаа юм. Авууштай зүйл байхыг үгүйсгэхгүй. Тэгэхдээ үүнийгээ хэдүүлээ сайн хяная.

Ийм үйл явдал эцэстээ юунд хүргэх вэ гэхээр. Одоо манай Ж.Бат-Эрдэнэ гишүүн сууж байна. Ж.Бат-Эрдэнэ дарга.

Малчны тухай хуулийн санаачлагчдын нэг. Болно, бүтнэ гэж баталчхаад тэгээд хэрэгжүүлж чадахгүй байна. Төсөв, мөнгө нь байхгүй байна гээд шалтаг хэлээд сууж байгаа байхгүй юу. Энд чинь ямар ч шалтаг хэлэх ёсгүй шүү дээ.

Баталсан бол хэрэгжүүлэх ёстой. Дараа нь шууд хариуцлагаа ярьдаг болох ёстой. Ингээд ирвэл хууль батлахдаа үүнийг сайн анхаардаг болно.

Тэгээд зарчмын хувьд энэ хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Цаашдаа бид ярих хөөрөх энэ дунд маш олон асуудал байна. Яагаад гэвэл хууль тогтоох дээд байгууллага өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулж байгаа учраас.

Би Б.Энхбаяр сайдын түрүүний саналыг дэмжиж байна. Байнгын хорооны гишүүдийн тоо олон болсон. Салбарын сайд нь орж ирлээ гээд л тэр Байнгын хорооны шийдвэрт нэг их нөлөөлөөд л, өөр сонирхол ороод байх юм байхгүй. Байнгын хороондоо ороод Байнгын хорооны гишүүний хувиар асуудалдаа хандаад ингээд явж болно.

Заавал нэг Байнгын хороонд завгүй юм чинь гэж бид энэ асуудлыг харахаа болих ёстой.

Манай Л.Гантөмөр даргын түрүүний тавьдаг санал зөв. Яагаад ер нь манайд ийм жишиг тогтсон юм. Яагаад зөвхөн Засгийн газартай холбоотой юм уу, улс төрийн шийдвэр гарах үед болон цөөн хэдхэн асуудал дээр Ерөнхий сайд тэр танхимд залардаг юм. Адилхан Улсын Их Хурлын сонгогдсон гишүүн хүн мөртлөө. Яагаад энэ үйл ажиллагаандаа тогтмол оролцож болохгүй юм.

Тэгээд энэ хууль дээр гишүүдтэй холбоотой сахилга, хариуцлагыг хэдүүлээ тусгаж өгвөл дарга юм, сайд юм гэж ялгаварлахгүйгээр бид энэ асуудлыг оруулах нь зөв байх.

Би зориуд С.Бямбацогт даргад хэлье. Манай Байнгын хороон дээр Улсын Их Хурлын дарга харьяалагддаг юм билээ.

Сүүлийн үеийн бүх хуралдаануудад өөрийн биеэр оролцоод сууж байна.

Тэгээд бас та өөрөө үлгэрлэх гэж байгаа юм шиг байна. Ерөнхий сайд маань ийм байгаасай. Сайд нар маань маань бас ийм байгаасай гэж хүсье. Баярлалаа.

Б.Жавхлан: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Баярмагнай Баярбаатар гишүүний микрофоныг нээе. Үг хэлнэ.

Б.Баярбаатар: Байнгын хорооны гишүүд бас Байнгын хорооныхоо гишүүдийг өргөж байх нь зөв л дөө.

Хуулийн төслүүдийг дэмжиж байгаа. Энэ чинь дахиад дараа нь дэгийн хууль байгаа, хяналт шалгалтын тухай хууль байгаа.

Тэгээд энэ гурван хууль гурвуулаа холбоотой учраас.

126 гишүүнтэй парламент үйл ажиллагаа эхлээд 50 хувьдаа орж байна. Одоо энэ цаг үед бид саяын нэр дурдсан 3 хуулийг тодорхой түвшинд нэмэлт, өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага үүссэн.

Учир юу вэ гэвэл энэ анхны парламент. Өмнөх 76 гишүүнтэй парламентын үед энэ 3 хууль гурвуулаа батлагдсан. Үүнээс хойш нэг их дорвитой өөрчлөлт угаасаа энэ хуульд ороогүй.

Гэтэл энэ өнгөрсөн 2 жилийн хугацаанд чинь тодорхой түвшний доголдлууд. Ялангуяа сая Ж.Батжаргал даргын хэлж байгаагаар төсөв хэлэлцэж батлах үеийн асуудлууд, татвар мөнгөтэй холбоотой асуудлууд дээр хэцүү зүйлүүд өрнөсөн. Улсын Их Хурлын нэгдсэн чуулган ирц айхтар хоцрохгүй эхэлдэг болсон. Энэ бол давуу тал.

Гэтэл эсрэгээрээ Байнгын хороо, ажлын хэсгийн хурлуудын ирц бүрдэлт муудсан. Ер нь идэвхтэй ажиллалаа гээд нэг их буруудахгүй байх. Гишүүд хуралдаа, ирцдээ ороод асуулт асуугаад, үг хэлээд.

Мэдээж хуулийн төсөл өргөн барих асуудал тодорхой түвшний хууль тогтоомжийн хуулиараа тавигдах шаардлага нь байгаа. Магадгүй тэрийг өндөр болгож болно.

- Нийгмийн хүлээлт ёс зүйн асуудал байгаа.
- Хувь гишүүний ёс суртахууны асуудал байгаа.

Тэгээд энэ дээр Ёс зүйн дэд хорооны асуудал манай хуулийн өөрчлөлтөд тодорхой түвшинд удирдах албан тушаалтны асуудал яригдаж байна. Зөв байх.

Б.Хэрлэн гишүүнээр ахлуулсан Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль гэсэн ийм 2 эрх зүйн бичиг баримтад үнэлгээ хийж нэмэлт, өөрчлөлт боловсруулж оруулж ирэх ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа. Их Хурлын даргын захирамжаар.

Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм гэдэг бол өөрөө дүрэм гэдэг нэртэй боловчиг Их Хурлын тогтоолоор баталж байгаа зүйл. Хууль нэгэн адил.

Тэгэхээр бид жоохон тодорхой түвшинд сахилга хариуцлагыг сайжруулах зайлшгүй шаардлага байгаа. Ингэж байж бид иргэдийн хүлээлтэд нийцсэн. Наанадаж хурал нь цагтаа эхэлдэг, ирц нь бүрэн, санал хураалтдаа орооч ээ гээд гишүүдийг гуйгаад байдаггүй түвшинд асуудалд хандах нь зөв болов уу гэсэн байр суурь дээр өнөөдөр энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд хамгийн эхний байдлаар орж ирж байгаа юм.

Тэгээд дараа дараагийн зүйлүүд нь ажлын хэсгийн түвшиндээ чамбай таараад явах боломжууд байгаа.

О.Алтангэрэл гишүүн, С.Зулпхар гишүүний хэлснээр шинээр байгуулагдаж байгаа Байнгын хороонд инновацыг нь заавал хавсруулах ёстой.

Тодорхой дэгтэй холбоотой Ч.Ундрэм гишүүний гаргаж байгаа тодорхой саналуудыг ажлын хэсгийн түвшиндээ гаргаад, яриад, сайжруулаад, тэгээд энэ хуулиа батлаад, тэгээд намрын ээлжит чуулганаас мөрдөгдөх болов уу гэж харж байгаа.

Тэгээд үлдсэн хоёр жилээ ядаж нийгмийн хүлээлтэд нийцсэн байдлаар ирц нь бүрэн, санал хураалтаа гуйгаад байдгүйгээр идэвхтэй ажиллах нь зөв болов уу гэж бодож байна.

Тэр салбарын сайд нь харьяаныхаа Байнгын хороонд хамрагддаг байх нь зөв байх. Бид чинь өмнө дандаа тусдаа байх ёстой гэдэг байдлаар гаргаж хаяад байсан юм билээ.

Энэ ч нэг талаараа тэр ашиг сонирхол гээд олон юм байсан байх. Одоо нэг их айхтар 126 дээр тийм нөлөөлөл үүсээд байх нь хэр бол гэдэг байр суурь дээр явцын дунд хэлэлцээд явах нь боломжтой.

Тэгээд өнөөдөр хэлэлцэх гэж байгаа 3 хуулийн төслийг гурвууланг нь дэмжиж байгаагаа илэрхийлье.

Б.Баярбаатар: Гишүүд үзэл баримтлалтай холбоотой дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Ж.Баярмаа гишүүн санал хураалтдаа бэлтгээрэй. Л.Гантөмөр гишүүн. Болсон байна. Санал хураалт явуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Гурав.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн
2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Гурав.Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ гишүүний микрофон.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын зохион байгуулалт үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг 1992 онд баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль, 1997, 2001, 2006, 2007, 2020 онд баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгээр зохицуулж ирсэн.

Улсын Их Хурлын 9 дэх удаагийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан 126 гишүүнтэй Улсын Их Хурал 2024 оны 5 дугаар сарын 15-ны өдөр шинэчлэгдэн баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу чуулганы хуралдааныг дахин зохион байгуулж байна.

Улсын Их Хурлын гишүүдийн болон Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвслийн тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын үйл ажиллагаа төлөвлөлттэй, хэлэлцүүлгийн дэг тодорхой, чуулганд оролцож байгаа гишүүд хариуцлагатай байх чиглэлээр чуулганы хуралдааны дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага нэмэгдэж байна.

Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг боловсронгуй болгох талаарх Улсын Их Хурлын гишүүдийн санал, Монгол, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хэрэглэх явцад гарч байгаа нарийвчлан зохицуулах хуулийн

зүйл, хэсэг, заалтын хоорондын нийцлийг хангах шаардлагыг харгалзан үзэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн Улсын Их Хурлын 06/125 дугаартай албан бичгээр бусад Байнгын хороодоос, мөн 3, 4 дүгээр сард Улсын Их Хурлын гишүүд, тэдгээрийн ажлын албаны ажилтнууд, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудаас санал авч миний бие болон Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл, Ж.Батжаргал, Б.Бейсен, Ч.Лодойсамбуу, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, Ц.Сандаг-Очир, Р.Цэддорж, Г.Тэмүүлэн нарын 12 гишүүний хамтаар хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд тусгасан өөрчлөлтийг дараах хоёр хүрээнд багцлан танилцуулъя.

Нэг.Чуулганы хуралдааны хэлэлцүүлгийн чанар, үр нөлөөг сайжруулах, дэгийн зохицуулалтыг тодорхой болгох хүрээнд дараах гол өөрчлөлтийг тусгахаар бэлтгэлээ.

1.Хууль тогтоомжийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг хэлэлцүүлгийн үе шат бүрээр Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл тогтоож, асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооных харьцааг харгалзан тухайн нам, эвсэл, бүлэг болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүд, бусад гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилж байгаа одоогийн зохицуулалт өөрчлөлт оруулж, хугацааг хувь тэнцүүлэн хуваарилж урьдчилан нэр авахгүйгээр зохион байгуулахаар төсөлд тусгалаа.

Ингэснээр хууль тогтоомжийн хэлэлцүүлгийн явцад танхимд байгаа гишүүд зөвлөлийн тогтоосон хугацаанд багтаан урьдчилсан авсан тооны хязгаарлалтгүйгээр ирцэд бүртгүүлсэн дарааллаараа асуулт асууж хариулт авна.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэгдсэн хуралдаан болон Байнгын, дэд хянан шалгах, түр хорооны хуралдаанд асуулт асуух, түүнд хариулт авах хугацааг өөрөөр зохицуулсан.

Зарим тохиолдолд тодорхой зохицуулаагүй тохиолдлууд ч байгаа тул Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх болон хяналтын сонсголоос бусад тохиолдолд гишүүн асуулт асуух, түүнд хариулт өгөх, нэмэлт асуулт асуух, хариулт авах хугацааг ойлгомжтой болгож, гишүүн 4 минутаас илүүгүй асуух. Хариулт тайлбар хангалтгүй гэж үзвэл 2 хүртэл удаа 1 минутаар нэмэлт асуулт асуух. Түүнд хариулах хугацаа 4 минутаас илүүгүй. Нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл 1 минутаас илүүгүй байхаар тусгалаа.

Хуралдаан даргалагч шаардлагатай бол гишүүний асуултад бүрэн хариулт өгөх зорилгоор нэмэлт тайлбар өгөх хугацааг нэмж өгч болох. Гишүүн хүсэлт гаргасан бол нийт 8 минутын хугацаанд асуулт, хариултыг илүү уян хатан

байдлаар буюу хэдэн ч удаа асуулт асууж, хариулт авах боломжтойгоор зохион байгуулж болох заалт нэмлээ.

3.Хууль санаачлагчдын өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороонд хуваарилснаас хойш ээлжит чуулганы хугацаанд нэг сарын дотор хэлэлцэх асуудлын тов дараалалд тусгах зохицуулалтыг тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нам, эвслийн бүлэг мэтгэлцээн зохион байгуулахаар санал, дүгнэлт гаргасан бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэхээр, түүнчлэн хуралдааны өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө нам, эвслийн бүлэг илтгэгч гишүүнийг томилж ирүүлэхээр заасан.

Гэвч хууль хэрэгжиж эхэлснээс хойш нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргах мэтгэлцээн зохион байгуулаагүй байна.

Тиймээс Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед гишүүн санал гаргаж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол тухайн хэлэлцүүлгийн явцад нэг цагийн хугацаанд чөлөөт мэтгэлцээнийг шууд буюу нам, эвслийн бүлэгт санал, дүгнэлт гаргахгүйгээр, илтгэгч гишүүн томилохгүйгээр зохион байгуулах зохицуулалтыг тусгалаа.

5.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх болсон үндэслэлийн талаарх Ерөнхий сайдын, эсхүл Засгийн газрын гишүүний танилцуулгыг сонссоны дараа санал хураалт явуулж шийдвэрлэх өөрчлөлт орууллаа.

6.Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл хууль тогтоолын төсөл болон төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын саналын талаар хууль зүйн дүгнэлт гаргахдаа ямар хүрээг хамруулан гаргах талаар тусгалаа.

Түүнчлэн Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал Тамгын газраар зардлын тооцоо болон улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн асуудлаар дүн шинжилгээ хийлгэж болох зохицуулалтыг тусгалаа.

7.Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахын өмнө хууль санаачлаад хуулийн төслийн талаар тайлбар хэлж болохоор тусгалаа.

8.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэхэд гишүүн горимын санал гаргасан бол хууль зүйн нэр томъёог жигдлэх зорилгоор хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар багцлан нэг санал болгон санал хураалт болгож болохоор.

Мөн нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх санал хураалт явуулахад эх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжээгүйд тооцох зохицуулалтыг нэмж орууллаа.

9.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахтай холбоотойгоор хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулсан бол түүний ахлагч, эсхүл ажлын хэсгийн гишүүн, Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулах, нэгдсэн хуралдаанд тухайн Байнгын хорооны дарга, ажлын хэсгийг хэсгийн ахлагч, гишүүн асуултад хариулах зохицуулалтыг тусгав.

Мөн Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагчийн хуулийн төслийн талаарх тодруулга, тайлбар хийж болохоор зааснаар анхны хэлэлцүүлгийн шатад төслийн талаар ерөнхий асуулт, хариулт явагдаж төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэгтэй давхацсан шинжтэй асуулт хариулт гарч байгаа тул Байнгын хороогоор хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад гишүүн гаргасан саналаа тайлбарлах, хуулийн төсөлтэй холбогдуулан гарсан зарчмын зөрүүтэй санал дээр хууль санаачлагч тайлбар хийж болох зохицуулалт тусгах зэрэг өөрчлөлтүүдийг хийлээ.

Улсын төсвийн төслийг 4 үе шаттайгаар хэлэлцэхээр тусгалаа.

11.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох болон албан тушаалыг Улсын Их Хуралтай зөвшилцөн танилцах бол нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулж байгаа нь Үндсэн хуулийн холбогдох заалтад нийцээгүй гэж тогтоосон тул Цэцийн гишүүнийг томилох болон зарим албан тушаалтныг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөд нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах зохицуулалтыг хуулиас хасахаар бэлтгэлээ.

12.Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулахтай холбоотойгоор сонсгол даргалагчийг холбогдох Байнгын хороо болон дэд хорооны гишүүнээс сонгох, сонсгол даргалагч эзгүй бол холбогдох Байнгын, эсвэл дэд хорооны даргаар сонсголыг даргалах, сонсгол явуулах журмын зохицуулалтыг ойлгомжтой болгох зэрэг асуудлуудыг хуулийн төсөлд тусгалаа.

Хоёр.Чуулганы хуралдаанд болон санал хураалтад оролцохтой холбоотой гишүүний хариуцлагыг сайжруулах хүрээнд дараах өөрчлөлтийг хийлээ.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан тухайн өдрийн ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн, эсхүл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэх шалтгаантайгаар мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл

бүртгэлээс гарсан бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн хуралдаан асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцох одоогийн зохицуулалтыг хасахаар төсөлд тусгалаа.

Улсын Их Хурлын гишүүний чуулганы хуралдаанд биечлэн оролцож санал өгөх зохицуулалтыг нэмж, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр санал хураалтад биечлэн оролцоогүй гишүүнийг санал хураалтын бүртгэлээс хасах, санал хураалт явуулахын өмнө хуралдааны танхимд байгаа гишүүдийн тоог бүртгэж, тухайн бүртгэлээс санал хураалтын дүнг гаргахаар тусгалаа.

Нэгдсэн хуралдаанд хуралдаан даргалагч санал хураалт явуулахаас 10 минутын өмнө 1 минутын турш санал хураалтын хонх дуугарахаар төсөлд нэмж тусгалаа.

Ил санал хураалтыг цахим... /минут дуусав/

Б.Жавхлан: Ж.Бат-Эрдэнэ даргын цагийг сунгаж өгье. Хууль санаачлагчийн илтгэл учраас дуустал нь цаг сунгая.

Ж.Бат-Эрдэнэ: Ил санал хураалтыг цахимаар, эсвэл гар өргөж явуулах ба гар өргөх санал хураалт явуулах бол гишүүн тухайн асуудлыг дэмжиж байгаа, үгүйг тодорхой илэрхийлдэг байх зорилгоор гишүүн бүрийн нэрээр дуудаж саналыг авч хуралдаан даргалагч дүнг зарлахаар тусгасан байна.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлагад тусгагдсан хуралдаан даргалагч хуралдааны явцад хүлээлгэх хариуцлагаас хуралдаанд оролцох эрхийг хасах, тухайн хуралдааныг орхин гаргахыг үүрэг болгох хариуцлагыг хуулиас хасахаар төсөлд тусгалаа.

Улсын Их Хурлын гишүүн нэгдсэн, Байнгын, дэд хорооны болон хянан шалгах түр хорооны хуралдаанд идэвхтэй оролцдог байх.

Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тодорхой хугацаанд оролцоогүй бол, эсхүл санал хураалтын тодорхой хувьд шалтгаангүйгээр оролцоогүй бол Ёс зүйн дэд хороо хариуцлага хүлээлгэдэг байх зохицуулалтыг нэмж тусгасан болно.

Тодруулбал, гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр болон хуульд заасан үндэслэлээр санал хураалтад оролцоогүйгээ мэдэгдсэнээс бусад тохиолдолд нэг сарын хугацааны нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдааны нийт санал хураалтын 50-аас дээш хувьд оролцоогүй, эсхүл ээлжит чуулганы хуралдаанд нэгдсэн, эсхүл харьяалагдах Байнгын хорооны, эсхүл дэд хорооны хуралдаанд 5 ба түүнээс дээш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол Ёс зүйн дэд хороо, гишүүний зөвлөх, туслах, бие төлөөлөгч, туслахын цалингийн зардлаас бусад гишүүний төсвийн нэг сард оногдох санхүүжилтийг олгохгүй байх хариуцлагыг тусгалаа.

Ёс зүйн дэд хороо гишүүний хуралдааны ирц, санал хураалтад оролцсон байдлын мэдээг долоо хоног бүр гарган авч түүнд үндэслэн гишүүнд хариуцлага оногдуулах, түүнчлэн Ёс зүйн дэд хороо түүн хороо гишүүний хуралдааны ирц, санал хураалтад оролцсон байдлыг ээлжит чуулган хаасны дараа долоо хоногт нийтэд мэдээлэхээр тусгав.

Гурав.Гишүүн ажлын хэсгийн хуралдаанд 2 ба түүнээс дээш удаа биечлэн оролцоогүй түр хорооны хуралдаанд 3 ба түүнээс дээш удаа оролцоогүй бол тухайн ажлын хэсгийн болон түр хорооны бүрэлдэхүүнээс хасах зохицуулалтыг мөн тусгалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай болон Монгол Улсын Засгийн газрын тухай, олон улсын гэрээний тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж оруулсан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Жавхлан: Ж.Бат-Эрдэнэ даргад баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу?

Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа. Баттөмөрийн Энхбаяр гишүүний микрофоныг нээье. Асуулт.

Б.Энхбаяр: Нэгдүгээрт, дагасан хуульд Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулж байгаа юм байна. Энэ яг юу өөрчилж байгаа юм бол оо?

Энэ хуулийн “104 дүгээр зүйлд” гэснийг “хуульд гэж өөрчилсүгэй” гэсэн өөрчлөлт яваа юм байна. Үүнийг ямар учиртай өөрчлөлт хийж байгаа юм бол оо?

Хоёрдугаарт, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд бас өөрчлөлт оруулж байгаа юм байна.

Энэ “15” гэснийг “60” гэж өөрчилсүгэй гэсэн ийм өөрчлөлт оруулж байгаа юм байна. Энэ бас ямар учиртай өөрчлөлт юм бол?

Үндсэн хууль зөрчсөн гэж гарвал 15 хоногийн дотор Улсын Их Хурал холбогдох өөрчлөлт хийдгийг 60 болгож байна уу, үгүй юу?

Хэрэв тэгвэл энэ чинь бүр арай удаан хугацаа биш үү? 2 сар гэдэг нь. 15-аараа байгаад, магадгүй нэлээн тооцоо судалгаа, ажлын хэсгийн өргөн бүрэлдэхүүнтэй байх юм бол дахиад нэг удаа 15 ч байдаг юм уу. Нэгэнт Үндсэн

хуулийн цэцийн дүгнэлт гараад, тухайн хуулийн үйлчлэлийг Үндсэн хууль зөрчсөн гээд зогсоочхоод байгаа үед ингэж их удаж болохгүй байх гэсэн нэг ийм асуулт байна.

Хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байна. Мэдээж.

Том хэмжээний өөрчлөлт байна шүү. Шигтгэсэн байдлаар харвал илүү сайн харагдах байх. Тамгын газар үүнийг шигтгэсэн байдлаар үзээч. Нэг уншилт хийх юм сан гэсэн бодол төрж байна.

Тэгээд яах вэ, мэдээж гишүүдийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх гэж байгааг бид ойлгож байгаа.

Тэгэхдээ улс төрийн харилцаа тэр болгон хуулийн хатуу хана хэрэмд зангидагдахад түвэгтэй байдаг. Гишүүн үг хэлж байхад зэрэгцэж үг хэлэх, саад учруулахыг хориглоно гээд. Энэ бол манай парламент дээр бол ер нь байнга явагддаг. Ялангуяа манай Б.Пүрэвдорж гишүүн их тийм туршлагатай. Энэ тал дээр.

Тэгээд энэ нь үймүүлэх гээд байгаа зорилго биш юм шиг байгаа шүү. Цаад юм нь тэр хүнийг бас нэг дархлаа суулга юмсан.

Ер нь бол хатаагдсан улс төрч бол яаж ч дайрч байсан өөрийнхөө үгийг хэлэх чадвартай л бэлтгэгдсэн байх ёстой.

Тэгээд зориуд үгийг нь анхааруулаад л, үймүүлэх гээд л, цохилт өгөнгүүт нь цохилтод нь ороод л, уймраад л уйлаад л явбал тэгээд л тэр улс төрч биш шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр энэ бол тактикийн барилдаан гэж би ойлгоод байдаг байхгүй юу. Зориуд санаатай тактикийн барилдаан. Тэгэхээр бусад улс оронд бол бүр зодолцож байгаа шүү дээ. Энэ чинь. Юун... /минут дуусав/

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Тийм. Сүүлээс нь эхэлье.

“Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй” гэдэг. Хэдийгээр Улсын Их Хурлын гишүүд хэлсэн үгэндээ хариуцлага хүлээхгүй, дээр нь бусад орны парламент зодолдож л байдаг юм байна лээ. Бид бас тэгсэн ч болохгүй юм байхгүй шүү дээ гэж ярих жоохон биш байх.

Хамгийн гол нь бид нарыг төр гэж харж байгаа. Ард түмэн. Тэгээд төрийн түшээд маань бас ёс зүйтэй, бас бусдад үлгэр дуурайлал үзүүлж, илүү хариуцлагатай байж төрд итгэх ард түмний итгэл сэргэнэ, парламентын засаглал маань бэхэжнэ.

Тэгээд энэ үүднээсээ л бид хэчнээн халдашгүй байдал, бүрэн эрх, Их Хурлын гишүүн танхимдаа хариуцлага хүлээхгүй гээд тодорхой эрхүүд эдэлдэг ч гэсэн нэг хүн хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагддаг. Энэ бол Үндсэн хуулийн зарчим.

Дээрээс нь гишүүд маань гишүүндээ хүндэтгэлтэй хандаж, тэгээд ард түмнийг төлөөлөх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахгүй байх, хууль тогтоох бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй байх. Энэ нь парламентын өөрийнх нь бас нэг соёл, дэг жаяг.

Энэ үүднээсээ л дэгийнхээ хуулиудыг бид жоохон дэглэе, сайжруулъя, анхаарал татсан асуудлуудаа шийдье гэж оруулж ирж байгаа.

Тэгэхээр энд тэр Байнгын хорооны хуралдаанд, чуулганд оролцохгүй байх, санал өгөх эрх эрх өгөх эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарлах, төсөвтэй холбоотой тодорхой хариуцлага ногдуулах.

Мөн олон нийтэд бодитой мэдээллүүдийг нь чуулгандаа оролцсон, оролцоогүй, Байнгын хорооны хуралдаанд оролцсон, оролцоогүй, тасалсан. Тасалсан дотроо бид чинь ингээд байгаа шүү дээ.

Зарим гишүүд маань зальтай. Тасалдаггүй. Өвддөг, чөлөө авдаг. Тэгээд би тасалдаггүй гэж ярьдаг. Аягүй их өвдсөн байдаг. Үнэхээр өвдсөн үү, үгүй юу мэдэхгүй. Үнэхээр их чөлөө авдаг. Зарим гишүүд маань тасалдаггүй, чөлөө авдаггүй. Тэгсэн мөртлөө маш их гадаад томилолтоор явсан байдаг.

Тийм болохоор илүү хариуцлагатай байх ёстой гэдэг үүднээсээ энэ асуудлууд нэлээн оруулж ирж байгаа. Дэг орж байгаа.

Шүүхийн тухай хуультай холбоотой нэмэлт, өөрчлөлт Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 2007 оны хуульд орсон заалт эшилсэн юм байна лээ. Тэрийг хуульд нийцүүлж найруулгын чанартай өөрчлөлт хийж байгаа.

Цэцийн хуультай холбоотой асуудал дээр цэцийн дүгнэлтийг хүлээж аваад шийдвэр гаргахдаа бид хууль тогтоолд өөрчлөлт оруулахгүй бол шууд тэр доор нь шийддэг. Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх хуулийн хугацаатай.

Гэтэл хууль хүлээж аваад хуульд шаардлагатай өөрчлөлт хийх гээд энэ маань хийгдэхгүй, яах аргагүй дэгийн хуулиа зөрчөөд яваад байгаа тохиолдлууд байна. Тухайлах юм бол Х.Тэмүүжин гишүүний ахалж байгаа бусдыг Эрүүгийн хуулийн гүтгэх заалтыг цэц хүчингүй болгосон.

Гэтэл худал мэдээлэл тараах, гүтгэх, дээр дээрээс нь бодитой шүүмжлэл хэлж, бодит мэдээллийг, үнэн байдлыг ил тод зарлах энэ бүгдийг ялгаад, зааглаад, ангилаад ингээд асуудал ярьж байгаа.

Гэтэл нийгэмд галтай учраас гээд хуулийн хугацаандаа хэлэлцэхгүй явсаар байгаад одоо хүрсэн явж байна.

Тийм болохоор хууль зөрчөөд л яваад байна л даа.

Тэгээд ийм бодитой практик байгаа учраас иймэрхүү хүндрэлтэй асуудлууд дээр 60 хоног хүртэл байя. Аль болох богино хугацаанд батлах ёстой. Ийм зохицуулалтыг оруулж байгаа юм. Гүтгэх заалт дээрээ Та бүхэн анзаарч байгаа. Үүнийг ерөөсөө галтай гээд гишүүд маань, ажлын хэсэг маань ерөөсөө оруулж өгдөггүй. Шахаад байж болдоггүй. Хэн хууль зөрчсөн юм... /минут дуусав/

Б.Жавхлан: Лувсаннъямын Гантөмөр гишүүний микрофоныг нээе. Асуулт.

Л.Гантөмөр: Үнэхээр та хэдийн санаачилсан хэдэн хуулийг дэмжихэд аймаар эргэлзээтэй байна. Бодит байдал дээр бол. Асуудал ингээд шийдэгднэ гэж би хувьдаа ерөөсөө харахгүй байна.

Тэгээд бид одоо жишээлбэл татварын багц хуулийг Их Хуралд өргөн мэдүүлээд багц хуулийнхаа ард гаръя гэж байтал Засгийн газар болгон төсөв төлөвлөгөөндөө тааруулаад нэг жижигхэн нэмэлт, өөрчлөлт хийгээд л ингээд л Их хурлаа хуураад байгаатай адилхан бид өөрөө өөрийгөө нэг тийм аргацаах маягтай ийм зүйл бол гээд байна л даа.

Тэгээд би зүгээр Их Хурлын даргыг энд байж байгаа дээр хэлэх гэж байгаа нь нөхцөл байдлыг аягүй тийм ул суурьтай хараад, Их Хурлаар яг юу хэлэлцэх ёстой юм бэ гэдэг зүйлээ тодорхой болгохгүй бол Ерөнхий сайд нь тоож орж ирдэггүй Их Хурлын хуралдаан гэж юу байх вэ дээ. Тийм биз дээ. Энэ чинь ач холбогдол өгөхгүй байна шүү дээ.

Нэг үгээр хэлбэл Монгол Улсад ач холбогдолгүй зүйлийг бид хэлэлцээд сууж байна гэсэн үг байхгүй юу.

Зөв, буруугийн тухайд яг энэ намыг удирдаж байгаа хүн, төр засгийг авч явж байгаа хүн нь орж ирээд чихээ тавиад зөв гарах нь уу, буруу гарах нь уу гээд чагнаж байдаг зүйлсийг л бид яримаар байгаа юм.

Ингэвэл Их Хурлын ач холбогдол, үнэ цэн тодорхой хэмжээнд бий болно. Тэгэхгүй бол энэ хорвоо ертөнцийн бүх зүйлийг Их Хурлаар шийдүүлдэг зүйлийг л бид хийсэн юм байна лээ л дээ. Урьд нь энэ яаралтай гэдэг юм байсан уу, үгүй юу. Та нар үүнийг хармаар байна.

Тэгээд асуулт асуухаас өөр аргагүй болж байгаа зүйл бол энэ яаралтай горим гэдэг чинь ер нь цаашаа ажиллах ёстой юу, үгүй юу? Тэгээд яаралтай горим гэдгийгээ яг юу гэж ойлгох вэ гэдгээ их тодорхой болгохгүй бол Засгийн газар

хүссэн хуулиа өөрчлөхийн тулд энэ хуулийн цоорхойг ашигладаг. Дуртай үедээ өргөн барьдаг. Хүссэн хугацаандаа батлуулахыг оролддог.

Ингэхээр Их Хурлын гишүүд чинь дургүйцээд ажилдаа ирэхгүй байгаа байхгүй юу. Бид Засгийн газрын гар хөл биш шүү дээ гэж Их Хурлын гишүүдийн хэлж байгаа зөв шүү дээ.

Төлөвлөсөн төлөвлөгөөтэй зүйлээ ярихгүйгээр Байнгын хороон дарга Б.Жавхлан дарга онцгой анхаарах хэрэгтэй. Хаврын чуулганаар батлагдсан зүйлийг л ярь л даа.

Батлагдаагүй зүйлсийг бидэн рүү шахахаа болимоор байна шүү дээ. Тоглоомгүй. Бид төлөвлөсөн ажлаа л хийх хэрэгтэй шүү дээ.

Тэгээд шаардлагатай хуулиуд байгаа бол тэрийг бид намрын чуулганаараа ярьж болно, жилийн дараа ярьж болно. Хууль батална гэдэг чинь хамгийн хүнд ажил байх ёстой шүү дээ. Хамгийн их эсэргүүцэлтэй ажил байх ёстой шүү дээ.

Тэгээд батлагдаад гарсан юм нь хоёргүй агуулгатай байхгүй бол. Одоо бид нэг зүйлийг асуумаар байгаа юм. Эцсийн санал хураалтын өмнө ер нь Их Хурлын Тамгын газраас бид хуулийн дүгнэлт авдаг баймаар байна. Яг үзэл баримтлал нь хэвээрээ батлагдсан юм уу? Үнэхээр өргөн барьсан хүн... /минут дуусав/

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг өгье. Хариулт.

С.Бямбацогт: Ерөнхий сайд нь тоодоггүй Их Хурал гэж та ярьсан.

Ер нь үе үеийн Ерөнхий сайд нар яг л тухайн Үндсэн хуулиар өөрт ногдсон чиг үүргийн хүрээнд чуулганы хуралдаандаа суугаад л ирсэн. Цаашдаа ч ийм байх ёстой байх. Хууль тогтоох, гүйцэтгэх засаглалыг Үндсэн хуулиараа зааглаад ялгаад өгсөн.

Хууль тогтоох эрх мэдлийг зөвхөн Улсын Их Хурал хадгална. Улсын Их Хурлын гишүүд эдэлнэ. Гүйцэтгэх засаглал хуулийн хэрэгжилтийг Улсын Их Хурлын өмнө хангах үүрэгтэй.

Тийм болохоор Засгийн газар, Ерөнхий сайд хуулийн хэрэгжилтийг хангах ажилдаа л илүү анхаарах ёстой. Үндсэн хуулиар заагдсан Улсын Их Хурал зайлшгүй оруулж батлуулах иймэрхүү асуудлууддаа л оролцоод явах нь тэдний үүрэг. Засгийн газраас өргөн барьсан хуулиа батлуулах, төсөв, мөнгөний бодлого гээд Үндсэн хуульд заасан тодорхой бодлогын асуудлуудад оролцох.

Бусдаар одоо юу гэдэг юм Их Хурлын гишүүнийхээ хувьд харин Байнгын хорооны хуралдаан, чуулгандаа оролцох үүрэгтэй. Ерөнхий сайдынхаа хувьд оролцох биш. Хуулийн хэрэгжилтийг хангах Үндсэн хуулиар олгогдсон үүргээ л биелүүлнэ. Энэ ялгаатай.

Гишүүнийхээ хувьд Засгийн газрын гишүүд, Ерөнхий сайд нар, Байнгын хороо чуулганд оролцох үүргээ биелүүлэх ёстой. Тусдаа гүйцэтгэх засаглал институцийн хувьд хуулийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэх энэ хүрээндээ л ажил явах ёстой.

Тэгээд үүнийг бид ялгаж салгаж харах ёстой. Хууль батлах хүнд байх ёстой гээд та ярьж байгаа.

Сая О.Алтангэрэл гишүүн хууль санаачлагчийн бүрэн эрхэд халдаж байна. Хууль батлах хөнгөн байх ёстой. Ямар ч хуулийг яаж ч гишүүн санаачилж болно. Улсын Их Хурал харин засаад батлах ёстой гэж ярьж байгаа.

Үнэхээр улс орны тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх хуулиуд дээр бид онцгой анхаарч тодорхой босготой, шалгууртай. Таны хэлж байгаа.

Ялангуяа шаардлагатай үед мэргэжлийн Байнгын хороод нь Их Хурлын Тамгын газраар хууль зүйн дүгнэлт гаргуулах, тооцоо судалгаа хийлгэх, ингэж байгаад цаашид энэ хуулийг батлах уу, батлахгүй юу гэж ярьдаг байхгүй бол.

Сая О.Алтангэрэл гишүүн өөртэйгөө зөрчилдсөн юм ярьж байгаа юм.

Малчны тухай хуулийг баталсан. Бид хэрэгжих ч боломжгүй хууль баталсан. Хэрэгжих боломжгүй хууль өөрсдөө баталчхаад хууль санаачлах эрх алдах гээд байна. Ийм хэрэгжих боломжгүй хуулийг санаачлах нь бидний эрх шүү дээ гээд яриад байгаа байхгүй юу. Ийм биш ээ.

- Хууль хэрэгжих боломжтой байх ёстой.
- Хууль нийгмийн тулгамдсан асуудлыг шийдэж чаддаг байх ёстой.
- Батлагдаад хэрэгжихгүй бол бид хууль батлах шаардлагагүй.

Тийм болохоор таны хэлж байгаа хуулийг эцэслэн батлахын өмнө энэ хуулийн тодорхой дэг заалт орж байгаа. Энэ хууль санаачлагчийн үгийг сонсдог байх. Ийм агуулгатай хууль бид санаачилсан шүү гэдэг үгийг нь сонсдог байх.

Эцэслэн батлаад араас нь Улсын Их Хурал –

- ийм бодлоготой,
- ийм зорилготой,
- ийм ач холбогдолтой –

-ард иргэдийн амьдралд үр өгөөжөө өгөх хуулийг баталлаа гэдгийг нэгтгэн дүгнэж мэдээлдэг байх, сурталчилдаг байх зохицуулалтуудыг дэгийн хууль дээр оруулж ирсэн.

Яаралтай горимын тухайд Засгийн газар үндэсний эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар. Зөвхөн эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар яаралтай горимоор л хууль өргөн барина.

Бусад дурын үзэмжээрээ хууль нэн яаралтай горимоор хууль санаачлахгүй гээд зохицуулсан байгаа. Яг энэ хүрээндээ л орж ирж байгаа. Сая энэ горимоор Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, гадаад зээл ашиглалтын тухай хууль өргөн баригдсан.

Өөр бусад хуулиуд нь ердийн горимоор өргөн баригдаад хэлэлцэгдээд явж байгаа.

Тийм болохоор Засгийн газар ганцхан онцгой эдэлж байгаа эрх бол эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой асуудлаар л нэн яаралтай горимоор хууль өргөн барина гээд. Үүнийг өргөжүүлсэн зүйл байхгүй.

Урьд нь их замбараагүй байсан. Үүнийг харин цэгцэлсэн. Цаашдаа ийм зүйл гарахгүй.

Б.Жавхлан: Л.Гантөмөр гишүүн тодруулъя.

Л.Гантөмөр: Би тийм их ойлгомжгүй л юм асуугаад байгаа юм байх даа. Олон жил та парламентад суусан хүний хувьд би нэг зүйлийн ялгааг л гайхаад байгаа юм л даа.

Энэ парламентын засаглалтай улсуудын парламентын нэгдсэн хуралдаан үнэхээр зөв байгаа байхгүй юу. Жоохон ардчилал хөгжсөн улсуудад.

Тэгээд бидний буруу байгааг л би нэг дүн шинжилгээ хийгээд, үүнийг яаж зөв болгох вэ л гээд л амьхандаа хараад байгаа юм л даа. Ялгаануудыг нь.

Бид хэтэрхий олон зүйл рүү ороод байна. Бид олон зүйл рүү ороод байгаа учраас Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд хүн бид нар дээр тоож ирэхгүй байна шүү дээ.

Би үүнийг жишээ болгож ярьж байгаа болохоос биш би таныг Н.Учралыг авчраад энд суулга гэж ерөөсөө хэлээгүй. Би нэг хүний тухай яриагүй шүү. Өмнө нь бүгд тэгсэн. Тэрийг мэдэж байгаа учраас би хэлээд байна шүү дээ.

Тэгэхээр юу вэ гэхээр бид жоохон энэ дэгээ цаашаагаа ярихдаа Их Хурлын тухай ойлголтыг бид зөв болгохын тулд жоохон... /минут дуусав/

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг нээе. Хариулт.

С.Бямбацогт: Бодлоготой, төлөвлөлттэй, төлөвлөгөөтэй ажиллах бол таны хэлж байгаа зөв өө.

Улсын Их Хурал чинь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, таван жилийн үндсэн чиглэл, жилийн төлөвлөгөө гээд зүйлүүдийгээ баталсан. Энэ хүрээндээ л бодлого, төлөвлөлт маань хийгдээд явж байгаа.

Өнөөдөр хамгийн гол нь Улсын Их Хурлын өөрийн үйл ажиллагаа маань, дотоод зохион байгуулалт сул байгаа учраас. Түрүүн хэлсэн шүү дээ.

Өнгөрсөн парламенттай харьцуулахад бид тэр өнгөрсөн парламент баталж байсан хууль тогтоомжийн 10-хан хувьд нь хүрэх хууль тогтоомжийг өнгөрсөн 2 жилийн хугацаанд хийжээ.

Байнгын хороодын хуралдаан 57 удаа тасраад ажлаа хийж чадаагүй байна. Хувийн хэвшлийнхэн, төрийн бусад албан хаагч нар өглөө 8 цаг 30-д ажилдаа ирээд 17 цаг 30-д гардаг. Цагаа бүртгүүлдэг. Яс ажлаа хийдэг.

Гэтэл Их Хурлын гишүүд маань тааллаараа ажилладаг байгаад байна. Үүнээсээ болоод Их Хурлын нэр хүнд унаад байна. Төрд итгэх ард түмний итгэл сулраад байна.

Тийм болохоор л үүнийг цэгцлэх гээд л дотоод үйл ажиллагаа... /минут дуусав/

Б.Жавхлан: Доржзовдын Энхтуяа гишүүний микрофоныг нээе. Асуулт.

Д.Энхтуяа: Их Хурлын дарга аа,

Их Хурлын гишүүд тааллаараа ажилладаг хууль дүрэм үйлчилж байгаа юм уу? Би сая таны хэлсэнд бүр гайхлаа. Аргаа бараад л ийм хууль оруулж ирж байгаа байх гэж бодож байна.

Энэ чинь Төрийн албаны ёс зүйн тухай хууль, Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн тухай хууль гээд бүх юман дээр орж ирсэн энэ саналууд чинь бүгдээрээ л байгаа шүү дээ.

Өнөөдөр Их Хурлын гишүүд чинь хуралдаа бүтэн суух ёстой, идэвхтэй оролцох ёстой, ёс зүйтэй байх ёстой гээд бүх л хууль дээр энэ бүгдийг заагаад өгсөн байгаа шүү дээ.

Тэгээд дахиад Улсын Их Хурал хийх ажилгүй ажилгүй юм шиг гурав, дөрвөөр нь хуулийн төслүүдийг оруулж ирж байна л даа.

Тэгээд яг энэ оруулж ирсэн төсөл дээр ингэж байгаа байхгүй юу. Ерөнхийдөө Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа гэдэг юм уу, эсвэл рангийг нэмэх хэд хэдэн заалтууд байна л даа.

Өнөөдөр Ёс зүйн дэд хороо нэлээн л ажиллалаа.

Тэгээд Улсын Их Хурлын хууль тогтоох явцад хэлэлцэгдэж байгаа хэлэлцүүлгийн мэтгэлцээн дээр гарсан маргаануудыг шүүн таслах маягаар өнгөрсөн хугацаанд ажиллаж ирлээ л дээ.

Гэхдээ шүүн таслаад яг хариуцлага хүлээлгээд, ямар нэгэн байдлаар ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн юм өнгөрсөн хоёр жилийн хугацаанд миний хувьд Ёс зүйн дэд хорооны гишүүнээр ажиллахад тийм юм харагдсангүй.

Энэ нэмэлт, өөрчлөлт дээр Улсын Их Хурлын гишүүд нэг сарын хугацаанд нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оролцоогүй, мөн санал хураалтын 50-иас дээш хувьд оролцоогүй бол Ёс зүйн дэд хороо гишүүний ажлын албаны цалингаас бусад гишүүний төсвийг нэг сард ногдох санхүүжилтийг олгохгүй байна гэнэ.

Тэгэхээр нөгөө Ёс зүйн хороо чинь гишүүний санхүүжилт рүү хүртэл ороод энэ асуудлыг нь шийдэх юм байна л даа.

Тэгэхээр энэ бол бодит амьдрал дээр хэрэгжих боломжтой гэж үзэж байна уу? Хууль санаачлагчаас асуумаар байна? Адилхан Их Хурлын гишүүдээс бүрдсэн Ёс зүйн дэгийн хороо тэгээд л Их Хурлын гишүүнийхээ сарын санхүүжилтээс нь хасаад л явж байна. Энэ чинь угаасаа ирцээрээ байж байгаа шүү дээ.

Тэгэхээр Ёс зүйн дэд хороо чинь яг ямар асуудлыг хэлэлцэж, шийдвэр гэдэг юм уу, дүгнэлт гаргах юм бэ? Өнөөгийн нөхцөл байдалд Ёс зүйн дэд хорооны гаргаж байгаа шийдвэр, бусад гишүүд нь хүлээн зөвшөөрөгдөх байдал нь дутуу л байгаа шүү дээ.

Энэ дээр үнэхээр хүлээн зөвшөөрөхгүй зөндөө олон маргаан гараад л байгаа шүү дээ.

Яахаараа намайг, миний асуудлыг Ёс зүйн хороогоор хэлэлцдэг юм, эд нар яагаад хэлэлцэх ёстой юм гэсэн ийм л асуудал байгаад байхад дахиад Ёс зүйн дэд хороон дээр дахиад ийм ойлгомжгүй. Тэгээд энэ яг бодит байдал дээр цаашаагаа шийдэгдээд явах ийм зүйл харагдахгүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр ийм нэмэлт цаашдаа бодитоор амьдралд хэрэгжиж чадах уу? Нэг ийм асуулт байна.

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг нээе. Хариулт.

С.Бямбацогт: Тийм. Ёс зүйн дэд хорооны гишүүн та өөрөө байгаа.

Ёс зүйн дэд хороо хуралдах гээд хуралдаж чадахгүй зөндөө удаж байгаа. Ёс зүйн дэд хороо асуудлаа шийдэж чадахгүй. Ёс зүйн дэд хорооны гишүүд, Ёс зүйн дэд хорооны дарга, бусад гишүүдийн хооронд тодорхой асуудлууд үүсээд Их Хурлыг муухай харагдуулах иймэрхүү процесс болсныг та өөрөө сайн мэдэж байгаа. Тийм учраас –

- Ёс зүйн дэд хороо хүлээн зөвшөөрөгдөхгүй байна,
- Ёс зүйн дэд хороо ажиллаж чадахгүй байна.

Тийм болохоор Ёс зүйн дэд хороо ер нь байх хэрэгтэй юу, хэрэггүй гэж ярих биш ээ.

- Харин ч Ёс зүйн дэд хороо байх ёстой.
- Ёс зүйн дэд хороо илүү хүлээн зөвшөөрөгдөх ёстой.
- Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох ёстой.

Тэгж байж Улсын Их Хурлын гишүүд

- ёс зүйтэй,
- сахилга баттай,
- хариуцлагатай болно.

Тэгж байж Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын ажил сайжирна, зохион байгуулалт сайжирна. Ингэж байж төрд итгэх ард түмний итгэл нэмэгдэнэ. Ингэж байж парламентын засаглал улам бэхэжнэ.

Тийм болохоор энэ агуулгаар оруулсан. Ёс зүйн дэд хороог хүлээн зөвшөөрөөд, Улсын Их Хурлын аль нэг дэд дарга нь ахалъя гэж орж ирж байгаа.

Ёс зүйн дэд хороо нь аль болох туршлагатай, ёс зүйтэй гишүүдээсээ илүү оруулдаг байя. Ингээд бусад гишүүдийнхээ ёс зүйн асуудлыг ярьдаг байя. Ярьдаггүй биш.

- Ёс зүйн дэд хороон дээр ажлаа хийхгүй 5 удаа таслах юм бол тэр гишүүний асуудлыг Ёс зүйн дэд хороо ярина.
- Сарын санал хураалтын 50-иас дээш хувьд нь оролцохгүй бол тэр гишүүний ёс зүйн асуудлыг Ёс зүйн дэд хороо ярина.
- Ёс зүйгүй бүдүүлэг үг хэл хэрэглээд, хуралдаан үймүүлээд, бусдын нэр хүндэд халдаад, гутаагаад, худлаа мэдээлэл тараагаад байвал тэр гишүүний ёс зүйн асуудлыг Ёс зүйн дэд хороо ярина. Ингэж тодорхой оруулж өгч байгаа.

Мөн гишүүд тааллаар оролцоно гэдэг. Яах аргагүй тийм л болчхоод байна л даа. Бүгдээрээ биш. Тийм үү. Ихэнх гишүүд хариуцлагатай байна. Нөгөө “уулын

мод урттай богинотой, олон хүн сайнтай муутай” гэж ярьдаг. Энэ 126 гишүүн дотор чинь ажлаа хийдэггүй, хурлаа тасалдаг, ажилдаа ирж өглөө ирцдээ орчхоод санал хураалтдаа оролцохгүй гараад алга болдог ийм хүмүүс бас байна. Ихэнх нь ажлаа сайн хийж байна. Байнгын хороондоо, дэд хороондоо, ажлын хэсэгтээ чуулгандаа яс оролцож байна. Бүлгийн хуралдаа.

Гэтэл зарим нөхдүүд маань хуралдаа ерөөсөө ирдэггүй. Ажлаа таслаад алга болдог. Эсвэл ирчхээд ирцдээ орчхоод санал хураалтад оролцдоггүй. Түрүүн би хэллээ шүү дээ.

57 удаа Байнгын хороо хуралдаж чадаагүй байна гэж. Энэ чинь аягүй том асуудал болчихоод байна шүү дээ. Бид ажлаа хийж чадахгүй байна.

Өөр жирийн албан хаагч 57 биш, 5 удаа ажилдаа хоцрох юм бол, 5 удаа таслах юм бол ажлаас халагдаж байгаа.

Гэтэл бид 57 удаа Байнгын хороогоо хуралдуулж чадахгүй байж эцэст нь эргээд төр ажлаа хийж чадахгүй байна. Их Хурлын нэр хүнд чинь л унаад байна л даа.

Тийм болохоороо гишүүдийг илүү хариуцлагатай. Зарим нь тааллаар оролцоод байгаа. Зарим ажил хийдүүлээд байгаа нөхдүүдийг л илүү хариуцлагатай болгоё гэдэг агуулгаар л чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд тодорхой заалтуудыг оруулж байгаа юм. Д.Энхтуяа гишүүн ээ.

Б.Жавхлан: Хууль санаачлагч Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүний микрофоныг нээе. Нэмэлт хариулт.

Ч.Лодойсамбуу: Д.Энхтуяа гишүүний асуусан дээр тодорхой нэг юм хэлэхгүй бол болохгүй байгаа юм.

Яг санал нэг байгаа юм. Тэр Улсын Их Хурлын гишүүний санхүүжилтээс хасах. Тэрийг нь одоо Ёс зүйн дэд хороо шийднэ гээд. Энэ дээр нэг мөсөн нэг тодорхой хариулт хэлмээр байгаа нь юу вэ гэхээр сүүлийн үед гишүүний зардал, тойрогт зарцуулах мөнгө, санхүүжилт гээд.

Үүнийг ерөнхийдөө олон нийт юу гэж ойлгоод байна гэхээр гишүүний нэг ийм тусдаа цалин 20, 30 сая төгрөгийн цалинтай юм шиг ойлгоод, тэрийг нь манай парламент, хууль санаачлагчид бид өөрсдөө юу гэж дүгнээд байна гэхээр цалин юм шигээр энэ хуульдаа бичээд байгаа. Үүнийг яах вэ, даргын дээд зөвлөл дээр эсэргүүцээд бараагүй юм л даа.

Энэ хэрвээ цалин юм бол түүгээр бид арга хэмжээ авч болно.

Гэтэл гишүүний гээд бүтэн жилийн нэг төсөв тавьчихаад, тэгээд түүгээрээ үйл ажиллагаа буюу парламентын үйл ажиллагаа явуулах ёстой байтал тэрийг

нь хасна гэдэг шийтгэл оруулна гэдэг нь өөрөө тухайн гишүүнийгээ биш парламент үйл ажиллагаагаа шийтгээд байгаа хэлбэр болоод байгаа юм.

Тэгэхээр Д.Энхтуяа гишүүнтэй санал... /минут дуусав/

Б.Жавхлан: Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт сууж дууслаа.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу? Б.Хэрлэн гишүүнээр тасаллаа.

Бадарчийн Хэрлэн гишүүний микрофоныг өгье. Үг.

Б.Хэрлэн: Тэгэхээр Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуульд оруулж байгаа өөрчлөлтийг зарчмын хувьд ерөнхийдөө дэмжиж байгаа.

Бас түрүүн Улсын Их Хуралд оруулж байгаа өөрчлөлт бол сахилга хариуцлагыг, ялангуяа Улсын Их Хурлын гишүүний сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилготой байсан. Энд хуулийн төсөлд энэ санаа шингэж орж ирсэн байгаа.

Тэгэхээр сая Ёс зүйн дэд хорооны тухай, ялангуяа 2026 онд Ёс зүйн дэд хороонд 50 гаруй тооны өргөдөл ирээд, хэлэлцэгдэж шийдэгдсэн эсэх нь эргэлзээтэй.

Энэ дэд хороо ажиллаж байна уу, үгүй юу гэсэн ийм зүйлүүд яригдаж байгаа учраас энэ ажлыг хариуцаж байгаа хүний хувьд би бас бодитой тодорхой мэдээлэл өгөх үүрэгтэй гэж бодож байна.

Тэгэхээр 7 хүнтэй холбоотой өргөдөл ирсэн. Улсын Их Хурлын 5 гишүүнтэй холбоотой өргөдөл ирсэн байгаа. 5 гишүүний 3-ынх нь асуудлыг Ёс зүйн дэд хорооны гишүүдэд хуваарилж, өргөдлийг шалгаж асуудлыг бид шийдсэн байгаа.

Манай Ёс зүйн дэд хороо 8 гишүүнтэй. Бид бүгдээрээ ажил үүргээ хуваарилж аваад тэгээд явдаг. 2 гишүүнтэй холбоотой өргөдөл одоогоор хэлэлцэгдээгүй, шийдэгдээгүй, зүгээр өргөдлийг шалгаж тайлбарыг нь аваад хуралдаанаа хүлээгээд байж байгаа.

Ёс зүйн дэд хороог хуралдуулах тухай товыг тавьж өгөхийг бид Байнгын хороон даргад 5-аас 6 удаа бид тавьсан. 5-аас 6 долоо хоног гэсэн үг.

Тэгэхээр энэ товыг хүлээгээд байж байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө ёс зүйн асуудал маш хэцүүдээд байна. Энэ хороо ажиллаж байна уу, үгүй юу гэсэн ийм эргэлзээ тээнэгэлзээг төрүүлээд байх шиг

байна. Бид Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн хүрээнд, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хүрээнд хуулиа баримталж бид ажиллаж байгаа.

- Бид хуулийг давж ажиллаагүй.
- Хуулийг дутуу хэрэглэж бид ажиллаагүй.

Тэгэхээр хуулийн зохицуулалтын хүрээнд ажиллаж байгаа шүү. Үүнийг би бүр албан ёсоор хэлье гэж би бодож байна.

Тэгэхээр одоо орж ирж байгаа энэ хуулиуд дээр ерөнхийдөө сахилга хариуцлагыг бид хуулийн хүрээнд сайжруулъя гэж байна.

Тэгэхээр ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, энэ бүх юмтай магадгүй одоо орж ирж байгаа зарим нэг зохицуулалтууд давхцаж байна уу гэсэн ийм сэтгэгдэл надад төрж байна.

Тэгэхээр хуулийн хэлэлцүүлгийн явцад бид энэ давхардлуудыг, хийдлүүдийг арилгах тухай дээр зарчмын саналуудыг гаргаад явна.

Б.Жавхлан: Баярлалаа. Б.Хэрлэн гишүүн хуулийн үзэл баримтлалыг дэмжиж үг хэллээ гэж ойлголоо. Тийм ээ. Тэгж тооцлоо шүү дээ.

Лувсаннямын Гантөмөр гишүүн. Дэмжсэн юм байна. Үг давхацсан гэдэг нь дэмжсэн гишүүнтэй давхцаж байгаа учраас Л.Гантөмөр гишүүн хуулийн үзэл баримтлалыг дэмжиж байна гэж байна. Тийм.

Үндсэн хуулийн сүүлд орсон нэмэлт, өөрчлөлтөөс хойш Их Хурлын маань шинэ түүх эхэлж 126 гишүүнтэй болсон.

Мөн олон нийтээс ч тэр юм уу, үүнийг дагаад маш өндөр ёс суртахуун, дэг журам, парламентын өндөр гүйцэтгэл бүхий ийм хуулийн дээд байгууллага парламентын засаглалыг ард түмэн маань оюун санааны хувьд ч тэр, бодит хүлээлтийн хувьд ч тэр маш их өндөр боллоо.

Тийм учраас хууль санаачлагчдын хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлтүүд олон нийтийн хүлээлтийг гүйцэлдүүлсэн өөрчлөлтүүд болно гэж найдаж байгаа шүү.

Тийм учраас мөн хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь дэмжиж байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Ирцийн санал хураалт явуулъя. Гишүүд бэлэн байгаарай. Ирцийн санал хураалт шүү. Ирцийн санал хураалт. /алх цохив/

Баярлалаа. Ирц бэлэн болжээ.

1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар дэмжигдлээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцсоноос 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэж ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар санал дэмжигдлээ. Баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар гишүүн танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Дөрөв.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн
2026 оны 05 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Дөрөв.Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ нарын 12 гишүүн 2026 оны 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэллээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна.

Ж.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад заасны дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй.

28 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт хуулийн биелэлтийг хангахтай холбоотой ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурлын цөөнхийн төлөөллийг оролцуулан хороог байгуулна гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн эдгээр заалтад нийцүүлэн 2021 онд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг батлан 2024 онд шинэчлэн баталснаар нийт 5 жилийн хугацаанд Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхээ энэхүү хуулийн хүрээнд хэрэгжүүлж хийсэн.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд парламентын хяналт шалгалтаа зохион байгуулж ирсэн 5 жилийн хугацаанд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд чамгүй туршлага хуримтлуулж, холбогдох мэдээллийг нэгдсэн сан бүртгэл, хяналттай болсны зэрэгцээ цаашид сайжруулбал зохих хууль хоорондын нийцлийг хангах тодорхой асуудлуудыг таньж эрэмбэлж ирсэн билээ. Үүнд:

1.Хяналт шалгалтын төлөвлөлт цаглаврын хэрэгжилт, эрх зүйн зохицуулалт сул, бүрэн төлөвшөөгүй.

2.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, дүн шинжилгээ, түүний үр дүнг Улсын Их Хурлаар хэлэлцэх хэлэлцэх үе шат, үйл ажиллагааны зохицуулалт оновчгүй, үр дүнд зохицуулалт хангалтгүй.

3.Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтэд тавих хяналтын механизмыг сайжруулах шаардлагатай.

4.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнг Улсын Их Хурлаар хэлэлцэх хүрээ хязгаарыг оновчтой болгох, цаглаврын хувьд хууль хоорондын зөрчлийг арилгах шаардлагатай.

5.Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох, давтан болон гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах.

6.Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд Засгийн газрын гишүүд холбогдох албан тушаалтан мэдэгдэл, хариулт, арга хэмжээний талаарх үүрэг амлалтыг системтэйгээр бүртгэх, мэдээлэх, хянах, нэгтгэсэн механизм хангалтгүй.

7.Хяналт шалгах түр хорооны зарим зохицуулалтыг оновчтой, тодорхой болгох зэрэг сайжруулах асуудлууд байгааг дурдах нь зүйтэй.

Иймд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн явцад үүссэн хүндрэл, эрх зүйн хийдэл, давхардал, процедурын тодорхойгүй байдлыг арилгах, парламентын хяналтын үр нөлөөг чөлөөт бус үйл ажиллагааг зохицуулах хүрээнд Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл, Ж.Батжаргал, Б.Бейсен, Ч.Лодойсамбуу, У.Отгонбаяр, Д.Пүрэвдаваа, Ц.Сандаг-Очир, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн нарын гишүүдийн хамтаар Монгол Улс Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хамт өргөн мэдүүлэх төслийг боловсруулж 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдэгдлээ.

Хуулийн төсөлд тусгасан асуудлуудыг багцалж Та бүхэнд танилцуулъя.

Төрийн байгууллагуудын хяналт шалгалтын давхардлыг бууруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөлт, цаглаврын зохицуулалтыг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, хяналт шалгалтын цаглаварт санал өгөх, давхардлыг арилгах зорилгоор Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн холбогдох хэсгийг өөрчлөн найруулж, хяналт шалгалтын ачаалал, үр дүнгийн давхардлыг бууруулах санал боловсрууллаа.

Байнгын хороо, дэд хороодын хяналт шалгалтын ажлын зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хяналт шалгалтын ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх, дэд ажлын хэсэг байгуулах, эрх олгох ажлын хэсэг байгуулсан тогтоолын хавсралтаар ажиллах удирдамжийг хамтад нь батлах зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэх боломжтойгоор өөрчлөн найрууллаа.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой зааж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эсвэл хүчингүй болгох арга хэмжээ авах, биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх.

Шаардлагатай гэж үзвэл Үндсэн хуулийн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг хүчингүй болгох тодорхой 3 төрлийн арга хэмжээ авдаг байхаар өөрчлөн найрууллаа.

Монгол Улсын Үндсэн хуульд “хууль тогтоомжийн биелэлт” гэдэг ойлголтыг хууль тогтоомжийг сахин биелүүлэх, дагаж мөрдөх гэдэг утгаар хадгалж орчин үеийн парламентын хяналт нь

- ➔ хууль хэрэгжиж байгаа эсэх,
- ➔ хууль тогтоомж зорилтдоо хүрч байгаа эсэх,
- ➔ бодит өрнөлөө үзүүлж байгаа эсэх,
- ➔ эерэг, сөрөг дагавар үүсэж байгаа эсэх –

-зэргийг хамарсан өргөн хүрээний үнэлгээний тогтолцоо болон хөгжиж байгаа тул хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, “хуулийн хэрэгжилт” гэх ойлголтыг хэрэглэх, хууль тогтоомжийн үр дагаврын үнэлгээний нэгдсэн дүнг холбогдох Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэх, санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд.

Хууль зүйн байнгын хороо шалтгаан, үр дагаврын үнэлгээний хамт хэлэлцэн нэгтгэн нэгдсэн хуралдаанд оруулахаар тусгалаа.

Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийн хувьд холбогдох Байнгын хороонд эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэн, Улсын Их Хурлын биелэлт шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, Улсын Их Хурлын шийдвэр, холбогдох заалтыг хяналтаас хасах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналаа Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж, Төрийн байгуулалтын байнгын хороо 6 дугаар сарын 15-ны дотор нэгдсэн хуралдаанд оруулахаар тусгалаа.

Нэгдсэн хуралдаанд шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэхээр даалгах, эсвэл Улсын Их Хурлын шийдвэр, түүний холбогдох зүйл, хэсэг, заалтыг хяналтын бүртгэлээс хасахыг даалгахаар өөрчлөн найрууллаа.

Улсын Их Хурлын нэгдсэн, Байнгын дэд хорооны түр хорооны хуралдааны явцад Засгийн газрын гишүүн хуулиар тогтоосон бусад байгууллагын удирдлагаас өгсөн тоо тодорхой хугацаатай хэрэгжих боломжтой амлалтыг

бүртгэн хэрэгжилтэд хяналт тавих, амлалтын биелэлт хангалтгүй, эсхүл хугацаа хоцорсон тохиолдолд холбогдох Байнгын хороо тухайн албан тушаалтны мэдээллийг сонсож, шаардлагатай бол хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.

Үүрэг амлалтын бүртгэл, түүний хэрэгжилтэд хяналт тавих нарийвчилсан журмыг хэрэгжүүлэх зохицуулалтыг шинээр нэмлээ.

Давтан хяналтын журам тогтоох буюу хяналт шалгалтын үр дүнг санал, дүгнэлт гарснаас хойш тодорхой хугацааны дараа давтан хянах зохицуулалтыг шинээр тусгасан.

Энэ нь Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг хянах үйл ажиллагааг сайжруулах бөгөөд цаашид цахим хяналтын систем, хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан хянах боломжийг бүрдүүлнэ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнг Улсын Их Хурал хэлэлцэхдээ үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээний биелэлтээр бус зорилго, зорилтын түвшин, нийгэм, эдийн засаг, салбарын үндсэн үзүүлэлтээр гарсан өөрчлөлт иргэдийн амьдралд үзүүлсэн үр нөлөөгөөр үнэлэх 2 түвшний аргачлалыг хэрэглэдэг болох эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр тусгалаа.

Мөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг Улсын Их Хурлаар хэлэлцэх, тайлагнах хугацааг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан цаглавартай нийцүүлэх замаар бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн уялдаа хариуцлагыг сайжруулах өөрчлөлтийг орууллаа.

Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд Хянан шалгах түр хороо байгуулах, бүрэлдэхүүнийг томилох, татан буулгах, шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой одоогийн зохицуулалт тодорхой бус, практикт хүндрэл үүсгэж байгаа тул процедурын зохицуулалтыг нарийвчилсан тодорхой болгохоор тусгалаа.

Тухайлбал,

- Түр хороо тогтоолын төслүүдийг өргөн мэдүүлсэн дарааллаар хэлэлцэх.
- Түр хорооны бүрэлдэхүүнд олонх, цөөнхийн төлөөллийг бодитой хангах.
- Ашиг сонирхлын зөрчилтэй гишүүн оролцохоос сэргийлэх.
- Түр хорооны тогтоол гаргах асуудал, хүрээг тодорхойлох.
- Түр хороо тайлангаа танилцуулснаар татан буугдсанд тооцох –

-зэрэг харилцааг тодорхой зохицууллаа.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд хянан шалгах шинжээчийг –

- сонгон шалгаруулах,
- санал болгох,
- томилох,
- ашиг сонирхлын зөрчлийг шалгах,
- хариуцлага тооцох зохицуулалт хангалтгүй байгааг нарийвчлан зохицуулсан.

Тухайлбал, хянан шалгагч шинжээчид тавигдах –

- мэргэжлийн болон ёс зүйн шаардлага,
- ашиг сонирхлын зөрчилгүй байх,
- баталгаа,
- томилгоо,
- чөлөөлөх журам,
- ажлын даалгавар,
- бүрэн эрхийн хүрээ,
- хараат бусаар дүгнэлт гаргах нөхцөл,
- мэдээллийн нууцлал,
- хариуцлагын зохицуулалтыг тодорхой болгох,
- хяналт шалгагч, шинжээчийн эрх зүйн байдлыг нарийвчлан зохицуулахаар тусгалаа.

Хянан шалгах түр хорооны нотлох баримт шинжлэн судлах, сонсголын тусгай журмыг нарийвчлан тогтоосон бөгөөд –

- ▶ гэрчийг дуудах үндэслэл,
- ▶ мэдэгдэх хуудасны агуулга,
- ▶ сонсголын дараалал,
- ▶ сонгогчдын эрх, үүрэг,
- ▶ хянан шалгагчийн тайлан,
- ▶ шинжээчийн дүгнэлт сонсох ажиллагаа,
- ▶ гэрчээс асуулт асуух, хариулт авах сонсголын ёс зүй, дэгийг тусгайлан зохицууллаа.

Эцэст нь Хянан шалгах түр хороо үйл ажиллагааныхаа үр дүнг Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулсан бол холбогдох Байнгын хороонд танилцуулж, Түр хороо тайлан, санал, дүгнэлт болон шийдвэрийн төслөө холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтээр нэгдсэн хуралдаан танилцуулж шийдвэрлүүлэхээр зохицуулалтыг тус тус тусгалаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Жавхлан: Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Баттөмөрийн Энхбаяр гишүүнээр тасаллаа.

Баттөмөрийн Энхбаяр гишүүний микрофоныг нээе. Асуулт.

Б.Энхбаяр: Манай улс ер нь нийгмийн амьдралыг хуулиар засаглах дэг журам тогтоох энэ ажлыг төлөвшүүлэхийн тулд хууль санаачлах эрх бүхий этгээд, Засгийн газар, Их Хурлын гишүүд хууль тогтоох институт маань бас нэг ийм манлайллыг би үзүүлж яваасай гэж их олон дахин удаа яриад байгаа.

Сая Хууль зүйн сайдаар баталж байх үед Засгийн газраас боловсруулж байгаа хуулийн төслүүдэд ер нь журам батлах гэдэг хэм хэмжээ заасан ийм эрх олгосон хуулийн төслүүдийг ерөөсөө зөвшөөрөл өгөхгүй, аль болох процессыг нь бичиж байх ийм тал руу их тийм шаардлага тавьж ажиллаж байсан юм.

Нөгөө талд хуулийн хэлэлцүүлгийн явцад энэ журам батлах эрх аягүй их орж ирдэг юм байна лээ, гишүүдээс. Юм аа хараад энэ журмаар зохицуулья гээд.

Энэ дотор бас их журмууд байна. Энэ дотор. Тэр дотроо хууль тогтоох институтээс Тамгын газар эрх шилжүүлсэн ийм журмуудыг би зөвшөөрөмгүй байна. Түрүүн Б.Баасандорж дарга чинь бараг Их Хуралтайгаа тэмцэж явж байгаад халтираад унасан шүү дээ.

Даргаа ч алаад, өөрийгөө ч алаад ингээд халтирсан.

Тэгээд би өөрт нь аягүй их сануулдаг байсан байхгүй юу.

Тэгээд энэ дээр одоо жишээлбэл миний харж байгаагаар л лав хоёр, гурван журам байна. Жишээлбэл, амлалтын бүртгэл хийгээд, амлалтын бүртгэл, түүний хэрэгжилтэд хяналт тавих нарийвчилсан журмыг Их Хурлын дарга батална гээд.

Энэ “амлалтын бүртгэл” гэж юу яриад яваа юм бол? Үүнийг журмаар хянадаг болоод. Энэ нэг амлалт авсан хүмүүсийг л алж хяддаг л нэг журам байх шиг байна даа. Нэг ийм журам байна. Энэ хэн нь ч байж магадгүй юм шиг байна.

Дараа нь Их Хурлын Тамгын газрын даргад аягүй том эрх өгсөн байх юм. Жишээлбэл, Засгийн газрын өргөн мэдүүлсэн тайланг буцаах эрхийг Тамгын газрын даргад өгсөн байх юм.

Энэ чинь хууль санаачлах эрх бүхий институт яваад байгаа байхгүй юу. Үндсэн хуулиар хуульчлагдсан.

Засгийн газар Их Хуралтай харьцах ёстой болохоос Засгийн газрын өгсөн тайланг ажлын албаны дарга буцаагаад байх ийм эрх хэмжээ хуулиар өгч болохгүй байх гэж бодож байна.

17-гоос 20 дугаар зүйлд заасан хяналт тавих журмуудыг Тамгын газрын дарга батална гээд байгаа байхгүй юу. Хяналт, дүн шинжилгээ хийх журмыг.

Энэ журам чинь л өөрөө Тамгын газрын даргыг бараг Их Хурал болгоод хаячхаж байгаа байхгүй юу. Их Хурлаас том дарга болгож байгаа байхгүй юу. Энэ журмаар Засгийн газар, одоо тэр бүх юмнуудыг... /минут дуусав/

Б.Жавхлан: Хууль санаачлагч Ж.Бат-Эрдэнэ даргын микрофоныг нээе. Хариулт.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ 20.9 дээр энэ хуулийн 17.20 дугаар зүйлд заасан тайланд дүн шинжилгээ хийх журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална гэж. Энэ журамтай холбоотой.

Урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуультай холбоотой журам байж байгаа. Тэнд заасан журмыг л ийшээгээ. Тэнд заагдсаны дагуу л энд журам гэж л оруулсан. Өөрөөр хэлбэл “үнэлгээ хийх л журам” л даа. Тийм.

Ер нь тантай санал нэг байгаа. Жишээ нь, би ажлын хэсэг удирдаад хууль боловсруулах хүрээнд дандаа журмуудыг ерөнхий гол гол санаануудыг нь хуульдаа тусгахгүй бол журмыг хэн нэгэн эрх мэдэл бүхий хүнд өгөөд, тэр нь цаашаагаа дураараа өөрчлөөд, дураараа журам зохиогоод батлаад явдаг нэг ийм зүйл болоод байгаа шүү дээ.

Тийм болохоор аль болох журмыг зохицуулж, хуульд нь процедур болгож суулгах гэдэг дээр санал нэг байгаа шүү.

Б.Жавхлан: Лувсаннямын Гантөмөр гишүүний микрофоныг нээе. Асуулт.

Л.Гантөмөр: Сүүлийн үед Засгийн газрын гишүүд болоод холбогдох албаны хүмүүст Их Хурлын дарга хуулийн заалт анхааруулаад байгаа.

Их Хурал дээр худлаа мэдээлэл хэлсэн тохиолдолд хуулийн ийм заалтаар хариуцлага хүлээнэ гээд. Яг энэ дагуу яаж хариуцлага хүлээлгэх вэ? Хамгийн сүүлийн жишээ махны нөөц хийгээгүй. Засгийн газар өнгөрсөн жил.

Тэгээд үүнийхээ үндсэн шалтгааныг түлш тасарсан гэдэг шалтгаан хэлж байгаа.

- Зарим хэсэг нь хулгай хийсэн гэж ярьж байгаа.
- Зарим нь бүлэглэн зохион байгуулсан гэж ярьж байгаа.

Тэгэхдээ эндээс бодитой харагдаж байгаа нь бол түлш тасарсан. Одоо яг түлш тасалсан хүмүүст нэгдүгээрт ямар хариуцлага тооцох вэ?

Хоёрдугаарт, холбогдох сайд нар махны үнийг чөлөөлнө гэсэн. Үнэ тогтоохгүй гэсэн. Маргааш нь Ерөнхий сайд махны үнэ тогтооно гэсэн.

Тэгээд хэн нь худлаа хэлсэн бэ гэдэг асуудал хөндөгдөж байгаа. Би зүгээр ойрын жишээ аваад байна л даа. Ийм зүйл бол маш олон удаа давтагдаж байна.

Иймэрхүү зүйлүүдийн хариуцлагыг ер нь хэрхэн хийх вэ гэдэг нэг дэх асуулт байгаа юм. Яг хариуцлага тооцогдлоо гэдэг нь хэзээ гарч ирэх юм?

Хоёр дахь асуудал бол Ашиг сонирхлын зөрчлийн хууль дээр илт зөрчил гарч байгаа тухай мэдээллүүд их яваад байгаа. Төрийн сайд улсын төсвийн хөрөнгийн ажлыг өөрийнх нь хамаарлын этгээдүүд авсан байна гээд. Зарим газар Их Хурлын тодорхой гишүүд Засгийн газар, төрийн албан хаагчид энд тэнд казинод тоглосон байна гэсэн мэдээлэл яваад байгаа.

Гэтэл хуулиараа төрийн албан хаагчид казинод тоглох хориотой. Жишээлбэл, гадаадад казино тоглож байгаа тэр нөхдүүдийн тухай мэдээллийг ер нь манайх авч байгаа юм уу гэдэг ийм асуулт байгаа юм.

Ер нь энэ ашиг сонирхлын зөрчлийн хуулийн хэрэгжилтийн хяналтыг бид ер нь хэрхэн хийх юм бэ гэдэг асуулт байгаа юм. Бид хэрэг мөрдөн шалгая гээгүй. Тодорхой зөрчил илэрсэн тохиолдолд төрийн өндөр албан тушаалтнууд хариуцлага хүлээх үү, хүлээхгүй юу гэдэг асуудал байгаа.

Тэгээд энэ болгон дээр сонсгол хийгээд явна гэхээр аягүй төвөгтэй байна л даа.

Жишээлбэл, Н.Өнөрцэцэгт төрийн нууц дамжуулсан этгээд өнөөдөр хүртэл ямар ч ял аваагүй. Сэтгүүлч Н.Өнөрцэцэгт. Бүгд мэдэж байгаа. Н.Өнөрцэцэг ял авсан. Хариуцлага байхгүй. Хэнд ч хариуцлага яригдахгүй гээд ийм тодорхой зүйлсээ бид сонсголгүйгээр шийддэг боломжууд... /минут дуусав/

Б.Жавхлан: С.Бямбацогт даргын микрофоныг өгье. Хариулт.

С.Бямбацогт: Тийм. Л.Гантөмөр гишүүний ярьж байгаа асуудлууд үнэн.

Яах аргагүй бид шийдэх ёстой тулгамдсан асуудлууд. Тийм ч үүднээсээ 2019 онд бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийхдээ Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг нэмэгдүүлсэн.

Үүнийхээ хүрээнд 2020 онд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай гэж анхдагч хуулийг баталсан.

Энэ хууль маань 5 жилийн хугацаанд, 6 жилийн хугацаанд хэрэгжээд явж байх явцад ямар алдаа дутагдал гараад байна, ямар асуудал нь орхигдсон байна гэдэг дээр дахиад нэг апдэйт хийгээд энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт өргөн барьж байгаа юм. Хяналт шалгалтын тухай хууль.

Таны ярьж байгаа –

- ▶ Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандах, худлаа мэдээлэл өгөх, өгсөн үүрэг чиглэлийг биелүүлэхгүй байх зэрэг асуудлуудыг тодорхой тусгаад өгсөн.
- ▶ Улсын Их Хурлын тухай хуулийн 21.31 дээр үл хүндэтгэсэн этгээдэд холбогдох хариуцлага хүлээлгэхээр томилсон эрх бүхий этгээд нь албан бичиг илгээнэ. Томилсон эрх бүхий этгээд нь ямар арга хэмжээ авсан талаараа заавал бичгээр хариу мэдэгдэнэ гээд оруулаад өгсөн.
- ▶ Хяналт шалгалтын тухай хуулийн 16.14 дээр амлалтын бүртгэл, түүний хэрэгжилтэд хяналт тавих гээд Улсын Их Хурал дээр сайд нар би дутуу мэдээллээ гүйцээж хариулъя. Дутуу мэдээллээ бичгээр өгнө гэж хэлдэг. Үүнийг нь нэг бүрчлэн бүртгэнэ. Бүртгээд тэр бүртгэлийн дагуу хариулт ирж байх ёстой. Ирэхгүй бол чуулганы хуралдаанд асуултад гүйцэд хариулаагүй, буруу хариулаад, түүнийгээ засаж залруулах мэдээллээ албан бичгээр ирүүл гээд ирүүлсэн, ирүүлээгүй нь хянадаг, бүртгэдэг. Бүртгэж байгаад эргүүлээд хариуцлага тооцдог болох зохицуулалтууд орж байгаа.

Дээрээс нь Л.Гантөмөр гишүүн өөрөө мэднэ. Асуулга, асуулт тавьдаг байсан. Асуулт. Энэ үндсэндээ нэлээд суларсан. Урьд нь Байнгын хороон дээр асуулт тавиад, хэлэлцүүлээд тухайн махны үнийн асуудлаар хулгайлсан юм уу, хулгайлаагүй юм уу, үнэ өссөн, яагаад өсөв, өссөн нь хэн буруутай вэ гэдэг асуудал дээр чуулган дээр асуулга тавиад Нийслэлийн Засаг даргаас, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас, тэгээд Засгийн газар дээр сар болгоны нэг дэх, гурав дахь долоо хоногт асуулгын цаг гэж хэлэлцдэг байсан. Энэ хэрэгжихээ больчихоод байгаа юм.

Одоо энэ Хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль, дэгийн тухай хуулиараа үүнийг нээж байгаа.

Сар бүрийн нэг дэх, гурав дахь долоо хоногийн 14.00 цагаас Улсын Их Хурлын гишүүний асуулга хэлэлцдэг болно.

Мөн тодорхой нийгэмд бухимдал үүсгэсэн, тулгамдсан асуудлаар Баасан гарагийн даргын зөвлөлийн хурал дээр яаралтай хэлэлцээд, ерөөсөө энэ асуудлыг, иргэдийн анхаарал татсан, бухимдал дагуулсан асуудал байгаа учраас Байнгын хороон дээр хэлэлцүүлэг хийе, эсвэл чуулган дээр мэдээлэл сонсъё гэдгээ шийдээд маш хурдан шуурхай ажиллах боломжуудыг нээж өгч байгаа.

Мөн чуулган болон Байнгын хорооны хуралдаанууд дээр бид мэтгэлцээний цаг, асуусан асуултад хангалттай хариулахгүй бол хариултыг 1 минутаар асуугаад, 1 минутаар хариулах дэгээр зохицуулж болно. Тодорхой хугацаагаар шууд мэтгэлцээний горимд шилжүүлээд мэтгэлцдэг. Заавал асуулт асууж,

хариулт авах дэгээр биш чөлөөтэй асуудал хариуцаж байгаа асууж байгаа нөхдүүд нь мэтгэлцэх.

Иймэрхүү зохицуулалтыг оруулж өгснөөрөө илүү парламентын үйл ажиллагаа ил тод, илүү чанартай, илүү мэтгэлцээнтэй, илүү ажил хэрэгч болох.

Дээрээс нь эргээд хууль маань хэрэгждэг байх. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих парламентын хянан шалгах чиг үүрэг.

Улсын Их Хурлын гишүүний үндсэн 3 эрх байгаа шүү дээ.

- Төлөөлөх эрх.
- Хууль тогтоох эрх.
- Хуульд хяналт тавих эрх.

Энэ хяналт тавих чиг үүрэг маань хангалтгүй хэрэгжээд байгааг илүү чанартай чамбай болгоё гэдэг үүднээс иймэрхүү заалтуудыг Хяналт шалгалтын тухай хуульд оруулж өгсөн.

Б.Жавхлан: Ж.Бат-Эрдэнэ дарга нэмэлт хариулт. Микрофоныг нээе.

Ж.Бат-Эрдэнэ: Л.Гантөмөр гишүүний сонирхолтой асуулт энд байх шиг байна.

Нэгдсэн чуулган, эсвэл Байнгын хороо, дэд хороон дээр Засгийн газрын гишүүд болоод эрх бүхий байгууллагын дарга, албан тушаалтан тодорхой хэмжээний мэдээлэл өгөөд, эсвэл амлалт авдаг.

Энэ асуудлыг би ингэж ингэж тийм хугацаанд буцаж танд хариу хэлье, танд бичгээр явуулъя, эсвэл би буцаад эргээд танилцуулна ч гэдэг юм уу ийм амлалтууд аваад, өөрөөр хэлбэл яг энэ чуулганы танхимд асуултыг хаагаад явдаг тохиолдол байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг бүртгэж авъя гэж байгаа юм. Бүртгэж аваад үүндээ хариуцлага тооцоод, буцаж эргэж асуултыг нь сонсдог, асуултыг нь хянадаг. Хэрвээ хариуцлагагүй дутуу байвал дахиад Байнгын хороо хэлэлцдэг ч байдаг юм уу, эсвэл бүр шаардлагатай бол албан тушаалтанд хариуцлага тооцдог ийм систем рүү орёе гэж байгаа юм. Нэг.

Хоёрдугаарт, таны яриад байгаа тэр махтай холбоотой асуудал ч юм уу. Үнэн... /минут дуусав/

Б.Жавхлан: Нэмэлт хариулт.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь Улсын Их Хурлын нэгдсэн чуулган, тэгээд дээрээс нь Байнгын хороон дээр худал үнэн нь мэдэгдэхгүй зүйлүүдийг ярьж байгаа. Улсын Их Хурлын гишүүд болоод бусад хариуцлагатай хүмүүсийн амнаас гарч байдаг.

Энэ болгонтой хариуцлага тооцно гэхээр бас энэ чинь цаанаасаа тодорхой хэмжээний төлөөлөлтэй, тодорхой хэмжээний хянан шалгах үйл ажиллагаа явуулах боломж бололцоо харагдахгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр яагаад бид 126 гишүүнтэй холимог тогтолцоотой Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан юм бэ. Энэ чинь олон намын тогтолцоо бий болж байгаа шүү дээ.

Олон намын тогтолцоо бий болно гэдэг чинь өөрөө энэ парламент болоод, өөрөө Засгийн газраа хянах ийм тогтолцоо бүрдээд байгаа байхгүй юу даа. Хэрэв худлаа ярьж л байгаа бол дараагийн нам нь босож ирээд л энэ дээр тодорхой хэмжээний хариуцлагын асуудлуудыг сөхөөд явах ийм боломж бололцоо чинь нээгдэж байгаа болохоор өнөөдрийн энэ 126 гишүүнтэй холимог тогтолцоо буюу олон намын тогтолцоо чинь бидний бас эрүүл байх нөхцөлийг биелүүлээд, худлаа хэлэхгүй байх нөхцөлийг биелүүлж байгаа л гэж хараад байгаа шүү дээ.

Б.Жавхлан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр суурь илэрхийлэх, үг хэлэх гишүүд байна уу? Лувсаннямын Гантөмөр гишүүнээр тасаллаа. /алх цохив/

Л.Гантөмөр гишүүний микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Хяналт шалгалтын ажлаа зөв болгоод эрчимжүүлэх гэж байгааг бол дэмжинэ.

- Сонсголыг илүү олон хийдэг болох хэрэгтэй.
- Илүү чанартай хийдэг болох хэрэгтэй.
- Сонсголын хугацааг бол илүү урт тавиу болгох хэрэгтэй.

Яагаад гэвэл мөрдөн шалгах ажиллагаа чинь гуравхан сар юм уу, ганц сарын хугацаанд хийгдэхээр дутуу дулимаг хийгдээд байна. Үр дүн гарахгүй байна. Их урт хугацаанд нарийн шалгах ёстой маш ноцтой гэмт хэргүүд сүүлийн үед маш их хэмжээгээр сонсогдож байгаа.

Тийм учраас би хяналт шалгалтын сонсгол хийх ажлыг нэг чуулганы хугацаанд хоёрыг хийнэ. Тэрийг чуулганыхаа хугацаанд барагдуулна гэдэг зүйлийг Та бүхэн маань хэлэлцүүлгийн явцад олшруулах боломжийг гаргаж өгөөрэй гэж хүсмээр байна.

Дээр нь хугацааг нь бүрэн эрхийнхээ хугацаанд хяналтын энэ мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжийг парламентдаа гаргаж өгөөсэй гэж хүсэж байна.

Тэгээд ингээд багц хууль явж байгаа учраас нэг жижигхэн зүйл хэлмээр байгаа юм.

Их Хурлын гишүүд тодорхой асуудлыг дэмжиж, дэмжихгүй үг хэлэхдээ индэр дээр очиж үг хэлдгийг болиулах хэрэгтэй.

Монгол Улсын Их Хурлын гишүүн өөрийнхөө сууж байгаа суудал дээрээс үгээ хэлэх эрхтэй баймаар байна. Тэгэхгүй бол нэг тийм жижгэрсэн нөхцөл байдал харагдаад байгаа байхгүй юу. Засгийн газрын гишүүн нь сууж байдаг. Их Хурлын гишүүн нь тэр асуудлыг дэмжихгүй байна гэдгээ хэлэхдээ босоод үгээ хэлээд явж байдаг ийм зүйлийг та хэд маань зүгээр хэлэлцүүлгийн явцад тэр хэсгийг, суудал дээрээсээ үгээ хэлэх боломжуудыг нь гаргаж өгөөрэй гэж хүсье. Баярлалаа.

Б.Жавхлан: Баярмагнайн Баярбаатар гишүүн дэмжиж үг хэлнэ.

Б.Баярбаатар: Монгол Улсын парламент 2018 оноос хойш энэ хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ хэрэгжүүлээд, хууль эрх зүйн орчныг нь бий болгоод өнөөдөр тодорхой түвшинд хяналтыг хэрэгжүүлээд эхлээд явж байгаа.

Жишээлбэл, 2024 оноос хойш парламент Оюу Толгой, газрын ховор элемент гээд сонсголуудыг хийсэн. Түр хороо байгуулагдаад ажилласан.

Парламентын дархлаа гэж Улсын Их Хурлын гишүүн –

- төлөөлөх эрхтэй,
- үзэл бодлоо илэрхийлж үгээ хэлэх эрхтэй,
- хяналт хэрэгжүүлэх эрхтэй.

Үндсэн 3 чиг үүрэг. Энд хэн ч нөлөөлж болохгүй, хэн ч халдаж болохгүй. Үүнийг парламентын дархлаа гэж нэрлэж байгаа юм.

Тэгэхээр парламент өнөөдөр хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг аль болох улс төрийн зэвсэг болгож хэрэглэхгүй байх нь зөв гэж харж байгаа. Үнэхээр хууль зөрчсөн үйлдэл байх ёстой байна уу, үгүй юу гэдэг дээр.

Зарим тохиолдолд улс төржүүлсэн байдлаар асуудалд хандаж байгаа зүйл ажиглагдаад байгаа. Энэ нь өөрөө парламентынхаа дархлаанд өөрсдөө халдаж байгаа хэлбэр байхгүй юу.

Тэгэхээр энэ хууль илүү чанаржиж, ер нь аливаа асуудал өмнөхөөсөө дандаа чанаржиж байх ёстой гэж харж байгаа.

Би өнгөрсөн хугацаанд Хууль зүйн байнгын хороон дээр энэ Эпштейн гэдэг нөхөртэй холбоотой Монгол Улсын төрийн тэргүүнүүд холбогдсон баттай эх сурвалжаас авсан мэдээ мэдээллийг хүргэж байсан.

Тэгээд энэ талаараа өнгөрсөн хугацаанд чамгүй судалгааг хийж, холбогдох материалуудыг бүрдүүлж, өнөөдөр нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд гарын үсэг зурж, бичиг хэргийн шугамаар Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт даргад өргөн барьсан. Удахгүй Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж нээлттэй сонсголын асуудал явах байх.

Тэгээд бид энэ түр хороо байгуулах, нээлттэй сонсгол гэсэн хоёр зүйлээ ялгаж салгаж иргэдэд зөв ойлгуулах ёстой. Нээлттэй сонсгол мөрдөн байцаах чиг үүрэг байхгүй. Холбогдох эксперт, шинжээчдийг томилж үнэлгээ хийж, тэрийгээ иргэдэд нээлттэй сонсгол хэлбэрээр явуулдаг.

Түр хороо бол мөрдөн байцаах чиг үүрэг бүхий. Хугацааны хувьд гэхэд нэг нь 45 хоног, нэг нь 6 сарын хугацаанд ажиллана гэсэн ийм ялгаатай зүйлүүд байгааг бас зөв ойлголтыг өгч анхаарч ажиллах ёстой юм байна гэдгийг манай Байнгын хорооны гишүүд цаашдаа анхаараад явах нь зөв байх гэж бодож байна.

Тэгээд хуулийн төслийг бүхэлд нь дэмжиж байна. Баярлалаа.

Б.Жавхлан: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 13 гишүүн дэмжиж, 61.9 хувиар санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ гишүүнийг дэмжсэнээр оруулж тооцъё. Хууль санаачлагч өөрийгөө дэмжих байлгүй дээ. Тийм ээ.

2.Хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

3.Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

4.Хамт өргөн мэдүүлсэн Төрийн аудитын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

5.Хамт өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

6.Хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

7.Хамт өргөн мэдүүлсэн “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 14 гишүүн дэмжиж, 66.7 хувиар уг санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа гишүүн танилцуулна.

Дараагийн асуудал оръё.

**Тав.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир нарын 4 гишүүн
2026 оны 05 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/**

Тав.Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир нарын 4 гишүүн 2026 оны 5 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир танилцуулна. /алх цохив/

Д.Бум-Очир гишүүний микрофоныг нээе.

Д.Бум-Очир: Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн Тухай Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг Төрийн байгуулалтын байнгын хороонд хийж байна.

Уг төслийг Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир, Ч.Анар, Ж.Золжаргал, Ж.Баярмаа нарын гишүүд 2026 оны 5 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Сонгуулийн үндсэн зарчмын нэг болох бүх нийтийн байх, бүх нийтийн оролцоог бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага байсаар байгаа нь сонгуульд оролцож буй сонгогчдын ирц, оролцоо сонгуулиас сонгуулийн хооронд тогтмол буурч байгаа дүнгээс харагдаж байна.

Тухайлбал, 2021 онд 59.2 хувь болж буурчээ.

Сонгуулийн ирц оролцоо буурч байгаа гол шалтгаан нөхцөлийг тодорхойлох зорилгоор Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос 2025 онд 21 аймаг, 330 сумын нийт 11 мянга 700 сонгогчийг хамруулсан сонгогчийн зан төлөвийн судалгааны тайланд дурдсан үр дүнгээс үзвэл сонгуульд оролцоогүй шалтгааны 33.9 хувь нь санал авах өдөр байнгын оршин суугаа газраасаа өөр

газарт байсан, 7.7 хувь нь оюутан орон нутагт оршин суух хаягтай, 0.5 хувь нь гадаад улсад байсан зэрэг шалтгаантай байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 77 дугаар тогтоол гарч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гадаад улсад суугаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа боловч сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хаягаас өөр газарт байгаа иргэн, оюутан, суралцагчид, сонгуулийн санал авах өдөр албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч, уртын ээлжээр ажиллаж байгаа ажилтан зэрэг сонгогчдын сонгох эрхийг эдлүүлэх, санал өгөх боломжит хувилбарыг тодорхойлж эрх зүйн орчныг бий болгох талаар санал боловсруулахыг үүрэг болгосон болно.

Хуулийн төслийг дээр дурдсан үндэслэл, шалтгаан, Улсын Их Хурлын тогтоолд үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгав. Үүнд,

1.Гадаад улсад байгаа иргэд санал өгөхдөө урьдчилан бүртгүүлэхгүй бөгөөд сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал өгөх боломжийг бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

2.Санал авах өдөр саналаа өгөх боломжгүй сонгогчийн саналыг урьдчилан авах төрөл, хэлбэрийг нэвтрүүлэх, түүнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

3.Санал авах өдөр тухайн сонгогчийн харьяа хэсгийн хороо, хамаарах аймаг, нийслэлээс өөр нутаг дэвсгэрт байгаа сонгогчийн саналыг авах, түүнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Мөн хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээнээс шалтгаалан дагалдан гарах хуулийн төсөл боловсруулах шаардлагатай.

Тухайлбал, санал авах төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэхдээ сонгуулийн автоматжуулсан систем, түүнд хамрагдах тоног төхөөрөмжийг судлах, тодорхойлох, баталгаажуулах зэрэг чиг үүргийг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн чиг үүрэгт нэмэлтээр тусгах зорилгоор Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай дагалдан гарах хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Жавхлан: Баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Сонгуулийн ерөнхий хороо. Даваанямын Даваа-Очир Сонгуулийн ерөнхий хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд нарийн бичгийн дарга, Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга.

Улсын бүртгэлийн ерөнхий газар. Содномын Чинбат Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл, технологийн газрын дарга, Нямдагийн Наранцэцэг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газрын дарга.

Гадаад харилцааны яам. Батсүхийн Биндэръяа Консулын газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Оргиохүүгийн Эрдэнэсамбуу Консулын газрын зөвлөх.

Хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Л.Гантөмөр гишүүнээр тасаллаа. Ирцээрээ Лувсаннямын Гантөмөр гишүүний микрофоныг нээе. Асуулт.

Л.Гантөмөр: Өнгөрсөн Ерөнхийлөгчийн сонгуулиар хийж чадахгүй байсан техник, технологийн асуудлыг одоо шийдээд Их Хуралдаа оруулж ирж байгаа юм байна гэж ингэж ойлгож байна. Зөв үү?

Д.Даваа-Очир дарга энэ дээр одоо яг бодит байдал хэлмээр байна.

- Та нар сонгууль болохоос өмнө саналын хуудсаа хэвлэж дуусах уу?
- Хэд хоногийн дотор гадаадад хүргэх вэ?
- Хэзээ гадаад улсуудад цахим машинаа хүргэж байршуулах вэ?
- Хэдэн цэг дээр байршуулах хүчин чадал байгаа вэ?

Энд маш тодорхой хариулт хэлмээр байна. Хэрвээ ийм боломж 2021 онд байгаад тэр үед хэрэглээгүй. Одоо 2027 онд хэрэглэх гэж байгаа бол өмнөх сонгуулийн бүрэн эрхийн асуудал хөндөгдөнө.

Хоёрдугаарт, манай иргэний бүртгэлийнхэн өмнө нь яагаад зөвхөн хаяг дээрээ санал өгдөг байж байгаад одоо хаяг хамаагүй болох гэж байна гэдэг дээр тайлбар өгмөөр байна.

- Та нар тэр блокчэйнийг хийсэн үү, хийгээгүй юу?

Сонгуулиар болдог хамгийн будилаантай юм бол хоёр, гурван хаяг дээр очиж санал өгдөг байсан.

2004, 2008 оны сонгуулийн үед гараараа тоолдог байсан. Сүүлдээ хоёр, гурван газраар тойрч санал өгдөг болсон.

Тийм учраас хүн болгон байгаа байгаа газраа саналаа өгье гэдэг ийм зүйл рүү л явсан юм л даа.

- Та бүхэнд гаргасан дэвшил байна уу?
- Нэг хүн хоёр газар санал өгөхгүй гэдэг баталгааг иргэний бүртгэлийнхэн өгч чадах уу?

Ер нь Иргэний бүртгэлийн ерөнхий газар сонгуулийн орой дэвхцээд шампанск задалж байсан олон удаагийн яриа байгаа. Будилааны гол эзэд тэнд байгаа гэж олон хүн хардаж байгаа.

2021 оны сонгуулийн дараа энэ олон хүн байгаа байгаа газраа санал өгөөд, хоёр, гурав давхардсан санал өгөхөөр арынхаа хариуцлагыг яг Та бүхэн хүлээж чадах уу гэдэг ийм асуултад бүрэн хариулж байж энэ цаашаа явах ёстой шүү.

Д.Бум-Очир гишүүн –

- Яагаад Ерөнхийлөгчийн сонгууль руу давхиад орчхов оо?
- Хэн захиалав аа?
- Хаанаас гаргасан шийдвэр вэ?
- Ямар туршлага дээрээ үндэслэв ээ?

Би эрхэм гишүүний бүрэн эрхийн тухай ярихгүй байгаа. Ямар судалгааны үр дүнд хэчнээн сонгуульд оролцоод ийм том хууль руу улс төрийн намуудын зөвшилцөлгүйгээр, улс төрийн намуудын ойлголцолгүйгээр давхиад орчхов. Та. Хэний хүсэлт байна аа?

Б.Жавхлан: Гишүүний асуултад хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Дуламын Бум-Очир гишүүн хариулна. Микрофоныг нээе.

Д.Бум-Очир: Гишүүний сүүлчийн асуултад хариулъя.

Яагаад миний бие энэхүү хуулийг санаачлах болов гэдэг асуулт байна. Их Хурлын энэ удаагийн чуулган нээгдсэний дараахан хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлөөс хилийн чанад байгаа Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах лобби бүлэг байгуулж өгөөч ээ гэдэг ийм хүсэлт ирсэн.

Энэ лобби бүлгээ намайг ахалж өгөөч ээ гэдэг ийм хүсэлт ирсний дагуу бид дэмжих бүлэг байгуулаад хилийн чанад дахь Монголчуудын зүгээс хэд хэдэн асуудлыг шийдвэрлэж өгөөч ээ гэж бидэнд хүсэлт ирүүлсэн. Тэрний нэгдүгээрт нь сонгуульд оролцох эрхийг нээж өгөх, боломжийг өргөжүүлж өгөх ийм хүсэлт ирсэн юм.

Ингээд энэ хүсэлтийн дагуу үндсэндээ судалж ажил хэрэг болгох гэж явсан. Энэ хүрээнд Цахим бодлого, инновацын байнгын хороон дээр хилийн чанад дахь

монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, цахимаар сонгууль өгөх боломжийг судлан санал, дүгнэлт танилцуулах ажлын хэсэг байгуулагдсан.

Энэ ажлын хэсэгт мөн дэмжлэг үзүүлэх бүрэлдэхүүн 16 байгууллага оролцсон.

Ингээд өнгөрсөн жилийн хугацаанд манай Их Хурлын эхний жил, түүнээс хойших 2 дахь жил рүү орсон. Ингээд энэ хугацаанд үндсэндээ энэ боломж бололцоог судлаад тэгээд өнөөдөр энэхүү хуулийн төслийг өргөн барих нөхцөл бүрэлдсэн.

Энэ ажлын хэсгийг миний бие ахалж байсан. Түүнчлэн Цахим бодлого, инновацын дэд хорооны дарга Ч.Анар гишүүн бас энэ хуулийг хамтран өргөн барих ийм нөхцөл бололцоо бүрдсэн юм.

Б.Жавхлан: Ажлын хэсгээс харин нэмэлт хариулт өгнө дөө. Улсын бүртгэлийн ерөнхий газраас. Ажлын хэсгийн 5 номерын микрофоныг нээх юм байна шүү.

Дараа нь Сонгуулийн ерөнхий хороо бэлдэж байгаарай.

Н.Наранцэцэг: Л.Гантөмөр гишүүний асуултад хариулъя.

Улсын бүртгэлийн байгууллага 2012 оноос эхлээд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үүссэн үндэслээд сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх үйл ажиллагааг зохион байгуулан явуулж байна.

2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр иргэний улсын бүртгэлийн нэгдсэн сан сүлжээтэй холбох асуудлыг шийдвэрлэсэн байж байгаа.

Тэгэхээр зэрэг одоо бид нэгдсэн сангаасаа сонгогчийн мэдээллийг дуудаж сонгуулийн санал авах өдөр бүртгэлийн хуудас болгож баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулаад явуулж байгаа.

Дашрамд хэлэхэд 2024 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасны дагуу хүсэлт гаргасан эрх бүхий нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгсөн байгаа. /минут дуусав/

Б.Жавхлан: Хариулт болсон уу? Сонгуулийн ерөнхий хороо. Хэдэн номер юм? Номероо өргөөрэй. Ажлын хэсгийн 4 номерын микрофоныг нээе.

Д.Даваа-Очир: Л.Гантөмөр гишүүний асуултад хариулъя.

Бид Д.Бум-Очир гишүүнтэй жил гаруй энэ төсөл дээр ажилласан. Өнөөдрийн байдлаар гадаадад 172 мянган Монгол Улсын иргэн, сонгуулийн насны иргэд ажиллаж амьдарч байгаа.

Энэ амьдарч байгаа 52 дипломат төлөөлөгчийн газар ICP (ImageCast Precinct), хамгийн сүүлд бид шинээр тооцож ашиглах гэж байгаа ICX (ImageCast X) төхөөрөмжийг энэ хуульд заасан хугацаанд нь бид хүргэх бүрэн бололцоотой гэж тооцоолол гаргаад энэ дээрээ ажиллаж байгаа.

Б.Жавхлан: Ажлын хэсгийн 4 номер. Нэмэлт тайлбар.

Д.Даваа-Очир: Хоног бол ер нь сонгууль эхлэхээс 5 хоногийн өмнө бид тоног төхөөрөмж, холбогдох материалуудаа аваачаад байршуулах бүрэн бололцоотой.

Энэ дээр бүртгэлийн нэгдсэн сан, сонгогчийн нэрийг нь жагсаалт бүрдээд цуг очоод ажиллах бололцоотой гэж үзэж байгаа. Гадаадын 52 дипломат төлөөлөгчийн газар, 172 мянган хүнд хамрахаар ийм зохион байгуулалтын арга хэмжээ авахаар урьдчилж тооцоод бэлтгэл ажлаа хангаад явж байгаа.

2021 онд бид ерөнхийдөө урьдчилсан сонгууль авсан шүү дээ. 47 дипломат төлөөлөгчийн газраас санал аваад, холбогдох журмынхаа дагуу саналын хуудсаа хүргээд, буцаж аваад дүнгээ гаргасан байгаа. Тийм.

Б.Жавхлан: Минут дууссан. Доржзовдын Энхтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Энхтуяа: Нэрээ татсан.

Б.Жавхлан: Өө., ёстой мундаг гишүүн шүү.

Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд байна уу?

Л.Гантөмөр гишүүн горимын санал. /алх цохив/

Л.Гантөмөр: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Энэ сонгуулийн хуультай холбоотой асуудлыг улс төрийн нам бүлгүүд эхлээд ярих нь зөв өө. Ямар ч тохиолдолд. Энэ хүмүүсээс мэдээллийг нь их нарийвчилж авах хэрэгтэй.

Тийм учраас Ардын намын бүлэг ч гэсэн өөр дээрээ ярих ёстой. Яг ийм зохион байгуулалт хийж чадах уу, болох уу, техникийн хувьд боломжтой юу.

Дээр нь энэ мэдээллийн сан чинь өөрөө найдвартай байгаа юу гэх мэтчилэн.

Тэгэхээр би хувьдаа Ардчилсан намын бүлгээр энэ асуудлыг хэлэлцэж байж Төрийн байгуулалтын байнгын хороон дээр Ардчилсан намын гишүүд саналаа өгөх боломж нээгдэхээр харагдаж байна.

Тийм учраас нам, эвслийн бүлгүүд хэлэлцтэл энэ хэлэлцэх асуудлыг хойшлуулахыг хүсэж байна. Баярлалаа. Горимын санал гаргаж байна.

Үүнийг дэмжиж өгөөч ээ.

Б.Жавхлан: Дэгийн тухай хуулийн 13.3-аар хуралдаанаар нэг асуудлыг хэлэлцэж эхэлсэн боловч түүний хэлэлцүүлгийг горимын саналаар хойшлуулсан тохиолдолд хуралдаан даргалагч дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ гэсэн ийм заалт, дэгтэй.

Тийм учраас нэгэнт Лувсаннямын Гантөмөр гишүүн горимын санал гаргасан учраас горимын саналын томьёоллоор уг асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулъя гэдэг саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт.

Түр байж байгаарай. Санал хураалтад гишүүд маань эхлээд бэлдэх хэрэгтэй юм байна. Техникийн хувьд ер нь хэдүүлээ ингэж явж байхгүй бол болохгүй юм байна шүү.

Гишүүд санал хураалтад бэлдье.

21-ээс 11 гишүүн бэлэн байна шүү. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

Горимын санал дэмжигдээгүй учраас хэлэлцүүлгээ цааш үргэлжлүүлье.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэх, үг хэлэх гишүүд байна уу?

Л.Гантөмөр гишүүнээр тасаллаа. Аюушийн Ариунзаяа гишүүний микрофоныг нээе.

А.Ариунзаяа: Би Л.Гантөмөр даргатай юун дээр санал нэгдээд байна вэ гэхээр ийм томоохон хуулиудыг зүгээр хувь гишүүд барьж авах нь өөрөө буруу юм.

Яаж ч бодсон ийм асуудлуудыг, нэн ялангуяа сонгуулийн хуулиудыг зөвшилцөл дээр суурилж, намуудын ойлголцол дээр нь тулгуурлаж явахгүй л бол энэ чинь болдоггүй шүү дээ. Тийм ээ.

Гагцхүү энэ удаагийн энэ хууль нь өөрөө цаг хугацаандаа шахагдаад ороод ирэв үү? Энэ чинь 6 сарын 01-нээс өмнө батлах хуулийн өөрчлөлтийг жилийн өмнө өөрчлөлтийг хийх ёстой. Хуулийн хугацаа хязгаартай байдаг шиг санаад байна.

Тэгэхээр иймэрхүү асуудлуудаа бас улс төрийн намууд ч гэсэн, даргын дэргэдэх зөвлөл дээр ч гэсэн бүх намын дарга нар өөрсдөө орж байгаа учраас энэ мэтийн хуулиудаа эртхэн шиг харж. Мөн түүнчлэн зөвхөн Улсын Их Хуралд суудалтай намууд гэлтгүй бусад улс төрийн намуудаа оролцуулсан зөвшилцлийн уулзалтуудыг ч гэсэн хийдэг шүү дээ.

Энэ агуулгаараа томоохон хуулиудаа марталгүй зөвшилцлийн хэлбэрээрээ явуулах нь зүйтэй гэсэн зарчмын суурь байр суурьтай байгаа.

Тэгээд нэгэнтээ цаг хугацаа ийм болсон юм одоо тэгээд энэ хуулийг дэмжээд явахаас өөр аргагүй, хэлэлцээд явсан нь зүйтэй байх гэсэн байр суурьтай байгаа.

Тэгэхээр бусад улс төрийн намууд чуулган дээр болон бусад агуулгаараа хэлэлцээд явна биз ээ. Тийм.

Б.Жавхлан: Үг хэлж дууслаа. Сархадын Зулпхар гишүүн үг хэлье. Микрофоныг нээнэ үү.

С.Зулпхар: Эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Төрийн байгууллагатай холбоотой, улс төрийн намтай холбоотой, улс төрийн сонгуультай холбоотой хууль өөрөө засаглалын маш чухал чимхлүүр чухал хуулиуд. Энэ чинь өөрөө цаана ард түмний засаглах эрхтэй холбоотой асуудлыг тал талаасаа консенсус хийж байж ордог ийм л үйл явц шүү дээ.

Тэгэхээр би Гантөмөр даргын саналтай санал нэг байна. Манай бүлэг дээр яригдсан. Яах вэ, бид дэмжсэн. Гэхдээ дэмжих явцдаа ярьсан. Энэ хуулийг бид хэрвээ баталдаг юм гэхэд, хэлэлцдэг юм гэхэд хэрэгжүүлэх боломж байгаа юу? Цаг хугацааны хувьд. Техникийн боломж бий юу гэдэг асуудал байгаа юм.

Хэрвээ техникийн боломж нь хязгаарлагдмал байх юм бол түүнээс гарч болох үр дагаврыг бид хэлэлцэж чадахгүй гэсэн үг. Янз янзын сонгуулийн маргаан үүсэж болзошгүй. Түүнийг дагалдсан улс төрийн нөхцөл байдлууд үүсэж болзошгүй учраас иймэрхүү хуулийг. Яг одоо энэ хуулийг шүү дээ.

Улс төрийн намуудын консенсус дээр тулгуурласан байдлаар оруулж ирэх нь зөв байх гэж бодож байна.

Мэдээж хэрэг Улсын Их Хурлын гишүүдийн хууль санаачлах эрх байх нь эргэлзээгүй. Гэхдээ улс төрийн нам өөрөө энэ институцүүдийг хангадагийн хувьд энэ дээр бас тодорхой байр сууриудаа нэгтгэж байж ярилцах нь зөв байх.

Одоо бид эндээс сая санал хураагаад уншлаа шүү дээ.

Чуулган дээр мэдээж хэрэг Ардчилсан намын бүлгээс санал гаргаад энэ асуудлаа яах тухай өөрсдөө хэлэлцсэн нь зөв байх гэж бодож байна.

Б.Жавхлан: Баярлалаа. Лувсаннямын Гантөмөр гишүүн үг хэлнэ. Микрофоныг нээе.

Л.Гантөмөр: Энэ хуулийг дэмжиж болохгүй.

Гадаадад оршин сууж байгаа хүмүүсийг санал өгүүлэх халхавчаар Монголын дотоодын тролл арми бий болгох хуулийг Д.Бум-Очир оруулж ирсэн байна.

Чи сайн хүний үр сад. Ийм заваан юманд оролцож болохгүй. Нэр хүндээ бод.

Яг энэ дотоодын тролл чинь. За байз энэ Их Хурлын дарга С.Бямбацогттой хариуцлага тооцохгүй бол хажуугаас үг хэлүүлэхгүй байна. Зэрэгцэж яриад үг хэлүүлэхгүй байна.

Тэгэхдээ энэ байна шүү дээ. Энэ бол тоглоом биш. Одоо Б.Энхбаяр сайд Хууль зүйн сайд хийж байсан хүн маш нарийн мэдэж байгаа.

Энд тэнд баахан хүн очоод санал өгөөд эхэлнэ. Яг Их Хурлын сонгуулийн хууль чинь ийм болно. Тэгнэ. Байгаа газраа санал өгнө гэж байгаа байхгүй юу. Биш биш.

Одоо та бид хоёр дуртай газраа явж байгаад саналаа өгч болно гэж байгаа байхгүй юу. Биш ээ. Үгүй Монголд. Одоо хоёулаа Дорнодод сонгуулийн ажлаар явж байгаад тэр өдөр саналаа өгч болно гэж байгаа байхгүй юу. Тийм.

Тэгэхээр эрхэм гишүүд ээ. Наадах чинь ингээд хяналтгүй болдог байхгүй юу. Ж.Батжаргал дарга иймэрхүү сонгуулийн асуудлыг маш сайн мэдэж байгаа.

Ер нь Д.Бум-Очир оо, тэр гадаадын иргэдийн эрхийг хамгаалах ажил, дотоодын сонгогчийн чөлөөт дурсгал хоёрыг нэг доор шийдэж чи бол хэрхэвч болохгүй. Би чамайг хамгаалж байна.

Энэ сонгуулийн луйвард гаршсан хүмүүс хийж болно. Ийм хүмүүс чинь тусдаа хүмүүс байдаг юм. Ийм сайхан залуугаар.

Энэ чинь сонгуулийн дараа бөөн хэрүүл болно. Үгүй. 220 мянган хүн хаягийн гадуур санал өгнө. Монгол Улс дотроо шүү. Энэ хүмүүсийн саналаар сонгууль шийдэгдэнэ. Үүний дараа бөөн бослого, цуглаан болно. Хэн хариуцлага хүлээх юм.

Тийм учраас хэдүүлээ жоохон болгоомжтой хандъя л гэж байгаа юм.

Ер нь Д.Бум-Очир гишүүн цаашаа энэ хуулийг явуулъя гэж байгаа бол та зөвхөн гадаадын хэсгээ би авч гарна, дотоод хэсэг дээр больё гэж больсон нь зөв шүү. Больсон нь зөв шүү. Яагаад 2021 оны сонгуульд хүссэн хүн болгон хүссэн газраа санал өгөөгүй вэ?

Үүнийг л бүгдээрээ бодох хэрэгтэй. Барилдах дүрмээ сонгууль болгоноор сольдог байдлыг бид болих хэрэгтэй.

2021 онд Монгол Ардын нам ямар дүрмээр барилдаж ялсан, 2027 онд яг тэр дүрмээрээ барилдацгаа. Одоо та нар сонгуулийг дээрэмдэж авах гэж байна шүү дээ. Болдоггүй юм. Үүнийг л төрийн эргэлт гэдэг юм. Тоглоом биш шүү Ж.Батжаргал дарга аа.

Б.Жавхлан: Хууль санаачлагч Д.Бум-Очирын микрофоныг нээе.

Д.Бум-Очир: Л.Гантөмөр гишүүн уучлаарай.

Та бас арай ингэж хэлж болохгүй ээ. Тролл яах гэж байна, юу юу гэнэ вэ. Арай бас ингэж хэлж болохгүй. Яах вэ, нөгөө талдаа та намайг бодож байгаад чинь би талархаж байна. Тодорхой хэмжээгээр шинэ гишүүн, залуу гишүүн гээд үнэлж байгаад талархалтай байна. Гэхдээ нөгөө талаас асуудлыг ингэж их мушгин гуйвуулж болохгүй ээ.

Ямар тролл, яасан яасан. Одоо сая олон хүн сонслоо. Тийм юм байхгүй гэдгийг би хариуцлагатайгаар мэдэгдье.

Нөгөө талдаа та бас энэ асуудлыг мэддэг, мэддэггүй гэж гишүүдийг ялгаварлаж болохгүй шүү дээ.

Үүнийгээ мэддэг туршлагатай гишүүн, туршлагагүй гишүүн гэх шиг. Энэ дотор олон гишүүд байгаа. Яах вэ, би анх сонсогдож байгаа. Туршлага багатай байхыг үгүйсгэхгүй. Тэгэхдээ энэ жил гаруй. Би эхлээд яриад дуусгая.

Тийм учраас энэ сонгуулийг луйвардах гэж байна гэсэн ингэж мушгиж болохгүй гэдгийг би танд хэлмээр байна. Ийм санаа агуулга байхгүй. Надад тэгэх хэмжээний ёс зүй, тийм итгэл үнэмшил байхгүй. Би тэгж сонгууль луйварддаг. Магадгүй та болоод тань шиг олон жил олон удаа сонгогдоод, олон олон сонгуулийг луйвардсан улсууд байдаг байхыг үгүйсгэхгүй.

Би тэрийг чинь нэгийг нь ч мэдэхгүй. Та тэгээд үүнийг нэг их Ардын нам руу оруулаад л, иймэрхүү байдлаар улс төржүүлээд явж болохгүй. Нийт сонгогчдын 10 орчим хувь нь буюу 240 орчим мянган иргэн сонгуульд Үндсэн хуулиараа олгогдсон эрхийн дагуу саналаа өгөх эрх нь хязгаарлагдмал нөхцөл байдал үүссэн байгааг Хүний эрхийн Үндэсний Комисс ч илтгэлдээ дурдсан. Их Хурлын 77 дугаар тогтоол дээр гараад ирсэн.

Бид Их Хурлын тогтоолыг биелүүлэхийн тулд гүйцэтгэхийн тулд өөрсдөдөө олгогдсон эрх, үүргийн дагуу энэ хуулийг оруулж ирж байгаа.

Сонгууль өгөх насны нийт сонгогчдын 10 хувь гэдэг бол их тоо. Бид энэ иргэдийнхээ Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь төр нээж өгөх ёстой, боломжийг нь олгож өгөх ёстой. Тэр мэдээж хариуцсан байгууллага нь. Үүнийг хариуцсан байгууллагууд нь хариулах ёстой. Би хариулах чиг үүргийн хүн нь биш. Би 2021 онд юу болсныг би мэдэхгүй.

240 мянган хүн гэдэг дотор ийм байгаа юм.

- ➔ 46 мянган төрийн албан хаагч байгаа. Энэ хүмүүс томилолтоор орон нутагт сонгуулийн санал авах байруудад ажилладаг.
- ➔ 56 мянга нь уртын ээлжид ажиллаж байгаа залуучууд байгаа.
- ➔ 20 мянга нь хотод байдаг. Орон нутагт буцаж очиж саналаа өгөх боломжгүй 20 мянган оюутан байгаа.

Яг надад өгсөн тоон мэдээгээр гадаадад байгаа 120 мянга гэсэн ийм тоо бий.

Ингээд нийлээд үндсэндээ 240 орчим мянган хүн. Энэ хүмүүс бидэнд сонгуулиа өгөх бололцоо нээгдэхгүй байна гэдэг зүйлийг ярьсан.

Миний ойлгосноор, надад ирсэн мэдээллээр 2021 оноос хойш технологийн дэвшлүүд гарсан гэж би ойлгож байгаа. Энэ боломжуудаа ашиглаад. Энэ иргэний бүртгэлийг блокчэйн болгох ажил Л.Гантөмөр гишүүн ээ, миний ажил үүрэг биш. Чи гээд байх юм. Тэгвэл та хий л дээ.

Иргэний бүртгэлээ блокчэйн болгох ажил тийм чухал гэж та үзэж байгаа бол, тэрийг илүү их мэдэж байгаа, мэдээлэлтэй байгаа бол та ч гэсэн 126 гишүүний ялгаагүй нэг л гишүүн. Энэ санаа зовж байгаа асуудлаа хариуцаад барьж аваад тэгвэл та тэрийгээ санаачил л даа.

Түүнээс биш хүний санаачилж орж ирж байгаа хуулийг ингэж янз бүрийн үндэслэлгүйгээр тролл арми энэ тэр, юу юу гэнэ вэ, сонгууль луйвардах гэж байна гэж ингэж хүнийг мушгин гуйвуулж болохгүй шүү дээ.

Та танд ямар үндэслэл байгаа юм? Мушгин гуйвуулж хүнийг ингэж гүтгэж байх.

Б.Жавхлан: Хууль санаачлагч тайлбар хэлж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд анхаарал тавья. Санал хураалтад бэлтгэе гишүүд. Зааланд сууж байгаа гишүүд ирцдээ орно уу. Б.Баярбаатар гишүүн ороорой. А.Ариунзаяа гишүүн ороорой. Ж.Баярмаа гишүүн ирцдээ ороорой. С.Зулпхар гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Б.Энхбаяр гишүүн, Ж.Батжаргал гишүүн, Д.Энхтуяа гишүүн, Ж.Бат-Эрдэнэ дарга санал хураалтын ирцдээ орсон уу.

Ч.Ундрам гишүүн зааланд ирж санал хураалтдаа орно уу? Өөр хэн байна? Ж.Баярмаа гишүүн ээ, санал хураалтад бэлдэнэ үү. Байхгүй гишүүдээ дууд Б.Хатантуул.

Хууль санаачлагч Ж.Баярмаа гишүүн санал хураалтынхаа ирцэд орно уу.

Д.Энхтуяа гишүүн санал хураалтын ирцэндээ орно уу. Ороогүй байна. Ч.Ундрам гишүүн орж ирж санал хураалтад оролцоорой. Т.Доржханд гишүүн орж ирлээ. Ирцдээ ороод санал хураалтад бэлдэнэ үү.

Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалтын ирц бэлэн боллоо.

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 47.6 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Хамт өргөн мэдүүлсэн Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 38.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийн чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа гишүүн танилцуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

Зургаа.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд
нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг
сонгох тухай/

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4.2 дахь хэсэгт хорооны гишүүний 5-ыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, 2-ыг Монгол Улсын Ерөнхийлөгч, 2-ыг Улсын Дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилно гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30.1.1 дэх заалтад Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсголыг хийхээр тус тус заасан байдаг.

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайханыг Улсын Их Хурлын 2025 оны 6 сарын 25-ны өдрийн 47 дугаар тогтоолоор үүрэгт ажлаас чөлөөлсөнтэй холбогдуулан тус газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваанямыг, мөн Цагдаагийн ерөнхий газрын дарга асан Т.Сүхболд чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасантай холбогдуулан тус газрын дарга Ж.Болд нарыг тус тус Төрийн байгуулалтын байнгын хорооноос санал болгох, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосон Г.Байгальмаагийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2026 оны 04 сарын 01-ний өдрийн Е/07 дугаартай албан бичгээр Д.Ариунболдыг санал болгосон.

Улсын Дээд шүүхээс санал болгосон Сонгуулийн ерөнхий хорооны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Улсын Дээд шүүхийн 2026 оны 05 сарын 19-ний өдрийн 01/1825 дугаартай албан бичгээр Д.Мөнхзоригийг санал болгож ирүүлсэн тул “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг боловсруулсан.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос **ТОГТООХ** нь.

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч Дашчиваагийн Ариунболд, Жамсранжавын Болд, Довдойн Дамдинням, Доржсүрэнгийн Мөнхзориг нартай хийх нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Сонгуулийн ерөнхий хорооны нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Болдын Жавхланг сонгосугай.

3.Нэр дэвшигчийн сонсголын зарыг нийтэд мэдээлж, бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль, журамд заасны дагуу зохион байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасугай.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан гэсэн ийм тогтоол байна.

Байнгын хорооны дотоод тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж үг, хэлж дууслаа. /алх цохив/

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд анхааралтай байгаарай. Ирц муудаад байна шүү.

“Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжих нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураая. /алх цохив/

Санал хураалтад 21 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж, санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ. /алх цохив/

Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанд идэвхтэй оролцсон Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүддээ талархал илэрхийлье. Сайхан амарцгаагаарай.

Хуралдаан 3 цаг 30 минут үргэлжилж, 17 цаг 30 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД